

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ,
СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ**

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

№ 1

**Улаанбаатар хот
2003 он**

ЭРХЭМ УНШИГЧ ТАНАА

Эрхэм уншигч таны амар амгаланг айлтган мэндчилж байна.

Энэхүү шинэ сэтгүүлийн анхны дугаар нь Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв /ХЗҮТ/-өөс эрхлэн гаргаж байгаа хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн улирал тутмын хэвлэл юм.

Сэтгүүлээ бид шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах нийт байгууллагын ажилтан, төрийн болон төрийн бус байгууллага /иргэний нийгмийн ба бизнесийн байгууллага /-ын хуулийн зөвлөх, эрдэмтэн судлаач, хууль зүйн их, дээд сургуулийн багш, оюутанд зориулж байна.

Эрх зүйт төрийг төлөвшүүлэн хөгжүүлэх хүнд хэцүү боловч гүнээ хүндтэй үйлсэд хүч хөдөлмөр оюун бодлоо зориулж буй судлаач эрдэмтэд, хуульч хэн бүхэнтэй хамтран ажиллаж, Таны бүтээл туурвилыг дараахь тогтмол буландаа нийтлэхэд бид бэлэн байна. Үүнд:

- Үндсэн хууль ба Төрийн байгуулалтын хууль тогтоомж,
- Иргэний хууль тогтоомж,
- Олон улсын эрх зүй,
- Криминологи
- Үндсэн хуулийн хяналт,
- Шүүх эрх мэдэл,
- Прокурорын хяналт,
- Эрх зүйн үйлчилгээ, хууль зүйн зөвлөгөө /өмгөөлөл, нотариат/.

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлээр Таны оюуны мэлмий гэгээрч, хууль зүйн мэдлэг тань тэлж, мэдээлэл арвижих болтугай гэж срөөгөөд тогтмол хэвлэлийн Таны захиалгад манай сэтгүүл багтсан гэдэгт итгэж буйгаа илэрхийлэн талархалаа дэвшүүлье!

СЭТГҮҮЛИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨЛ

СЭТГҮҮЛИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Ц.Бат-Орших	- Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч
А.Доржготов	- Улсын Дээд Шүүхийн шүүгч
Н.Ганбаяр	- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Ж.Амарсанаа	- Хууль зүйн үндэсний төвийн захирал
Ж.Энхнасан	- Хууль зүйн үндэсний төвийн Захиргааны хэлтсийн дарга
Т.Мэндсайхан	- Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн Цэцийн ажилтан
П.Цэцгээ	- Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвийн захирал
Б.Балган	- ХЗДХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга
А.Энхжав	- Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн дарга
Ж.Сайнжаргал	- ЦЕГ-ын Тамгын газрын дарга
Б.Пүрэвням	- Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч
А.Оюунчимэг	- Монголын Нотариатчдын танхимын ерөнхийлөгч
Г.Сумъяа	- Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

ЭНЭ ДУГААРТ:

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- Үндсэн хуулийн хяналтын механизм 7
(*Үндсэн хуулийн Цэцийн ажилтан Э.Лхагвасүрэн*)

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

- Хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх арга зам 14
(*Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Ж.Дашдорж*)
- Зохистой захиргааны ерөнхий зарчим 20
(*Голландын төрийн захиргааны туршлагаас*
(*Филипп М.Лэнгброк, орчуулсан С.Гэрэлмаа*)
(*ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрхлэгч*)

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

- Газрын эзэн, эрх зүйн асуудал 34
(*Монгол Улсын их сургуулийн тэргүүлэх профессор, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Т.Сэнгэдорж*)
- Оюуны өмчийн түүхэн хөгжлийн тойм 38
(*ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч, дэд профессор, докторант Д.Цолмон*)

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

- Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээрийн тухай 46
(*ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч, докторант Б.Отгонбаяр*)
- Олон улсын харилцаа-Ази, Номхон далайн орнуудын хэтийн төлөв, Монгол Улсын эзлэх байр суурь 52
(*Хууль зүйн магистр Ш. Үнэнтөгс*)

КРИМИНОЛОГИ

- Авлигын эсрэг: тэмцэл түүнийг боловсронгуй болгох нь 62
(*ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч, доктор, профессор Д.Зүмбэрэлхам*)
- Мансууруулах бодис ба хууль бус үйл ажиллагаа 68
(*Монгол Улсаас БНКазУлсад суугаа ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, доктор О.Пунцагдаш*)

ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫН МЕХАНИЗМ

Үндсэн хуулийн Цэцийн ажилтан Э.Лхагвасүрэн

Үндсэн хуулийн хяналтын тухай

Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны нэг биеэ даасан институт нь Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийг эрх зүйн зохицуулалтаар хамгаалах асуудал бөгөөд Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд ч Үндсэн хуулийн шүүх онцгой байр эзэлдэг.

Улс гүрэн бүр өөрийн Үндсэн хуулийг боловсруулж батлах нь чухал боловч түүнийг хэрэгжүүлж мөрдөн сахиж хамгаалах нь бодит Үндсэн хуультай байх үндсэн баталгаа болдог. Өөрөөр хэлбэл батлагдсан Үндсэн хуулийг зөрчөөд эхлбэл хэлбэрийн төдий Үндсэн хуультай болж Үндсэн хууль үйлчлэх баталгаагүй болдог. Гавъяат хуульч Г.Совд гуай Үндсэн хуулийн төрөлжсөн шүүхгүй аливаа Үндсэн хууль бол шүдгүй арслан мэтээр зүйрлэж хэлсэн нь санаандгүй хэлсэн зүйл огт биш. Үндсэн хууль тунхаг биш, Үндсэн хууль хоосон амлалт ч биш гагцхүү түүний заалт бүр баталгаатай хэрэгжих бодит механизмыг бүрдүүлсэн байх нь юунаас чухал.

Дэлхийн түүхэнд Үндсэн хуулийн үзэл санааг гуйвуулан тайлбарлахаас эхлээд эрх мэдэл бүхий субъектүүд түүний тодорхой заалтыг буруу хэрэглэж гажуудуулах, заримдаа улс төрийн тодорхой хүчний явцуу сонирхолдоо тохируулан ашиглахыг оролдох хүртэл илрэлүүд үзэгдсээр ирсэн. Ийм учраас үндсэн хууль батлан гаргахдаа түүнийг хангах баталгааг юуны өмнө улс төр, хууль зүйн баталгааг нэгэн зэрэг бодолцон тогтоодог явдал юм. Энэ бол эрх зүйт

төрт улс орнуудын нийтлэг жишиг билээ.

Төр-эрх зүйн харилцаанд оролцож буй зарим субъект ялангуяа, улс төрчид өөрийн зорилгодоо хүрэхийн тулд хууль зөрчигдөж буй эсэхэд санаа бага тавьдаг бөгөөд тэр тусмаа Үндсэн хуулийн хязгаарлалтыг тэр бүр анхаарч сахдаггүй. Иймээс эрх зүйн зохицуулалтаар /хуульчилж/ Үндсэн хуулийг хамгаалах ёс аль XVII зууны үеэс бий болжээ.

Монгол Улс ч 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа боловсруулж батлахдаа уул жишгийг харгалзан үзэж өөрийн орны онцлогт тохируулан Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог тодорхойлсон билээ.

Хэдийгээр Үндсэн хуулийг сахин биелүүлж байгаад хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагууд болон эрх бүхий албан тушаалтнууд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлж түүнийг хамгаалдаг хэдий ч зарим тохиолдолд тэд ч Үндсэн хуулийг зөрчих явдал байдаг.

Иймд Үндсэн хуулийн биелэлтэд хууль зүйн хувьд мэргэжлийн үүднээс хянаж зөрчил маргааныг эцэслэн шийдвэрлэдэг тийм баталгааг тогтоосон байх нь юунаас ч чухал ба хэнээс ч хараат бус, зөвхөн Үндсэн хуульд захирагдаж, тухайн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэдэг шүүхийн хяналт юм. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь дэлхийн ихэнх улс оронд ямар нэг

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

хэлбэрээр хэрэгжиж байна. Мөн Үндсэн хуулийн хяналтын байгууллагын эсрэг байр суурьтай хүмүүс ч байдаг. Тэд парламентаас баталсан хуулийг хяналтын төрөлжсөн байгууллага болох шүүх хүчингүй болгож байгаа нь хууль тогтоох эрх хэмжээнд халдах, цаашлаад парламентыг дээдлэх зарчим алдагдаж байна гэдэг үндэслэлийг голлон тавьдаг. Үүнтэй холбогдуулан Япон, Югославын Үндсэн хуульд тусгагдсан заалтыг сонирхож болно.

Японд аливаа нэг хуулийг Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл шүүх байгууллага энэ тухай бүх мэдээллээ парламентад өгнө. Энэ нь хуулийг хэрэглэх явцад гарсан зөрчлийг авч хэлэлцэн, тухайн хуулийг эргэн хянах боломжийг парламентын гишүүдэд олгодог юм. Тэгвэл Югославт хэрвээ Үндсэн хуулийн шүүх нь ямарваа нэг хуулийг Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл Парламентад оруулж, улмаар парламентын гишүүд түүнийг 6 сарын хугацаанд дахин хэрлэлцэх ёстой. Хэрвээ хуулийн хугацаанд уг хуулийг Үндсэн хуультай нийцүүлж чадаагүй бол холбогдох хууль тогтоомж түүний тодорхой заалт хүчин төгөлдөр бус болдог байна.

Үндсэн хуулийн хяналтын загвар
Дэлхийн улс орнуудад аливаа хууль Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхэд хоёр аргаар хяналт тавьдаг байна. Энэ нь урьдчилсан /предварительный контроль/, ба дараачийн хяналтын /последующий контроль/ арга юм.

Хуулийн төслийг парламентаар хэлэлцэж байхад болон түүнийг батлагдсаны дараа гэхдээ хүчин төгөлдөр болохоос нь өмнө урьчилан хяналт тавих гэдэг нь уг хуулийн төслийг хууль тогтоох процессийн

хүрээгээс гадуур хэлэлцэнэ гэсэн үг учраас боломжгүй зүйл. Гэхдээ дэлхийн олон оронд тухайлбал Бельги, Нидерландад урьдчилсан хяналтын үүргийг парламент, Финландад парламентын үндсэн хуулийн эрхийн асуудлаархи хороо, Бразилд Конгрессийн Үндсэн хуулийн болон шүүн таслах ажиллагааны асуудлаархи хороо хэрэгжүүдэг. Үндсэн хуульд урьдчилсан хяналт тавих буюу өөрөөр хэлбэл хуулийн төслийг Үндсэн хуульд нийцүүлэх үүргийг парламентад зөвлөх, тус дөхөм үзүүлэх үүрэг бүхий байгууллага, шүүх гүйцэтгэдэг. Ийм үүргийг Бельгид Төрийн зөвлөл, Камерун, Конгод дээд шүүх нь хэрэгжүүлдэг.

Парламентын сайшаасан хуулийн төслийг Үндсэн хуульд нийцээгүй болохыг зарлах эрх бий болох нь Үндсэн хуульд урьчилсан хяналт тавих өөр нэг хэлбэр юм. Үүний сонгомол жишээ нь Францын Үндсэн хуулийн зөвлөл. Тэрээр органик хууль болон Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, танхимуудын дарга нар, танхимуудын 60 гишүүний хянуулахаар хүсэлт тавьсан хуулийн төслийг соёрхон батлахаас нь өмнө тэдгээр нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянах ба урьчилсан хяналтын арга нь хууль тогтоох процесстэй нягт уялдаатай төдийгүй парламентын гишүүд аливаа хуулийн төслийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай хэлэлцэх, мөн энэ тухай эрх бүхий байгууллагад асуудлыг дэвшүүлэн тавих явдал юм.

Үндсэн хуулийн дараачийн хяналтад хууль батлагдаж, хүчин төгөлдөр болсноос хойш хийгдэх хяналтыг ойлгох ба ихэвчлэн шүүх байгууллага түүнийг хэрэгжүүлдэг. АНУ, Канад, Австрали, Энэтхэг, Дани, Норвег зэрэг оронд дотоодын хууль тогтоомж Үндсэн хуультай нийцэхгүй зөрчилдөж байвал түүнийг хэрэглэхээс

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

- Прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэх зарим асуудал 73
(Улсын ерөнхий прокурорын орлогч,
Төрийн хууль цаазын шадар зөвлөх Б.Цэрэмбалтав)

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Өмгөөллийн нууцын тухай (Өмгөөлөгч Б.Эрдэнэцогт) 77
- Нотариатч ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ? (И.Гебхардт) 78

ДУГААРЫН ЗОЧИН

- Үндсэн хуулийн Цэц хуулийг үндэслэж 80
шүүхийн аргаар шийдвэр гаргадаг
(Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор,
Монгол Улсын гавъяат хуульч Г.Совд)

ШИНЭ НОМ, СОНИН, СЭТГҮҮЛ 85

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

татгалзах шийдвэрийг шүүн таслах эрх бүхий байгууллага буюу Дээд шүүх гаргадаг бол Австри, ХБНГУ, Итали, ОХУ, Унгар зэрэг улсад Үндсэн хуулийн шүүх гүйцэтгэдэг.

Үндсэн хуулийн хяналтыг анх бий болсон түүхээс нь авч үзвэл дараахь 3 үндсэн загварт хувааж болно. Үүнд:

а) Ердийн шүүхийн буюу АНУ-ын загвар;

б) Дагнасан шүүхийн буюу Австрийн загвар;

в) Зөвлөлийн буюу Францын загвар.

Эхний хэлбэрийн үед тухайн маргаантай асуудлыг хараат бус бие даасан зарчмаар авч хэлэлцэн эцсийн шийдвэр гаргадаг. Анх 1803 онд АНУ-ын дээд шүүхийн дарга Жон Маршал Ж.Медисоны эсрэг У.Мерберийн хэргийг шийдвэрлэхдээ “Холбооны Үндсэн хууль бол Конгрессийн ямар ч хуулиас дээд хүчинтэй. Үндсэн хуульд нийцээгүй хууль хүчин төгөлдөр бус байна” гэж зарласнаар Үндсэн хуулийн биелэлтэд тавих дээд хяналтыг шүүхийн харьяалалд анх оруулжээ. Энэ загварын шүүх Америк тивийн ихэнх орнууд, Австрали, Шинэ Зеланд, мөн Норвег, Швед зэрэг европын зарим оронд, Япон, Энэтхэг, Иран зэрэг азийн орнуудад Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэдэг тусгай биеэ даасан шүүх байхгүй гэсэн үг.

Үндсэн хуулийн шүүхийн 2 дахь загварыг Австрийн Үндсэн хуулийг боловсруулалцсан хуульч Ханс Келсэн 1920 онд Үндсэн хуулийн хяналтыг эрхэлдэг мэргэжлийн бөгөөд тусгай төрөлжсөн Үндсэн хуулийн шүүхийг байгуулахаар тусгасан байдаг. Энэ бол зөвхөн Үндсэн хуулийн хяналтыг тусгайлан эрхэлж, дээд шүүхээс тусдаа биеэ даасан шүүх бий болох эхлэл нь

байв.

ХБНГУ 1951 онд Үндсэн хуулийн шүүхээ байгуулахдаа дээрх загварыг улам боловсронгуй болгон хуульчилсан нь Үндсэн хуульд мэргэжлийн хяналт тавьдаг Үндсэн хуулийн шүүхийг байгуулах онолын бөгөөд практикийн асуудлыг үлэмж боловсронгуй болгон төгөлдөржүүлж дэлхий нийтийн нийтлэг хандлагад тохируулах талаар томоохон алхам болсон.

3 дахь хэлбэр болох Францын загвар буюу зөвлөлийн гол хандлага нь хууль болон бусад актыг батлагдахаас нь өмнөх шатанд урьчилсан хяналт тавьдаг. Үндсэн хуулийн хяналтын энэ загвар хэрэглээний хувьд хязгаарлагдмал төдийгүй хүчин төгөлдөр болсон хууль тогтоомжид үйлчилдэггүй онцлогтой.

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэхэд жишиг тогтоох эрх зүй /прецедентное право/ чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл шүүгчид аливаа маргааныг шийдвэрлэхдээ уг маргаантай асуудлаар урьд нь гарсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг дагах нөгөөтэйгүүр Үндсэн хуультай зөрчилдөж байгаа хууль нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бус байх ёстой. Ийм практик АНУ, Канад, Австрали, Энэтхэг мөн Дани, Норвеги, Грек зэрэг баруун европын олон оронд тогтсон байдаг. Жишиг тогтоох эрх зүй үгүй оронд шүүгчид нэг хэргээр урьд нь гаргаж байсан шийдвэрийг үл харгалзан өөрсдийн шийдвэрийг гаргадаг тул тухайн хууль нь Үндсэн хуульд нийцэж байна, эсхүл нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг янз бүрийн шүүхүүд нэгэн зэрэг гаргах ч тохиолдол байхыг үгүйсгэхгүй.

Дээрх жишиг Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд ч тусгалаа олсон байдаг. Өөрөөр хэлбэл тухайн маргааны талаар өмнө нь гаргасан

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

Цэцийн шийдвэр хүчинтэй байгаа тохиолдолд дахин тэрхүү асуудлаар Цэцэд маргаан үүсгэх нөхцлийг хуулиар хязгаарласан байдаг.

Үндсэн хуулийн Цэцийн шүүх болох шалгуур

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн хяналтын 2 дахь загварыг жишиг болгож гэхдээ өөрийн улсын онцлог, түүх уламжлалд тохируулан Үндсэн хуулийн Цэц /БНСУ, Франц, Итали, Ази, Европ, Латин америкийн нэлээд оронд Үндсэн хуулийн дагнасан шүүхийн хяналтыг хэрэгжүүлдэг байгууллага нь "Үндсэн хуулийн шүүх" гэхээс гадна "Зөвлөл", "Жюри", "Требунал" гэх мэт заавал шүүх гэхгүй оноосон нэртэй байдаг/ нэртэйгээр Үндсэн хуульд "Шүүх эрх мэдэл" гэсэн 3 дугаар бүлгээс тусад нь 5 дугаар бүлэгт хуульчилсан нь эргээд Цэц шүүх мөн биш гэсэн маргаан өнөөг хүртэл мэр сэр гарсаар л байна.

Анх Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс "Монгол Улсад шүүх эрх мэдлийг УДШ, аймаг, нийслэлийн болон бүс нутгийн шүүх, мөн Үндсэн хуулийн Цэц хэрэгжүүлнэ" гэж Цэцийн тухай асуудлыг шүүх эрх мэдлийн хэсэгт тодорхойлж байсан боловч тухайн үед төрийн тогтолцоонд цоо шинээр бий болсон хяналтын институтэд хязгааргүй эрх хэмжээ олгогдох гэж байгаа мэтээр учрыг үл ухан, хий болгоомжлон маргасаар тус хэсгээс хасч бие даасан буюу 5 дугаар бүлэгт "шилжүүлсэн" түүхтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд "Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан

сахиулах баталгаа мөн" гэж заасан байдаг.

Товчхондоо Үндсэн хуулийн цэц нь:

-Үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлдэг,

-Үндсэн хуулийн заалт зөрчсөн талаар дүгнэлт гаргах,

-Маргааныг магадлан шийдвэрлэж заавал биелэх хүчинтэй эцсийн шийдвэр гаргадаг зэргээр түүний шүүх болох шалгуур, онцлогийг илэрхийлж болно.

Үндсэн хуулийн цэцийн хяналтын зүйл нь зөвхөн Үндсэн хууль байдаг. Бусад органик хуулийн биелэлтэд хяналт тавьдаггүй. Нөгөөтэйгүүр Цэцийн хяналтад байдаг субъектүүд хуулийн биелэлтэд хяналт тавьдаг бусад байгууллагад тэр бүр харьяалагдахгүй. Өөрөөр хэлбэл төрийн дээд байгууллага, тэдгээрийн албан тушаалтнууд байдаг.

Цэцийн хяналтын объект ч хуулиар нарийн заагдсан ба бусад ердийн шүүхэд харьяалагдахгүй онцлогтой. Мөн Цэцийн шийдвэр хууль зүйн хүчин чадлын хувьд заавал биелэгдэх, эцсийн бөгөөд давж заалдах эрхгүй байдаг. Өөрөөр хэлбэл Цэц тодорхой асуудлыг хянан хэлэлцэж эцсийн шийдвэр гаргаж, түүний дагуу Үндсэн хуульд харшилсан хууль тогтоомж нь хүчингүй болж байгаа нь Цэцийн шийдвэр хуулийн адил хүчин төгөлдөр гэсэн үг. Гэхдээ Цэцийн шийдвэр хуулийг хэрэглэж байгаа бүх субъектүүдэд хүрч, мөн хуулийн өөрчлөлтүүдэд тусгагдаж байх систем манай улсын хувьд хараахан төлөвшөөгүй байгааг энд онцолж тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай Монгол Улсын хуулийн 10

дугаар зүйлийн 4 дэх заалтыг Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 1 дүгээр тогтоолоор хүчингүй болгосоор байтал энэхүү заалтыг баримтлан зарим аймаг сумын Засаг дарга нар холбогдох шийдвэрийг мэр сэр гаргасаар байна.

Үндсэн хуульт ёсонд төрийн байгууллагуудыг олон нийтийн зүгээс шууд хянах механизм нь тэдгээрийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэр Үндсэн хуулийг зөрчиж буй эсэх асуудлаар иргэн гомдол гаргах эрх юм. Цэц ч энэ үүргээ биелүүлэхдээ хуульд заасан тодорхой албан тушаалтнуудын хүсэлт, иргэдийн өргөдөл, мэдээлэл, гомдлыг үндэслэн хяналтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

ХБНГУ-д Мюнхений их сургуулийн багш доктор, профессор Х.Шоллер Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хуулиар олгогдсон дараахь үндсэн зарчмууд байдаг тухай дурдсан байдаг.

1. Үндсэн хуулийн шүүх нь зарим үед төрийн дээд байгууллагын үүргийг гүйцэтгэдэг шүүх эрх мэдлийн байгууллага болтлоо хөгжжээ.

2. Үндсэн хуулийн шүүх нь шүүх эрх мэдэлд хамаарах ба энэ нь Үндсэн хуулиар баталгаажсан нөхцөлд төрийн эрх мэдэл хуваарилах зарчим зөрчигдөхгүй.

3. Үндсэн хуулийн шүүх нь бусад шүүхийг бодвол эрх зүй болон улс төрийн хооронд үүсдэг зөрчлийн гол цөмд оршдог.

4. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарт шүүхийн болон шүүгчийн хараат бус байдлын зарчмууд үйлчилдэг.

Үндсэн хуулийн Цэцийн хувьд дээрх зарчмууд бүгд тусгалаа олсон гэх бүрэн үндэслэлтэй. Тухайлбал Цэцийн маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаа шүүхийн зарчмаар явагддаг

төдийгүй шүүх байгууллагын шинжийг бүхэлд нь агуулсан, ердийн шүүх хуулийг хэрэглэж шийдвэр гаргадаг бол Цэц Үндсэн хуулийн маргаантай асуудлаар Үндсэн хуулийг хэрэглэж эцсийн шийдвэр гаргадаг. Мөн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг ч оролцогоороо Үндсэн хуулийн шинж чанартай байгууллага болон төлөвшиж дэлхийн Үндсэн хуулийн шүүхийн жишигт ойртож байна.

Цэцийн маргааны харьяалалд хамаарах объект, субъектийн хүрээг дүгнэхэд Цэц эрх зүйн болоод улс төрийн нарийн ээдрээтэй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг нь тодорхой юм. Энэ ч утгаараа Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Цэцийн гишүүнд томилогдох хүнд ердийн шүүхийн шүүгчээс илүүтэйгээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй байна гэсэн “болзлыг” хуульчилсан болно.

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн Цэцийн маргааны харьяалал, Үндсэн хуулийн Цэцийн хараат бус бие даасан байдлыг хангах болон цаашид цэцийн үйл ажиллагааг эрх зүйн нийтлэг тогтолцоонд хандуулахад бусад орны туршлага, практикаас судлах, хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Үндсэн хуулийн Цэц ба Улсын Их Хурлын харилцааны онцлог болоод эрх зүйн тулгамдсан асуудлууд

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэц хоорондын харилцаанд хуулиар тогтоосон нэг гол онцлог бол Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн маргааныг авч хэлэлцээд эхлээд заавал дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар хуульчилсан явдал.

Аливаа улсын Үндсэн хуулийн шүүх болгон өөрийн онцлогтой бөгөөд

энэ нь Үндсэн хуулийн Цэц бусад улсын Үндсэн хуулийн шүүхээс ялгагдах зарчмын нэг гол ялгаа гэж ч болно. Өнгөрсөн 10 гаруй жилийн практикаас харахад хуулийн дээрх заалт нь эерэг болоод сөрөг үр дагавартай байгааг тэмдэглэх хэрэгтэй. Эерэг талаас нь авч үзвэл УИХ-д өөрийнх нь гаргасан алдааг заавал Цэцийн эцсийн шийдвэр гарахыг хүлээхгүйгээр засах боломжийг олгож байна. Энэ нь Хууль тогтоох дээд байгууллагыг хүндэтгэж байгаагийн нэг илрэл гэж болох талтай.

Нөгөөтэйгүүр Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхгүй хуульд заасан хугацаа хэтрүүлж байгаа байдал нэлээд түгээмэл ажиглагдаж байна. Тухайлбал УИХ Үндсэн хуульд тайлбар хийж байгаа нь Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн Цэцийн 2001 оны 1 дүгээр дүгнэлтийг УИХ өнөөг хүртэл хэлэлцэж шийдвэрлээгүй байна.

Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхгүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь Үндсэн хуулийн хууль дээдлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх тухай Үндсэн хуулийн зарчмууд зөрчигдөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх процесс ажиллагаа тасалдах, парламентад олонх болсон аль нэг намын явцуу эрх ашгаас болж Үндсэн хуулийн үзэл санааг гуйвуулах, улмаар Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх эсэх нь тэдний дур зоргын асуудал болж цаашдаа ийм жишиг тогтож болох ч уршигтай.

Гэхдээ Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж ирсэн практикыг судлахад Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн дүгнэлтийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэх нь тун цөөн харин Үндсэн хууль зөрчсөн байна

гэсэн дүгнэлтийг илүүтэй удааж байгааг ч анхаарууштай.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн харилцааны нэг гол нөхцөл нь Цэцэд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдох явдал. Өөрөөр хэлбэл Цэцийн хуралдаанд томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын байр суурийг хамгаалж эрх, үүргээ ухамсарладаг ч гэлээ зарим тохиолдолд илтэд Үндсэн хууль зөрчсөн хуулийн заалт байсан ч түүнийг ямар нэг байдлаар хамгаалах байдлаар Цэцийн хуралдаанд оролцох талаа ажиглагддаг.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн эцсийн шийдвэрээр хүчингүй болгосон хуулийн заалтыг холбогдох хууль тогтоомжийн заалтад тусгахгүй байх, мөн агуулгаар нь дахин сэргээн батлах явдал өнгөрсөн хугацаанд нэг бус удаа гарч байв.

Тухайлбал Үндсэн хуулийн Цэцийн 2002 оны 1 дүгээр тогтоолоор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн заалтыг хүчингүй болгосон атал Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 50 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дээрх заалттай утга, агуулгын хувьд ижил заалт хүчинтэй хэвээр мөрдөгдөж байгаа тухай; мөн Үндсэн хуулийн Цэцийн 2002 оны 2 дугаар тогтоолоор Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “эрүүлжүүлэх журмыг Улсын Ерөнхий Прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэсэн заалтыг хүчингүй болгосон байхад Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дээрх заалтын агуулгаар дахин баталсан

зэргийг дурдаж болно.

Энэ нь Цэцийн шийдвэрийг хуулийн өөрчлөлтөд тусгаж байх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаатай холбоотой.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанаас гарсан шийдвэрээс шалтгаалж Үндсэн хуулийн Цэц болон

Улсын Их Хурлыг иргэд “ялагч” “ялагдагч”-ын төвшинд ойлгох явдал нийгмийн сэтгэл зүйд нэлээд тархсан ба энэхүү ойлголт огтхон ч байж болохгүй бөгөөд Монгол Улсад эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, эрх зүйт төрийг төлөвшүүлэн тогтоох үйлсэд хамтарч ажиллаж байгаа төрийн эрх бүхий байгууллагууд юм.

* * *

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, шүүхэд
нэхэмжлэл гаргах эрх**

6 дугаар зүйл. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах

6.1.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана.

6.2.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай⁶ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

6.3.Энэ хуулийн 6.1.-д заасан хөөн хэлэлцэх хугацаа зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн нь тогтоогдоол захиргааны байгууллага, албан тушаалтан уг хугацааг хэтэрснээс хойшхи гурван сарын дотор нөхөн сэргээж болно. Хугацаа сэргээхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргана.

6.4.Энэ хуулийн 6.1.-д заасан байгууллага, албан тушаалтан иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

* * *

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ

Хүний эрхийн үндэсний
комиссын гишүүн Ж.Дашдорж

Орчин үед иргэдийн ялангуяа хүүхэд залуучуудын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Энэ нь үндэсний төдийгүй олон улсын шинж чанартай боллоо.

Олон улсын төвшинд

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршилд “Гишүүн улсууд НҮБ-тай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг нийтээр хүндлэн сахиулахад тус дөхөм үзүүлэх үүрэг авсан”-ыг үндэслэн, энэхүү үүргийг бүрэн биелүүлэхэд хүний эрх, эрх чөлөөний мөн чанарыг нэг мөр ойлгох явдал нэн их ач холбогдолтойг харгалзан боловсрол нь :

- бие хүнийг өв тэгш хөгжүүлэх,
- хүний эрх , эрх чөлөөг улам бүр хүндэтгэх,
- аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах,
- Мөн НҮБ-аас энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж байгаа үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх ёстойг цохон тэмдэглэсэн байна.

Өөрөөр хэлбэл, боловсрол, түүний дотор хүний эрхийн боловсрол нь хүний эрх, эрх чөлөөг нэг мөр нийтэд ойлгуулсанаар хүний эрхийг хүндэтгэн сахиx соёлыг төлөвшүүлэх зорилготойг тунхаглан заажээ.

Цаашид эдгээр санааг Хүний эрхийн биллийн бүрэлдэхүүн хэсэг болох заавал мөрдөх хүчин чадалтай Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пакт болон Иргэний

ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад дэлгэрүүлэн тусгасан байна.

Хүний эрхийн Хороо улс орнуудын илтгэлийг судласны үндсэн дээр 1981 онд Иргэний ба Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн талаар дараахь ерөнхий зөвлөмжийг гаргасан байна “Хувь хүмүүс Пактын (болон нэмэлт протоколын) дагуу эдлэх эрхээ мэдэх нь тун чухал бөгөөд нөгөө талаас захиргааны болон шүүхийн эрх мэдэл бүхий этгээд нь Пактын дагуу оролцогч улсын хүлээсэн үүргийг ухамсарладаг байх нь чухал. Иймд Пактыг тухайн улсын бүх албан ёсны хэл дээр нийтэлж, эрх бүхий этгээдэд түүний агуулгыг таниулах сургалт явуулах шаардлагатай” гэжээ. Ингэснээр улс тус бүр өөрийн нэгдэж орсон, соёрхон баталсан олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийг албан ёсоор нийтлүүлж байхын чухлыг тэмдэглэсэн.

Мөн Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэргийг, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцэд хүний эрхийн боловсролын гүйцэтгэх үүргийг тусгасан.

1993 онд Австри улсын нийслэл Вена хотноо хуралдсан НҮБ-ын “Хүний эрх” бага хурлаар хүний эрхийн боловсрол нь “нийгмийн бүлгүүдийн

хооронд тогтвортой болон зохицолдсон харилцаа тогтоох, харилцан ойлголцох, хүлцэн тэвчих болон энх тайванч” хүмүүжлийг төлөвшүүлэхэд нэн чухал үүрэгтэйг цохон тэмдэглээд НҮБ-аас хүний эрхийн боловсролын 10 жилийг зарлахыг санал болгосон юм.

Үүний дагуу НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1994 оны 12 дүгээр сарын 23-ны өдөр 1995 оны 1 дүгээр сарын 1-ээс 2004 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацааг Хүний эрхийн боловсролын 10 жил болгон зарласан нь хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих явдалд чухал түлхэц өгсөн арга хэмжээ боллоо.

Мөн Венийн Бага хурлаас энэ арван жилийн хүрээнд хийх Үйл ажиллагааны хөтөлбөрийг сайшааж, түүний хэрэгжилтийг хангахыг НҮБ-ын ХЭДК-д даалгасан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хүрсэн үр дүнг жил бүр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болон ХЭДК Ерөнхий Ассамблейд тайлагнадаг. Үйл ажиллагааны хөтөлбөр нь олон улсын хамтын нийгэмлэгийн орнуудын өмнө дараахь зорилтыг дэвшүүлэн тавьсан:

- Хэрэгцээг тодорхойлж, үр ашигтай стратегийг боловсруулах;
- Хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг олон улс, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн төвшинд бий болгох, бэхжүүлэх;
- Хүний эрхийн боловсролын гарын авлага материалыг боловсруулах ажлыг уялдаатай хэрэгжүүлэх;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;
- Хүний эрхийн түгээмэл гүнхаглалыг дэлхий нийтэд түгээх.

Мөн хүний эрхийн боловсролын чиглэлээр баталсан дараахь олон

улсын баримт бидний ажлын удирдамж болдог:

- 1993 онд Монреаль хотноо болсон Олон улсын их хурлаас баталсан Хүний эрх ба Ардчиллын тухай боловсролын Дэлхийн хөтөлбөр
- 1994 оны Боловсролын талаархи Олон улсын бага хурлаас гаргасан Энх тайван, Хүний эрх ба Ардчиллын талаархи Тунхаглал ба Интеграцлагдсан үйл ажиллагааны үндэс суурь
- 1995 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий Бага хурлаар баталсан хүлээцтэй хандах тухай Тунхаглал

Эдгээр баримт бичиг нь олон улсын хамтын нийгэмлэгийн тэргүүн ээлжинд тавьж буй зорилт болох хүний эрхийг хангах, хамгаалах явдал дэлхий дээр энх тайвныг тогтоох урьдчилсан нөхцөл болдог гэдгийг дахин нотолж байна.

НҮБ-аас зарласан хүний эрхийн боловсролын 10 жилийн хүрээнд НҮБ-ын ХЭДКГ НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагатай хамтран болон дангаараа 10 жилийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагааг дэмжсэн техникийн туслалцааны төслүүд болон хүний эрхийн чиглэлээр олон нийтэд зориулсан жижиг төслүүдийг санхүүжүүлэн ажиллаж байгаа юм.

+ Бүс нутгийн төвшинд

Өнөөдөр дэлхий дээр хүний эрхийг хамгаалах Европ, Америк тивийн, Африкийн гэсэн бүс нутгийн тогтолцоо бий болж, бүс нутгийн хүний эрхийн баримт бичгүүдийг гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Харин Ази тив өөрийн гэсэн хүний эрхийн тогтолцоог бий болголгүй өнөөг хүрсэн. Бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн боловсролын талаар баримтлах бодлогоо боловсруулсан нь энэ үйл ажиллагаанд ахиц гарахад чухал алхам болж

байгаагаараа ач холбогдолтой. НҮБ-ын ХЭДКГ-аас 2001 оны 12 дугаар сард улс орнуудын хүний эрхийн боловсролын 10 жилийн хүрээнд хийгдэж байгаа ажлын талаархи мэдээллийг хүлээн авч 5 бүсээр ангилан илтгэл бэлтгэсэн байна. Үүнд:

- Африк
- Арабын орнууд
- Европ болон Хойд Америк
- Ази Номхон Далайн орнууд
- Латин Америк болон Карибийн орнууд хэмээн бүлэглэжээ.

Бүс нутгийн хүний эрхийн боловсролын чиглэлээр хийгдэж байгаа ажиллагаанд Европын орнууд хошуучилж яваа билээ. Бүс нутгийн хүний эрхийн тогтолцоонд анх Европын орнууд бүсийн хэмжээний Хүний эрхийн шүүх байгуулсан юм.

Хүний эрхийн боловсролыг хөхүүлэн дэмжих талаар ХЭҮК-оос баримталж байгаа бодлого, үйл ажиллагаа

ХЭҮК-ын нэг үндсэн чиг үүрэг нь Хүний эрхийн боловсролыг хөхүүлэн, дэмжих явдал юм. Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал ч хүний эрхийн боловсролыг тэргүүн ээлжинд тавихыг шаардаж байна. Эрх зүйн орчин үндсэндээ шинэчлэгдэж, хүний эрх, эрх чөлөөний тухай асуудал нь олон улсын жишгээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцэд тулгуурлах болсон нь шинэ нөхцөл байдлыг бий болгож байна.

Хүний эрхийн боловсрол олгох асуудал нь үндэсний хууль тогтоомжийг судалж мэдээд зогсохгүй олон улсын жишгээр хүлээн зөвшөөрсөн, хүн төрөлхтөний үнэт зүйл болсон олон улсын хэм хэмжээ, гэрээ конвенцийг харьцуулан судлахыг шаардаж байна.

Иймд иргэдэд Хүний эрхийн боловсрол олгох нь нэг дэх гол зорилт болж байна.

Манай иргэдийн хүний эрхийн боловсрол ямар төвшинд байгаа нь ХЭҮК-оос явуулдаг судалгааны явцад мэдрэгддэг. Тухайлбал, ХЭҮК-оос Хүүхдийн эрхийн талаар явуулсан судалгааны хүрээнд Улаанбаатар хотын 290 хүүхдээс Хүүхдийн эрхийн тухай хууль, конвенцийн талаар мэдэх үү? Гэсэн асуултад 25,8 хувь нь мэднэ гэж хариулсан бол 50,5 хувь нь муухан мэднэ, 11,0 хувь нь нэрийг нь дуулсанаас цаашгүй, 12,4 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан байна.

Мөн асуултыг насанд хүрэгч 149 хүнд тавихад 51,0 хувь нь мэднэ, 36,9 хувь нь муухан мэднэ, 7,4 хувь нь сонссоноос цаашгүй, 4,7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хүн амын хүний эрхийн талаархи мэдлэг тун хангалтгүй байгааг энэ асуулгын дүн харуулсан учраас нэн тэргүүнд иргэдэд өөрсдийнх нь эрхийн талаар таниулан мэдүүлэх нь чухал байна. Хүний эрхийн асуудал Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд маш өргөн хүрээтэй туссан бөгөөд манай улс хүний эрхийн 30 гаруй олон улсын гэрээнд нэгдэж орсон боловч тэдгээр нь одоо хүртэл албан ёсоор нийтлэгдээгүй, олны хүртээл болоогүй байна. Иймд иргэдэд дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээний дагуу эдлэх эрх чөлөөг нь таниулан мэдүүлэх нь нэн тэргүүний зорилт болон дэвшигдэж байна.

✱ Бусдын эрхийг хүндэтгэдэг, сахин биелүүлдэг хүмүүжлийг иргэдэд төлөвшүүлэх нь 2 дахь гол зорилт болж байна.

Өөрөөр хэлбэл, хүн өөрийнхөө эрх, эрх чөлөөг эдлэхдээ бусдын эрх,

эрх чөлөөг хүндэтгэдэг, өөрт олгогдсон эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийн тухай хууль тогтоомжийн заалт, шаардлагыг хатуу сахиж мөрддөг болгоход чиглэгдэх ёстой.

Бусдын эрхэд нэн тэргүүнд халдлаг

- Прокурор,
- Өмгөөлөгч,
- Шүүгч
- Хорих байгууллагын ажилтан,
- Цагдаагийн ажилтнууд гэсэн

албан тушаалтнуудын хүний эрхийн боловсрол өндөр байх нь чухал байдаг боловч бусад этгээдээс хүний эрхэд халдах явдал цөөнгүй тохиолддог.

Тухайлбал, өмнө дурьдсан санал асуулгад оролцсон хүүхдүүдээс Таны эрхийг хэн илүүтэй зөрчдөг вэ? гэсэн асуултад хүүхдүүдийн 47,4 хувь нь үе тэнгийнхэн, 19,6 хувь нь багш нар, 7,9 хувь нь хуулийн байгууллагын ажилтнууд, 8,9 хувь нь эцэг, эхчүүд гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, өөрийнхөө ч эрхийн талаар мэдэхгүй яваа хүүхдэд бусдын эрхийг хүндэтгэх ёстой гэсэн төсөөлөл ч үүсдэггүй, тийм соёлд ч суралцаагүй байдаг нь тодорхой байна.

• Өөрийн зөрчигдсөн эрхийн талаар тэмцэх чадвар, ухамсрыг хүн амын дунд бий болгох нь 3 дахь үндсэн зорилт юм.

Иргэд эрх, ашгаа зөрчигдсөн тохиолдолд түүнийгээ сэргээлгэхийн төлөө тууштай тэмцдэг, тэмцэх арга хэлбэрээ мэддэг байх ёстой. Ийм чадвар, ухамсар төлөвшөөгүй нь өнөөгийн нэг гол дутагдал юм.

Хүн эрхийнхээ талаар мэдэх нь чухал боловч тэр эрхээ хэнээр, хэзээ, яаж хамгаалуулахаа мэдэх нь бас чухал байдаг. Өөрөөр хэлбэл тодорхой эрх нь зөрчигдсөн тохиолдолд ямар

хугацаанд, ямар байгууллагад хандах аа мэдэх ёстой. Тухайлбал, наад захын жишээ дурьдахад ажлаас буруу халагдсан хүн нэг сарын дотор гомдлоо шүүхэд мэдүүлэх ёстой. Гэтэл хүмүүс энэ тухай мэддэггүй учраас Засгийн газар, Үндсэн хуулийн Цэц, Улсын Их Хурал зэрэг байгууллагад өргөдөл барьж явах хугацаанд нь шүүхэд гомдол хүлээж авах нэг сарын хугацаа нь өнгөрчихдөг жишээтэй.

ХЭҮК эдгээр тулгамдсан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс ямар бодлого баримталж байна вэ?

2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Хүний эрхийн үндэсний Комиссын стратеги төлөвлөгөөнд Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих чиг үүрэг нь Комиссын үйл ажиллагааны чухал хэсэг юм гэж цохон тэмдэглэжээ. Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжихийн тулд юуны өмнө энэхүү боловсролын ерөнхий хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөг зайлшгүй чухал юм.

ХЭНН-ий Сангийн эрхийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай. Ингэснээр хүний эрхийн салбарт туршлага, мэдлэгтэй шинжээч, эрдэмтэн, багш, хэвлэл мэдээллийнхэн зэрэг өргөн олон нийтийг энэ ажилд оролцуулах боломжтой болно. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь хүний эрхийн үзэл баримтлалыг нийгмийн хэм хэмжээ, үйл байдал бүрт шингээхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөр нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын

Пакт, Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Хүүхдийн эрхийн Конвенц зэрэг олон улсын баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд тулгуурласан байх бөгөөд үзэл баримтлал, агуулга, арга зүйн хувьд:

- Бүх шатны сургуульд
- Нийгмийн тодорхой зорилтот бүлэгт
- Олон түмэнд гэсэн гурван категорид ангилан хэрэгжих болно.

Бүх шатны сургуульд

Стратеги төлөвлөгөөний үйл ажиллагаа 1.2-д заасанчлан Комисс нь холбогдох яам, газруудтай хамтарч дунд сургууль, их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн сургалт явуулах нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх талаар ажиллана.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Соросын сантай хамтран ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид хүний эрхийн сургалтыг Хэрэглээний эрх зүйн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд 2002-2003 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэллээ. Цаашид энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд багш нарыг бэлтгэх, эцэг эхийг энэхүү сургалтад татан оролцуулах явдал чухал байна.

Их, дээд сургуулийн хувьд 1997 онд Монгол Улсын Гэгээрлийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар Хууль зүйн сургалт явуулдаг сургуулиудад мэргэжлийн чиглэлээр заавал үзэх хичээлийн жагсаалтыг баталсан ба эдгээрт хүний эрхийн 36 цагийн хичээлийг багтаасан байгаа. Манай улсын хэмжээнд 32 их дээд сургууль хууль зүйн сургалт явуулж байна. Одоогийн байдлаар хүний эрхийн сургалтыг зөвхөн лекц уншин, хүний эрхийн онол заах явдлаар хязгаарлаж байгаа нь энэхүү уламжлалт хэлбэрийг өөрчлөхийг нөхцөлдүүлж байна.

Учир иймд хуулийн мэргэжлийн сургалтын нийт хөтөлбөр нь хүний эрхийн хамгаалалтад бүхэлдээ чиглэгдэх ёстойг анхаарахын зэрэгцээ хуульчдын өөрсдийн хүний эрхийг хамгаалагч, болзошгүй зөрчигч байдаг хоёрдмол байдлыг анхаарч илүү мэргэжлийн бөгөөд хэрэглээний шинжтэй сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай байгаа юм. Нөгөө талаас, зөвхөн хуулийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиар хязгаарлахгүй хүний эрхийн сургалтыг бүх их, дээд сургуульд явуулах, ингэснээр хүний эрхийн зөрчлийг олж илрүүлэх, түүнтэй тэмцэх арга замаас суралцах, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадвартай, идэвхтэй, оролцогч, ардчилсан иргэн болж төлөвших практик зорилтот нийцүүлж сургалтын хөтөлбөрийг боловсруулах нь чухал байна.

Нийгмийн тодорхой бүлэгт

ХЭҮК нь хэдий үйл ажиллагаагаа эхлээд удаагүй байгаа ч иргэдийн гомдол хамгийн их гарч буй тодорхой салбарт болон хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах ёстой байгууллагыг хамарсан хүний эрхийн сургалт зохион байгуулах хэрэгцээ байгааг тогтоосон юм. Иймд ХЭҮК нь дараахь салбарыг хамарсан богино хугацааны эрчимтэй сургалт зохион байгуулна.

Шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдолтой албан тушаалтнуудад, тухайлбал:

- Прокурор,
- Өмгөөлөгч,
- Шүүгч,
- Хорих байгууллагын ажилтан,
- Цагдаагийн ажилтан.

Төрийн албаны хүрээнд зохих яам, тусгай газрын ажилтнуудад Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрхийн талаар болон тэдгээрийн

хүлээх үүргийн талаар ойлголт өгөх, төр иргэдийн хоорондох харилцааг таниулах

- Орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтнуудад, ялангуяа аймгийн төвшинд,

- Нийтэд мэдээлэл түгээх үүрэгтэй хэвлэл мэдээллийн төлөөлөгчдөд хүний эрхийн стандартын талаар суурь сургалт явуулах,

- ТББ, ялангуяа эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагын төлөөлөгчдийг сургалтанд оролцуулах,

- Багш нар, ялангуяа багшийн их сургуулийн багш нарт,

- Бизнесийн, эздийн болон ҮЭ-ийн байгууллагын төлөөлөгчдөд.

Энэхүү долоон бүлэгт сургалтыг зохион байгуулахад тус бүрийн онцлогт тохирсон сургалтын тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх болно.

Олон түмэнд

Хүний эрхийн боловсролыг өргөн олон нийтэд олгох нь ихээхэн чухал бөгөөд хөтөлбөрийн салшгүй хэсэг нь болно. Энэ нь юуны өмнө хүний эрхийн талаархи мэдлэг, мэдээлэл хүмүүст олгож улмаар нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх нь энэ бүлэгт явуулах сургалтын зорилго чиглэгдэнэ. Хэрэв тодорхой мэргэжлийн бүлгүүдэд зориулсан сургалт богино хугацаанд эрчимтэй явагдах ёстой байдаг бол олон түмэнд чиглэсэн хүний эрхийн боловсрол нь урт хугацаанд, олон удаагийн арга хэмжээгээр, энгийн хэлбэртэй, мэдээж хэрэглээний шинжтэй байх нь чухал. Энд голлох үүргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл гүйцэтгэнэ. Комиссын үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн зарим хэлбэр, тухайлбал:

• Аймагт Комиссын гишүүд очиж ажиллах, хүний эрхийн нээлттэй өдрийг зохиох,

• Телевизийн цуврал нэвтрүүлэг бэлтгэж гаргах,

• Зурагт хуудас, хүний эрхийн зарим сэдвээр эвхмэл хуудас, танилцуулга бэлтгэж хэвлүүлэх,

• Үндэсний телевизээр хүний эрхийн сэдвээр реклам бэлтгэж гаргах,

• Оюутан залуучуудын дунд хүний эрхийн тодорхой сэдвээр тэмцээн зохиох,

• Хүүхэд залуучуудыг хамруулан зуны сургалт зохиох зэрэг олон ажил үр дүнгээ өгсөн.

Цаашид

• радио нэвтрүүлэг явуулах,

• видеобичлэг бэлтгэх,

• улирал тутам гардаг хүний эрхийн сэтгүүл эрхлэн гаргах,

• өдөр тутмын хэвлэлийн байгууллагатай (Зууны мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр зэрэг) гэрээ байгуулж дээрх сонинд хүний эрхийн булан нээж ажиллуулах,

• Хүүхэд залуучуудын дунд хүний эрхийн клуб байгуулах,

• Хүний эрхийн салбарт ажилладаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, сургалт зохиоход нь тусалцаа үзүүлэх,

• Жил бүрийн 12 сарын 10-ны Хүний эрхийн өдрийг тэмдэглэхдээ олон түмэнд хандсан янз бүрийн арга хэмжээ зохиох (хүүхэд залуучуудын дунд хүний эрхийн сэдвээр зохион бичлэг, гар зургийн уралдаан зарлах, эрдэмтэн, багш нарын дунд тодорхой сэдвээр илтгэл, судалгаа хийлгэж шалгаруулах, онол практикийн бага хурал, симпозиум, семинар зохиох, концерт, шоу, телевизийн нэвтрүүлэг бэлтгэж зохиох г.м.)

ХЭҮК-оос Хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Хүний эрхийг заах шинжлэх ухаан-арга зүйн бага хурал:

• Хүний эрхийн курсыг их, дээд сургуулийн заавал судлах хичээлийн

жагсаалтад оруулах,

- Ерөнхий боловсролын болон их дээд сургуульд суралцагсад, тодорхой бүлэгт зориулсан сурах бичиг, гарын авлага бэлтгэн гаргах,

- Хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн багшийг сургаж, бэлтгэх,

- Хүний эрхийн мэдээлэл,

сургалтын нэгж байгуулах,

- Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, төрийн захиргааны албан хаагчийг сонгон шалгаруулах, шалгалт авахад хүний эрхийн мэдлэг боловсролын төвшинг харгалздаг байх зэрэг зорилт тавигдаж байна.

ЗОХИСТОЙ ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

(Голландын төрийн
захиргааны туршлагаас)

Филипп М.Лэнгброк
(Орчуулсан С.Гэрэлмаа, ХЗҮТ-ийн
Төрийн байгуулалтын хууль
тогтоомжийн секторын эрхлэгч)

Захиргааны ерөнхий хууль нь захиргаанаас шийдвэр гаргах тухай болон иргэд, хувь хүн болон байгууллагын эрх зүйн тодорхой байдлын тухай юм. Захиргаанаас шийдвэр гаргана гэдэг нь нийтлэг дүрмийг тодорхой тохиолдолд хэрэглэнэ гэсэн үг.

Эх газрын эрх зүйт төрийн сонгодог онолын дагуу (Германаар Rechtsstaat) эрх зүйн тодорхой байдал нь урьдчилан таамаглаж болохгүй нийгэм, улс төр болон шүүхийн процессийн сүлжил болж хувирсан.

Голландын захиргааны хуульд зохистой захиргааны ерөнхий зарчим (ЗЗЕЗ) нь эрх зүйн тодорхой бус байдлыг арилгах зорилгоор боловсруулагдаж эрх зүйн процедурыг илүү оновчтой болгоход чиглэгджээ.

Голландын захиргааны хуулийн ЗЗЕЗ нь шийдвэр гаргах, захиргааны эрх мэдлээр асуудлыг шийдвэрлэх болон шүүхийн хяналтын тухай байдаг. Мөн шүүх болон захиргааны

байгууллагын харилцааг хамаарна. Захиргааны хуулийн түүхэн хөгжил нь ЗЗЕЗ-д гол анхаарлаа төвлөрүүлэхэд хүргэсэн. ЗЗЕЗ нь захиргааны байгууллагын зан үйлдлийн журмыг тогтоодог бөгөөд шүүхээс захиргааны байгууллагын шийдвэрийг хянах арга хэрэгсэл болдог.

Голландын захиргааны хуулийн ЗЗЕЗ-ын хөгжил нь:

- Захиргааны хуулийн хөгжлийн түүх;

- ЗЗЕЗ-ыг захиргааны байгууллага болон төрийн хуулийн этгээдийн зан үйлдлийн дүрэм болохын хувьд нэрлэх болон утгыг нь тайлбарлах;

- Захиргааны байгууллага болон төрийн хуулийн этгээдийн шийдвэр гаргах процесс.

Захиргааны хуулийн хөгжлийн хандлага

Голландын захиргааны хуулийн хөгжил нь аж үйлдвэрийн хувьсгал болсноос хойш барууны нийгэм хөгжсөн тэр л замаар явж ирсэн бөгөөд

нийгэмд төрөөс үзүүлсэн нөлөөллийн үр дүн юм. Голландын хувьд энэ нь зохистой захиргааны эрх мэдэл болон шүүхийн хяналтын сөргөлдөөний замнал байжээ. (Захиргааны эрх мэдэл хэзээ дуусаж шүүхийн хяналт хэзээ эхлэх, Захиргааны байгууллагын тайлагнах явдал ямар хязгаартай г.м)

Голландад захиргааны эрх зүй хөгжсөний хэрээр зохистой захиргааны ерөнхий зарчим үүсэж бий болсон. Энэ хөгжил нь тодорхой логикийн дагуу явагдаагүй..

Голландын захиргааны хуулийн хөгжил нь маш товчхон түүхтэй. Хөгжил нь хувьсгалын шинжтэй биш харин тогтвортой байсан. Захиргааны хуулийн үйлчлэх хүрээ нь гэнэтийн зүйл биш бөгөөд өдөр тутмын амьдралд нөлөөлдөггүй.

Голландын захиргааны хууль нь 19 дүгээр зууны сүүлийн 10 жилд хөгжиж эхэлсэн. Аж үйлдвэрлэлтийн нийгмийн үр дагвар болох ажилчдын хөдөлгөөний цахалдаар улс төрчил зах хязгаарын хорооллын эрүүл ахуй, хүүхдийн хөдөлмөр, ажлын цагийн үргэлжлэл, нийгмийн даатгалын холбогдолтой бодлогыг боловсруулав. Хүн ам тогтвортой хөгжихийн хэрээр нийгэм, техник болон экологийн хөгжилтэй уялдан захиргааны эрх зүй өргөжиж ирсэн байна.

Энэ хөгжилд дараахь 3 төлөвийг онцлон тэмдэглэж болно:

Нэгдүгээрт улс төрийн тавцан дээр байдаг бүх оролцогчид нийгэмд нэвтэрч эхэлсэн тухайлбал хууль тогтоогч болон Засгийн газрын агентлагууд г.м. Нийгэм, төр илүү нягт холбоотой болж ирсэн. Энэ хөгжлийн нэг шинж нь хүмүүсийн талаархи мэдээллийг хамгаалах хуулийг дагаж мөрдүүлсэн явдал юм. Хүмүүсийн тухай мэдээллийг бүртгэх танхим

байгуулагдаж бусад бүх этгээдээс хувь хүний тухай мэдээллийг бүртгэх явдлыг хязгаарласан. Гэвч энэ нь анх ажилд авч байгаа хүний тухай мэдээллийг бүртгэхэд саад учруулахгүй.

Захиргааны хуулийн 2 дахь төлөв нь хуулийг илүү тодорхой болгохын төлөө тэмцэл өрнөсөнтэй холбоотой. Эрх зүйн тодорхой байдлыг Парламентын акт баталснаар тогтоож болно гэсэн өөдрөг үзлийг хуучинсаг үзэлтэн, бизнес эрхлэгчид, ажил олгогчид хүлээн зөвшөөрдөг. Тэдгээр нь хүний амьдралын бүх асуудлын талаархи хариуцлагыг төр хүлээх ёсгүй гэж шүүмжилдэг. Эрх зүйн болон нийгмийн тодорхой байдал тогтоохыг Засгийн газрын бодлогын зорилт болгохыг өөрчлөгдөж буй болон хөгжиж буй нийгмийн уян хатан байх хэрэгцээнд нийцэхгүй гэж үздэг. Эрх зүйн болон нийгмийн тодорхой байдлын хэрэгцээ нэг талаас эдийн засаг, нийгмийн уян хатан байдлын хэрэгцээ нөгөө талаас зөрчилдсөн нийгмийн ашиг сонирхол бий болгодог.

Эрх зүйт төрийн үзэл санаа нь эрх зүйн тодорхой байдлын үзэл санаанд үндэслэдэг. Эрх мэдлийг хуваах үзэл санааг анх Англи улсад 16 дугаар зуунд боловсруулж, дараа нь Франц, Германд эрх зүйн тодорхой байдлыг нийгэмд улсын болон хувийн хүрээг хязгаарлахад зайлшгүй шаардлагатай гэж үзэх болсон. Хуулиар тогтоосон дүрэм журмыг байгалийн хуультай адилтгаж үздэг. Гэгээрлийн зууны үед энэ үзэл санаа тийм ч ашигтай биш юм. Энэ үзэл санааны гол утга нь хүн бүхэн адил зан үйлдэл хийдэг зүй тогтолтой гэдэгт орших бөгөөд эрх зүйн шинжлэх ухааны зорилго нь энэ зүй тогтлыг нээж тэдгээрийг парламентаас батлах хуульд тусгах ёстой гэж үздэг. Ийм эрх зүйн тодорхой байдалд хаана ч, хэзээ

ч хүрч чадаагүй юм.

Бүх хүмүүс зохион бүтээх, ямар нэгэн юмыг өөрчлөх, сонгох болон хамтран үйлдэл хийх чадвартай болохыг мэднэ. Байгалийн үзэгдлийг урьдчилан таамаглаж болдоггүйтэй адил хүмүүсийн эдгээр чадвар нь ирээдүйг таамаглахад хүндрэл учруулдаг. Иймд Парламентаас гаргасан хууль хийх ёстой байсан зүйлээ хийхгүй байх нь элбэг тохиолддог. Тухайлбал, нийгмийн зарим төлөвийг зохион байгуулах болон хуулийн субъектууд нь эдгээрийн стандартын дагуу амьдрах г.м. Барууны нийгэмд гарч байгаа өөрчлөлт нь ирээдүйд гарч болзошгүй бүх хэргийг урьдчилан харж Парламентын актаар зохицуулах боломжгүй болохыг харуулж байна.

Бодлого болон ерөнхий стандартыг бодитой хэрэгжих дүрэм болгосон тохиолдолд тэдгээр нь захиргааны хэвшсэн заншил болж хэрэгждэг. Нийгэм, экологи, техникийн хөгжил нь Засгийн газар болон Парламентаас өөр эрх зүйн акт гаргахад хүргэж болно. Голландад өнөөдөр ч энэ процесс явагдаж байгаа жишээ байна.

Тухайлбал, Гадаадын иргэдийн тухай хууль нь гадаадын иргэдийг ямар нөхцөлд голландын нийгэмд амьдрахыг зөвшөөрөх вэ гэдэг асуудлыг зохицуулдаг. Орогнох хүсэлт гаргасан иргэдийн тоо хэт их өсөж байгаа нь цагаачлалын байгууллагын ажилд ихээхэн хүндрэл учруулдаг. Гадаадын иргэдийн тухай хуульд орсон саяхны өөрчлөлт нь орогнол олгох нөхцлийг илүү хатуу болгожээ. Гаг хотын дүүргийн шүүхийн гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн хэсгийн процедурыг илүү үр дүнтэй болгоход чиглэгджээ.

Эрүүл ахуйн халамжийн зардал өсөж байгаатай холбогдон эрүүл мэндийн даатгалын хуульд байнга өөрчлөлт орж байна. Энэ өөрчлөлтийн дагуу эрсдлийг нийтийн эрүүл мэндийн даатгалын сангаас хувийн даатгалын компаниудад шилжүүлсэн. 1994, 1995 оны өвөл Голландын олонхи голуудын усны төвшин гэнэт нэмэгдэж үер гарах аюул нүүрлэсэн нь томоохон голуудын далангийн тухай хууль батлахад хүргэсэн. Энэ нь байгаль орчныг хамгаалах бүлгийн байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөг үнэлж, голын даланг шинэчлэх талаар удаан хугацаанд хөөцөлдсөн асуудлыг шийдвэрлэх боломж олгожээ. Хууль гарсны дараа захиргааны байгууллага болон шүүх нь хэрэгжих боломжтой бодитой шинэ дүрэм гаргах, хэрэгжилтийн бодлогыг боловсруулах болно.

Энэ нь эрх зүйн тодорхой байдалд эрмэлзэх шаардлагагүй гэсэн үг биш. Хүмүүс амжилтгүй ч гэсэн тодорхой байдалд хүрэх чармайлт гаргадаг. Засгийн газрын үндсэн нэг зорилго нь нийгмийн хөгжлийг тодорхой хязгаарлалтайгаар чиглүүлэхэд оршдог учраас хууль дүрмийг богино хугацаанд өөрчилж байх болон тэдгээр өөрчлөлтийг өөрчлөгдөж байгаа дэлхийд хэрэгжүүлэх шаардлага гардаг. Үгийн утга нь ямар агуулгаар хэрэглэгдсэнээс хамаарч өөр өөр байдагтай адил хуулийг янз бүрийн утгаар өөр өөрөөр хэрэгжүүлдэг. Хууль маш хатуу чанга байлаа ч гэсэн түүнийг зөөлрүүлж илүү уян хатан болгож хэрэгжүүлэхийг зөвтгөх ёстой. Голландын Захиргааны хуулийн 3 дахь төлөв нь төр нийгэм дэх эрх зүй уян хатан байх хэрэгцээг хэрхэн хангаж байгаатай холбоотой. Энэ нь зохицуулах эрх мэдлийн уян хатан байдал, төрийн байгууллагаас асуудлыг үзэмжээрээ шийдвэрлэх эрх мэдэл нэмэгдэнэ, шүүхийн байгууллага

үүнд зохицож ажиллана гэсэн үг юм. Төрийн талаасаа авч үзэх юм бол нийгэм дэх эрх зүй уян хатан байх хэрэгцээг хангахын тулд нийгмийн болон Засгийн газрын хуулийг өөрчлөх, эрх мэдлийг зохицуулах боломжтой байх, зохистой шийдвэр гаргах баталгаа болон асуудлыг дахин шүүхээр хянах хэрэгцээний хоорондох тэнцвэрийг хайх нь чухал байна. Иймд тодорхой хэргийг шийдвэрлэх, хуулийг тайлбарлахад шүүгчийн ур чадвар илүү ач холбогдолтой болж байна. Эрх зүйн бизнес нь маш эрчимтэй байдаг.

Уян хатан байх

Парламентын хуулийг өөрчлөхөөс гадна хууль тогтоох эрх мэдлийг Захиргааны янз бүрийн төвшингийн байгууллагад шилжүүлэх болон захиргааны байгууллагад өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж олгох зэргээр уян хатан байдалд хүрч болно.

Эрх зүйн актын статус нь өндөр байх тусам уян хатан байдал нь алдагддаг. Тухайлбал, Голландын Үндсэн хуулийг өөрчлөх журам нь Парламентаас баталсан эрх зүйн акт, Зөвлөлийн тушаал, сайдын баталсан дүрэм журам болон орон нутгийн засаг захиргааны шийдвэрийг өөрчлөхөөс илүү төвөгтэй байдаг. Дүрэм журмын уян хатан байдал зохицуулах эрх мэдлийг төрийн байгууламжийн доод төвшинд шилжүүлснээр хангагдана. Голландын захиргааны хуульд хууль тогтоомж нь шаталсан бүтэцтэй байдаг бөгөөд ийм учраас хамтарсан дүрэм журмын тухай ярьж байна.

Тухайлбал, орон сууцны тухай хууль нь нийгмээс 50 жилийн туршид явуулсан орон сууцны бодлогын үр дүн юм. Энэ хуулиар орон сууцны төлбөрийн тодорхой төвшингээс доогуур төвшингийн орон сууцыг

тодорхойлох, ангилах болон хуваарилах журмыг тогтоосон. Энэ хуулийн дагуу тодорхой төвшингийн орон сууцыг хуваарилах, түрээсийн хөлсийг ангилах, орон сууц хүссэн хүмүүсийг бүртгэх журмыг тогтоожээ. Энэ эрх мэдлийг төвлөрсөн төвшинд Засгийн газар болон орон сууцны асуудал эрхэлсэн яамны хооронд орон нутгийн төвшинд хотын Засаг дарга болон хотын захиргааны хооронд хуваарилж, Засгийн газар нь өргөдөл гаргагчдыг ангилах журмыг тодорхойлж, хэндэн тэргүүн ээлжинд орон сууц олгохыг зааж өгдөг. Өгөгдсөн түрээсийн төвшинд орон сууцны төлбөрт өөрчлөлт оруулах журмыг хотын захиргаа батлах үүрэгтэй. Яаж энэ эрх мэдлийг хэрэгжүүлэхийг тэдгээр байгууллага нь өөрсдөө шийдвэрлэнэ. Хотын захирагч нь орон сууц хүссэн хүмүүсийн өргөдлийг шийдвэрлэдэг.

Зорчигч тээвэрлэлтийн хуулийн дагуу мужийн зөвлөл таксийн компанийг лицензжүүлэх бүсийн төлөвлөгөөг хийх ёстой. Энэ төлөвлөгөөний хүрээнд тэдгээр нь таксины тоог хязгаарлах эрхтэй байна. Ингэснээр таксины үйлчилгээний чанарыг тодорхой төвшинд тогтоох боломжтой болно. Мужийн захиргааны албан тушаалтнууд лицензийг мужийн төлөвлөгөөнд дурдсан нөхцлийн дагуу олгож болох юм.

Эрх зүйн уян хатан болон тодорхой байдалд “Бодлогын дүрэм”-ийн тусламжтайгаар хүрч болно. Бодлогын дүрэм гэдэг нь захиргааны байгууллагаас өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэх эрх мэдлээ эрхэн хэрэглэх тухай заадаг. Эдгээр нь энэ эрх мэдлийг эдэлж байгаа хүмүүсийн хувьд нэн чухал юм. Жишээлбэл, ямар нэгэн этгээд татвар төлөхдөө зөрчил гаргасан бол мужийн татварын байцаагч түүнд Орлогын

татварын хуулийн дагуу шийтгэл хүлээлгэнэ. Энэ шийтгэл нь ногдуулсан татварын 100 хүртэл хувиар нэмэгдүүлэхэд оршино. Татварын асуудал эрхэлдэг Санхүүгийн яам нь татварын байцаагчид асуудлыг өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрх олгох тухай бодлогын дүрэм баталсан. Үүнд зааснаар татвар төлөгчид зөрчил гаргасан тухай мэдэгдэл өгөх бөгөөд мэдэгдлийг үл тоомсорлосон тохиолдолд л хариуцлага ногдуулна.

Ийм төрийн удирдамж нь захиргааны дүрэм журмыг иргэдэд илүү тодорхой болгох ач холбогдолтой. Эдгээрийг захиргааны байгууллагын амлалт гэж үзэж болно. Захиргааны байгууллага нь эдгээр удирдамжийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд гэнэтийн явдал гараагүй л бол иргэд тэдгээрийг энэ удирдамжийн дагуу ажиллана гэж урьдчилсан төсөөлөлтэй байдаг.

Захиргааны шүүхийн хөгжил түүнийг харьяалан шийдвэрлэх асуудал

19 дүгээр зууны эцэст Голландад иргэний болон эрүүгийн хэргийг ерөнхийд нь харьяалан шийдвэрлэх шүүхүүд байсан. Төрийн оролцоо нэмэгдсэнтэй холбоотойгоор захиргааны тушаалд гомдол гаргах тогтолцоо төрийн байгууламжийн хүрээнд үүсч эхэлжээ. Эдгээр гомдлыг шийдвэрлэх хамгийн дээд шатны байгууллага нь Хаан байлаа. Төрийн зөвлөлийн захиргааны маргаан шийдвэрлэх хэсэг нь хааны Зөвлөх байгууллагын хувьд гомдлыг шүүхийн нэгэн адил хаанаар шийдвэрлүүлэхэд бэлтгэдэг байсан.

Тухайн үеийн шүүхийн байгууламжийн тогтолцоонд биеэ даасан захиргааны хэрэг харьяалан шийдвэрлэх тогтолцоог бий болгох гэсэн чармайлт 20 дугаар зууны 2 дахь 10 жилд амжилтгүй болсон Лоеф

сайдын захиргааны шүүх байгуулах тухай санал нь Парламентын олонхийн дэмжлэг авч чадаагүй. Асуудлыг зарчмын хувьд шийдэхийн тулд бодит баримтаар шүүхийн экспертиз хийлгэхийг түүний сөргөлдөгч проф.Страйкен шаарджээ. Тэр техникийн саатал эсхүл газрын төлөвлөлттэй холбогдолтой асуудлыг шүүгч ойлгож чадахгүй гэсэн үндэслэл гаргаж энэ саналыг эсэргүүцсэн. Иймд шүүгч захиргааны асуудалд оролцох ёсгүй гэж үзэж байв. Иргэний шүүхүүд захиргааны хэргийг захиргааны байгууллагын хүрээнд хянан хэлэлцэх нь маргааныг шийдвэрлэх зохистой хэлбэр гэж үздэг. Захиргааны журмаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд л иргэний шүүхэд ханддаг. Ингэснээр шүүх захиргааны тушаалыг зохих хязгаарлалттайгаар хянан шийдвэрлэж байсан. Харин одоо шүүхэд захиргааны хэрэг шийдвэрлэхэд маш цөөхөн тохиолдолд хязгаарлалт тогтоосон боловч шүүхүүд нь практикт хязгаарлалтыг өргөн хэрэглэдэг нь хэвээр байна.

Захиргааны хэргийг захиргааны журмаар шийдвэрлэхийг илүүд үзэж байсан боловч өнөөдрийн байдлаар хэд хэдэн захиргааны шүүх байгуулагдаад байна: Тухайлбал хөдөлмөрийн чадвараа алдсан үеийн нийгмийн даатгалын маргааны /1902/, татварын маргааны /1914/, төрийн албан хаагчдын шүүх /1929/. дурдсан хугацаанд иргэний шүүхэд мөн захиргааны маргаан шийдвэрлүүлэх боломжтой болсон, тухайлбал үерийн хамгаалалтын далан болон ус сувгийн тухай хуулиар зохицуулдаг.

Дэлхийн 2 дугаар дайны дараа худалдааны болон таваарын байгууллагаас захиргааны шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлэх захиргааны шүүх шинээр байгуулагджээ. Аж үйлдвэрийн

байгууллагын хэм хэмжээтэй холбогдсон гомдлыг шийдвэрлэх шүүх /1954/. Нийгмийн даатгал болон татварын эрх зүйн хамгаалалтын байгууллага шинэчлэн зохион байгуулагдлаа

Зөвхөн 1963 онд л захиргааны шийдвэрт гомдол гаргах нэгдсэн тогтолцоог бий болгосон хууль батлагдсан. Энэ тогтолцоог 1976 онд шинэчилж Төрийн Зөвлөлийн Шүүхийн хэлтэс байгуулжээ. Шүүхийн хэлтэст гомдлыг гаргахын өмнө эсэргүүцлээ шийдвэр гаргасан захиргааны байгууллагад гаргах ёстой. Мэргэшсэн захиргааны шүүхээр шийдвэрлүүлхээс бусад захиргааны байгууллагын ямар ч шийдвэрт гомдол гаргаж болно. Гэвч захиргааны маш олон шийдвэрийг захиргааны журмаар шийдвэрлэх тогтолцоо хадгалагдсаар байна

Дараагийн хөгжлийн үе шат нь Бенземын хэргийг Европын хүний эрхийн шүүхээр хэлэлцсэнтэй холбоотой. Ноён Бензем хотын захиргаанаас шатахууны станц байгуулах лицензийг Хот тохижилтын байдлын тухай хуулийн дагуу авчээ. Мужийн эрүүл мэндийн байцаагч шатахуун түгээх станц оршин суугчдын амьдарч байгаа газарт хэтэрхий ойрхон байна гэсэн үндэслэлээр энэ шийдвэрт гомдол гаргасан. Хаан эрүүл мэндийн байцаагчийн гомдлыг хангаж лицензийг хүчингүй болгожээ. Бензем шатахуун түгээх станцаа хаах болсон. Үр дүнд нь тэр дампуурсан байна. Бензем Хүний эрхийн хороонд гомдол гаргахдаа бие даасан шүүхэд хандах эрхээр хангагдаагүй учраас Европын хүний эрхийн тунхаглалын 6 зүйл зөрчигдсөн гэжээ. Европын хүний эрхийн шүүх Хааныг бие даасан шүүх биш гэж үзсэн учраас ЕХЭТ-ын 6 дугаар зүйл зөрчигдсөн байна гэсэн

шийдвэр гаргасан.

Үр дүнд нь Төрийн зөвлөлийн Захиргааны маргааны хэлтэс, хаанд өгсөн гомдлыг шийдвэрлэх зөвлөх байгууллагад бие даасан шүүхийн статусыг 1986 онд олгож Хаанд гомдол гаргах эрхийг хуулиар тогтоожээ. Үүний дараа захиргааны журмыг шууд өөрчлөхөд бэлтгэж, 1994 онд Захиргааны ерөнхий хуулийг баталсан байна. Энэ хуулийн дагуу дүүргийн 19 шүүхэд захиргааны шийдвэрийг эсэргүүцсэн гомдлоо гаргах боломжтой болсон бөгөөд зарим захиргааны шүүхийг хэвээр хадгалсан (татварын, нийгмийн даатгалын, төрийн албан хаагчидтай холбогдолтой асуудлаархи, аж үйлдвэрийн байгууллагын, байгаль орчны, газар ашиглалт төлөвлөлтийн) байна.

Европын хүний эрхийн хороо Голландын захиргааны хэргийг шийдвэрлэж байсан тогтолцоог мэргэжлийн биш гэж үзсэн нь тогтолцоог шийдвэртэй өөрчлөхөд хүргэжээ. Ингээгүй бол энэ өөрчлөлт хийгдэхгүй байж болзошгүй байлаа.

Захиргааны Ерөнхий хуулийг баталсан нь захиргааны тушаалын талаархи гомдлыг захиргааны шүүхэд гаргах боломжийг нээжээ. Одоогоор дүрэм журамтай холбогдсон гомдлыг захиргааны шүүхэд гаргах боломжгүй боловч иргэний шүүх эдгээр гомдлыг хянах боломжтой гэж үздэг. Шаардлагатай тохиолдолд шүүх нь эдгээр шийдвэрийг захиргааны зохистой зарчмыг баримтлан шийдвэрлэдэг. Мэдээж захиргааны тодорхой шийдвэрийг хянах үед тэдгээр шийдвэрийг гаргах үндэслэл болсон дүрэм журмыг хянах нь тодорхой юм. 1999 оноос эхлэн Захиргааны ерөнхий хуулийн IV А заалтын дагуу дүрэм журамтай

холбогдолтой гомдлыг шууд захиргааны шүүхэд өгөх болжээ.

Зохистой захиргааны ерөнхий зарчим, эрх зүйн хамгаалалт

ЗЗЕЗ талаас авч үзвэл Голландад захиргааны эрх зүйн хамгаалалт нь захиргаанаас өөрөөс нь үүдэлтэй. Захиргааны гомдол нь зөвхөн шүүхийн үзэл бодлоор биш мөн шийдвэр гаргасан захиргааны байгууллагын бодлогыг харгалзан шийдвэрлэгддэг. Шаардлагатай бол Хаан нь доод шатны захиргааны байгууллагын шийдвэрийг өөрчлөхөөс түдгэлзэдэггүй байв. Хаан нь энэ шийдвэр гаргасны төлөө улс төрийн хариуцлага хүлээдэг байсан учир үүнийг хийх боломжтой байв. Энэ нь өөрийн гэсэн ардчилсан эрх зүйн үндэслэлтэй. Ихэнх тохиолдолд гомдлыг дээд шатны захиргааны байгууллага нь шийдвэрлэдэг. Иймд захиргааны тушаалыг хянахдаа шүүхийн үндэслэл болон асуудлыг хянаж байгаа захиргааны байгууллагын бодлогод үндэслэсэн үндэслэлийг хэрэглэж болдог байсан.

Захиргааны эрх зүйн хамгаалалт нь захиргааны шүүхэд тогтвортой байжирсэн. Аяндаа энэ нь захиргааны байгууллага болон иргэний шүүхийн хяналтаас давамгайлжээ. Захиргааны шүүх нь эхэндээ зөвхөн хязгаарлагдмал хүрээний, санхүүгийн асуудлыг гуравдагч тал гомдол гаргах эрхгүй нөхцөлд /татвар, нийгмийн даатгал, төрийн албан хаагчдын/ шийдэж байлаа.

Аж үйлдвэрийн байгууллагын гомдлын шүүх, Төрийн зөвлөлийн шүүхийн хэлтэс нь /1976/ нийтээр дагаж мөрдөх биш зөвхөн тодорхой хувь хүнтэй холбогдолтой захиргааны бичмэл тушаалтай холбогдсон гомдлыг шийдэж байжээ. Нийтлэг шинжтэй бүх тушаал тэдгээрийн шийдвэрлэх асуудлын харьяалалд

багтдаггүй байв. (Тухайлбал, газар ашиглалтын төлөвлөгөө, настай хүмүүсийг халамжлах төлөвлөгөө г.м.) Хаантай харьцуулах юм бол шүүхийн шийдвэрлэх асуудал нилээд хязгаарлагдмал болсон бөгөөд тэдгээрийн эрх мэдэл нь зөвхөн шүүхийн хяналтаар хязгаарлагдана.

ЗЗЕЗ нь мэргэшсэн захиргааны шүүх болон иргэний шүүх захиргааны хэргийг шийдвэрлэхтэй холбоотой хөгжсөн байна.

Дэлхийн 2 дугаар дайны өмнө давж заалдах шатны ерөнхий шүүх зарим төрийн албан хаагчдын цалингийн тухай хуулийг буцааж хэрэглэх зарчмыг хэрэглэн бууруулсантай холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ эрх зүйн хувьд тодорхой байх зарчмыг тогтоожээ. Захиргааны байгууллагын асуудлыг үзэмжээрээ шийдвэрлэх эрх мэдэл өсөхийн хэрээр болон хөгжингүй нийгэмд төр тогтохын хэрээр шүүхэд төрийн хуулийн этгээдийн эрх зүйн актыг хянах арга хэрэгсэл дутагдах байдалтай тулгардаг.

Эхний үедээ захиргааны байгууллага ноёлж байлаа. Дэлхийн 2 дугаар дайны дараа орон сууцыг хуваарилахтай холбогдолтой асуудлыг шүүхээр хянах явцад ихэнх материаллаг зарчмуудыг тогтоосон байна. Дээд шүүх эдгээр бүрхэг хэм хэмжээг ёс зүйн хэм хэмжээтэй хослуулан хэрэглэхийг захиргааны байгууллагад ойлгуулснаар асуудлыг өөрийн үзэмжээр шийдвэрлэх захиргааны байгууллагын эрх мэдлийг хязгаарлажээ. Нэгэнт зам нээгдсэн учир бусад шүүхүүд ч зарчим тогтоож эхэлсэн. Хаан хүртэл захиргааны гомдлыг хэлэлцэхдээ Дээд шүүхийн чиглэлийг баримталж байлаа.

Зохистой захиргааны ерөнхий зарчмын шинж тэмдэг

Шүүхийн хяналтын стандартын нэгэн адил ЗЗЕЗ нь захиргааны байгууллагын үйлдлийн бичигдээгүй эрх зүйн стандарт болдог. ЗЗЕЗ нь эрх зүйн бүрхэг хэм хэмжээ юм. Эдгээр нь хууль тогтоомжийн нэгэн хэсэг бөгөөд захиргааны байгууллага болон төрийн бусад байгууллагын зан үйлдлийн маш бүрхэг хэм хэмжээг тогтоодог. Цаашид эдгээр нь яам, хотын захиргаа, төрийг хамарсан төрийн байгууллагын бүх актад хэрэглэгдэнэ.

ЗЗЕЗ нь захиргааны байгууллагын ажилтнууд болон төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээнээс ялгаатай юм. Зан үйлдлийн ёс зүйн хэм хэмжээ нь захиргааны байгууллагын ажилтнууд болон төрийн албан хаагчид өөр хоорондоо болон иргэдтэй харилцах харилцааг зохицуулдаг. Тэдгээр нь нийгмийн харилцан үйлдэлтэй холбоотой. Тэдгээрийн ихэнхийг шүүхээр хамгаалах боломжгүй. Тухайлбал иргэний асуудлыг шийдэж өгөхийн тулд захиргааны албан тушаалтан, төрийн албан хаагч түүнийг 3 цаг хүлээлгийн танхимд хүлээлгэх нь хуулийг зөрчсөн хэрэг болох уу? Эсхүл төрийн албан хаагч цайны газар байгуулах лицензийн нөхцлийг хэлэлцэж байгаад уурлаж өргөдлийг буцаахаар заналхийлэх нь хууль ёсны үйлдэл үү? Эдгээр үйлдэл нь хууль зөрчсөн үйлдэл болохгүй л болов уу. Гэхдээ тэдгээрийг зан үйлдлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж шүүж болно.

ЗЗЕЗ нь төрийн байгууллагын шинж тэмдгийг агуулсан эрх зүйн этгээдийн шийдвэр гаргах журмыг тогтоодог. Эдгээр нь захиргааны тушаалыг шүүхээс хянах хэм хэмжээ болно. Мөн захиргааны албан тушаалтан, төрийн албан хаагчийн зан үйлдэлтэй холбогдсон гомдлыг

омбудсман шалгахад ёс зүйн хэм хэмжээг үндсэн шалгуур болгож хэрэглэдэг.

ЗЗЕЗ болон ёс зүйн хэм хэмжээ нь аналитик ялгаатай боловч хоорондоо холбоотой байдаг. Тухайлбал, ёс зүйн хэм хэмжээ зөрчих нь ЗЗЕЗ зөрчигдөхөд зайлшгүй хүргэдэг.

Тухайлбал захиргааны байгууллага газар ашиглалтын зориулалтыг өөрчлөхөөр шийдвэрлэж, энэ газар нь захиргааны байгууллагын ямар нэгэн албан тушаалтны өмчлөлд байна гэж үзье. Захиргааны байгууллагын ажилтан өөрөө энэ шийдвэрийг гаргахад оролцох юм бол ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн хэрэг болно. Учир нь захиргааны албан тушаалтан өөрийн сонирхлыг нийтийн ашиг сонирхолтой хольж хутгах ёсгүй. Энэ шийдвэр захиргааны албан тушаалтан эсхүл өөр ямар нэгэн этгээдийн ашиг сонирхолд нийцсэн байвал шударга зарчимд нийцэхгүй

Зохистой захиргааны ерөнхий зарчим тэдгээрийн агуулга***Эрх мэдлээ зүй бусаар хэрэглэхийг хориглох***

Эрх мэдлээ зүй бусаар хэрэглэхийг хориглосон зарчим нь захиргааны байгууллага болон хуулийн бусад этгээд өөрийн эрх мэдлийг хуульд заасан зорилгоос бусад зорилгоор хэрэглэх ёсгүй гэсэн үг. Голландыг 1945 онд чөлөөлснөөс хойш орон сууц маш их дутагдалтай байв. Үүнтэй холбогдон 1947 онд орон сууц хуваарилах тухай хууль гаргасан. Энэ нь орон сууцыг зохистой хуваарилах зорилгоор гаргасан хууль юм. Хотын захирагч өмчлөгч болон түрээслэгчээс орон сууцаа түрээслэхийг шаардах эрхтэй гэж хуульд заажээ. 1947 онд Зандвуурт хотын захирагч өөрийн байгууллагад ажилладаг цагдаагийн ажилтан Дуумад зориулж орон сууц

болон зуны байр олгохыг шаардсан байна. Шаардлага өгсөн үндсэн шалтгаан нь түрээсийн хөлс хэт өндөр байгаатай холбоотой. Энэ хот нь аялал жуулчлалын хот байсан бөгөөд зуны байрыг нь өөр хүмүүс түрээсэлдэг. Байрны өмчлөгч энэ байдлаас болж өөрийн байрыг илүү өндөр үнээр түрээслэх боломжгүй болсон учраас шүүхэд ханджээ. Голландын дээд шүүх хэргийг хэлэлцээд хотын захирагчийн шийдвэр нь байр хуваарилах зорилгогүй, харин өөрийн ажилтны түрээсийн төлбөрийг бууруулахтай холбоотой байсан гэж үзээд, хотын захирагч эрх мэдлээ зүй бусаар хэрэглэсэн гэжээ. Мэдээж энэ нь хууль ёсны байх зарчмаас үүдэлтэй юм. Энэ зарчмыг Голландын захиргааны хуульд тусгаж, Захиргааны байгууллага нь өөрт олгосон зорилгоос өөр зорилгоор эрх мэдлээ хэтрүүлэх ёсгүй гэж үзжээ..

Дур зоргоор авирлахыг хориглох

Дур зоргоор авирлахыг хориглосон зарчим нь ашиг сонирхлын тэнцвэрийг хангана гэсэн үг. Энэ нь вохистой захиргааны үндсэн зарчмуудын нэг нь юм. Энэ зарчмыг шүүх хэрэглэхдээ хязгаарлагдмал хүрээнд захиргааны шийдвэрийг хянана. Өөрөөр хэлбэл шүүх захиргааны байгууллагын ноцтой алдааг л хүчингүй болгодог.

Энэ зарчмыг бас нэг хэргийн жишээ нь дээр авч үзэж болно. 1947 онд Дотинчем хотын дарга нэг байрны 4 өрөө болон угаалгын өрөөг түрээслүүлэхийг шаарджээ. Гэтэл тэр байрны өмчлөгч болох эхнэр, нөхөр хоёр нь хоёул өвчтэй байсан бөгөөд эмч тэр гэр бүлийг бусдаас тусдаа амьдарч байгаа нөхцөлд сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэхгүй байхыг зөвшөөрсөн байв. Дээд шүүх байрыг түрээслүүлэх шаардлагыг дур зоргоор гаргасан гэж тогтоох юм бол тэр шийдвэр нь хууль бус болно гэжээ.

Шүүх хэргийг авч хэлэлцээд хэрэв хотын захирагч иргэдийн ашиг сонирхлыг анхаарч үзсэн бол ийм шийдвэр гаргахгүй байсан. Мөн бусад иргэдийн ашиг сонирхлыг анхаарч үзвэл үр дүн нь эсрэг шийдвэр гарах боломжтой учраас хотын захирагчийг хууль зөрчөөгүй гэж үзжээ.

Дур зоргоороо авирлахыг хориглосон зарчмыг Голландын Захиргааны Ерөнхий хуульд тусгаж, Захиргааны байгууллага тушаал гаргахдаа шууд ашиг сонирхлыг харгалзан үзэх ёстой гэжээ.

Болгоомжтой байх зарчим

Энэ зарчмын утгыг эцэслэн тодорхойлоогүй байна. Гэвч энэ нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг зарчим юм. Болгоомжтой байх гэдэг нь захиргааны байгууллага тушаалын төслийг бэлтгэхдээ маш болгоомжтой хандах ёстой гэсэн үг. Энэ нь төрийн захиргааны байгууллага асуудлыг шийдвэрлэхийн өмнө зохих мэдээллийг цуглуулсан байдаг. Түүнчлэн:

- хэргийг шалгаж асуудлыг шийдвэрлэхэд хэрэгцээтэй мэдээллийг олж авсан байх,

- сонирхогч талуудад шийдвэрлэх гэж байгаа асуудлын талаар нэмэлт мэдээллийг өгөх боломж, асуудлыг хэлэлцэх журмын дагуу бүрдүүлсэн байх,

- холбогдох баримт болон ашиг сонирхлыг зөв тодорхойлсон байх.

- Хэргийг шалгаж асуудлыг шийдвэрлэхэд хэрэгцээтэй мэдээллийг олж авсан байх.

Сүү, бяслаг, өндөг үйлдвэрлэгчдийн байгууллага нь нэг фермерийн тушаасан сүүний хэмжээг бууруулж тооцжээ. Учир нь тэр хүн нь хөршөөсөө 20000 литр сүү худалдан авсан байсан тул түүнийг татвараас зайлсхийх оролдлого хийсэн гэжээ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний

хяналтын газар түүний санхүүг шалгаад тэр хөршөөсөө 20000 литр сүү худалдаж авсан нь үнэн байна гэж тогтоогоод тэр сүүгээр тугалаа угжсан бөгөөд 20000 литр сүүг өөрийн үйлдвэрлэсэн сүүний хэмжээнд оруулж бүртгүүлээгүй гэсэн татгалзлыг үл тоомсорлосон гэжээ. Аж үйлдвэрийн давж заалдах шатны шүүх энэ асуудлыг авч хэлэлцээд фермерийн татгалзлыг судалж үзээгүй учраас зохистой мэдээллийг судлаагүй гэсэн үндэслэлээр захиргааны шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Хотын захирагч болон дүүргийн захирагч нь ноён Бломын өмчлөлд байсан байшинг түүхэн ач холбогдолтой объектын жагсаалтад Түүх, соёлын дурсгалт зүйлийн тухай хуулийн дагуу оруулсан байна. Блом үүнийг эсэргүүцэж гомдол гаргажээ. Гомдлыг шийдвэрлэхдээ хотын захиргаа шийдвэрийг хэвээр үлдээж түүх соёлын дурсгалт байрны тодорхойлолтыг өөрчилсөн. Тэдгээрийн бодлоор зөвхөн шинжээчийн шийдвэрээр л энэ жагсаалтыг өөрчилдөг. Блом шинээр бичсэн тодорхойлолт зохих журмын дагуу бичигдээгүй гэсэн байр суурийг баримталсан байна. Төрийн зөвлөлийн шүүхийн хэсэг асуудлыг шийдвэрлэхдээ хотын захирагч эрх мэдлийнхээ хүрээнд ажилласан харин Бломд зөвлөлгөө авах бодитой хугацаа олгоогүй гэж үзжээ. Тэд Бломд шинэ зөвлөгөөг 2 дугаар сарын 22-нд илгээгээд 25-нд шийдвэрээ гаргажээ. Өөрөөр хэлбэл Бломд асуудлыг шийдвэрлүүлэхэд оролцох боломж олгогдоогүй. Энэ нь шийдвэр гаргахад болгоомжтой хандах зарчмыг зөрчсөн гэж ээ. Энэ зарчмыг Голландын Захиргааны Ерөнхий хуульд тусгасан байдаг.

Захиргааны байгууллага нь шийдвэр гаргахын өмнө сонирхогч талд тайлбар гаргах боломж олгох

ёстой: Хэрэв,

-шийдвэр нь тухайн этгээдэд хамааралтай бодит баримт, ашиг сонирхолд тулгуурласан байвал,

-энэ мэдээллийг сонирхогч этгээдээс өөрөөс нь аваагүй бол

Тахир дутуу хүмүүст тэтгэмж олгох тухай сайдын тушаал гарсан учраас Утрихт хотын зөвлөл тахир дутуу хүмүүс шилжин суурьшихтай холбогдсон тэтгэмж олгох тухай шийдвэр гаргажээ. Хотын захирагч нь эрүүл мэндийн комиссын зөвлөгөөний дагуу шийдвэр гаргажээ. Мөн тахир дутуу иргэн шилжин суурьшсантай холбогдож тэтгэмж авах хүсэлт гаргасан байна. Эрүүл мэндийн комисс татгалзсан зөвлөгөө өгсөн учраас түүнд эхний удаа тэтгэмж олгохоос татгалзжээ. Тахир дутуу иргэн энэ шийдвэрийг зөвшөөрөөгүй учраас эрүүл мэндийн комиссоос дахин зөвлөлгөө авсан. Эрүүл мэндийн комисс тухайн иргэн ямар ч зөвшөөрөлгүй сайн дураараа онцын шаардлагагүй өөр газар шилжсэн учраас тэтгэмж олгохгүй гэсэн шийдвэр 2 дахь удаагаа өгсөн байна. Гомдол гаргагч маргааныг төрийн зөвлөлийн шүүхийн хэсэгт давж заалджээ. Хотын захирагч эрүүл мэндийн комиссын шийдвэрийг дагасан гэсэн бол гомдол гаргагч эрүүл мэндийн комисс түүнд ямар ч үзлэг хийгээгүй гэж мэдүүлсэн бөгөөд тэр өөрийн эмчийн зөвлөснөөр өөр газарт шилжсэний дараа тэтгэмж хүссэн гэж мэдүүлдэг. Хотын захирагч захиргааны шийдвэр гаргахын өмнө эрүүл мэндийн комиссын шийдвэр үндэслэлтэй эсэхийг хянах ёстой байсан гэж үзсэн учраас шийдвэрийг хүчингүй болгожээ.

Захиргааны Ерөнхий хуульд шийдвэр гаргахад болгоомжтой хандах зарчмыг тусгаж, болгоомжтой хандах заалтын бусад хэсэг мөн хуульд

тусгалаа олсон байна.

Үндэслэлтэй байх зарчим

Үндэслэлтэй байх гэдэг захиргааны шийдвэрийг ямар учраас гаргасан үндэслэлийг тайлбарласан байхыг хэлнэ. Энэ нь захиргааны байгууллага иргэдийн хоорондын харилцаатай холбоотой. Захиргааны байгууллага нь иргэдэд хуулийн хүрээнд юу хийж болох, юу хийж болохгүйг ойлгуулсан байх ёстой.

Захиргааны тушаалыг хүмүүс эсхүл байгууллага биелүүлэх учраас тэдгээрийг тайлбарлах нь хэд хэдэн чиг үүрэгтэй. Нэгдүгээрт, холбогдох талуудад шийдвэр гаргасан үндэслэлийг мэдэжлэнэ. Үндэслэл нь хэрэгжиж байгаа шийдвэр, бодит баримт, ашиг сонирхол, тэдгээрийн тэнцвэрт байдал зэргээс бүрдэнэ. Эдгээр шалтгааныг тайлбарлаагүй нөхцөлд талууд шийдвэрийг хүлээж авахад хүнд байдаг. Хоёрдугаарт, үндэслэлийг мэдэхгүйгээр үүрэг хүлэсэн тал түүнээс татгалзах, гомдол гаргах боломжгүй. Гуравдугаарт, энэ үндэслэлээс захиргааны цаашдын бодлогыг тодорхойлох боломжтой болно. Захиргааны шийдвэрийг үндэслэх нь шийдвэрийн нэг бүрэлдэхүүн хэсэг болдог. Нэг эмэгтэй хүүхдийнхээ овгийг өөрчлөх өргөдлийг Хууль зүйн яамандаа өгчээ. Гэтэл өргөдөл өгөх журмыг баримтлаагүй гэсэн үндэслэлээр түүний өргөдлийг хүлээн авахаас татгалзжээ.

Төрийн зөвлөлийн шүүхийн хэсэг захиргааны шийдвэрт ямар үндэслэлээр гомдлыг хүлээн авахаас татгалзсан тухай заагаагүй гэсэн үндэслэлийг баримталжээ..

Шийдвэрт түүний үндэслэлийг заах зарчим Захиргааны Ерөнхий хуульд тусгагдсан байна.

Шударга байх зарчим

Шударга байх зарчим нь ямар ч хуулийн этгээд (төрийг төлөөлөх) сонирхогч этгээдийн процедурын боломжид саад учруулах ёсгүй гэсэн утгыг илэрхийлнэ.

Шар айрагны барны эзэн тухайн бар байрлаж байсан байшинг худалдаж авахыг хүсээд, болгоомжтой хүн байсан учраас өөрийн хийх гэж байгаа ажлыг хийж болох эсэхийг хотын захиргааны холбогдох хүмүүсээс лавлажээ. Барны эзэн зохих лицензтэй байсан боловч өөрийн тавьсан асуултад хариу өгөхийг удаан хугацаанд хүлээсэн байна. Энэ үед хотын байцаагч төрийг төлөөлж уг байшинг худалдаж авчээ. Учир нь энэ газар дээр зам барихаар төлөвлөж байв. Хотын захиргаанд энэ байшинг худалдаж авах нь дараа нь өмчлөгчид хохирол төлөхөөс хямд туссан юм.

Хотын захиргаа нь барны эзэнд зохистой мэдээлэл авсны үндсэн дээр шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх ёстой. Тухайн иргэний мэдээлэл авах эрх нь төрийнхтэй ижил байх ёстой.

Шударга байх зарчмыг Захиргааны Ерөнхий хуульд тусгасан байна. Үүнд:

- Захиргааны байгууллага үүргээ ялгаваргүй гүйцэтгэнэ.

- Захиргааны байгууллагад ажиллаж байгаа этгээд хувийн ашигсонирхлоо хөндсөн шийдвэр гаргахад оролцох ёсгүй.

Эрх зүйн хувьд тодорхой байх

ЗЗЕЗ-ын "Эрх зүйн тодорхой байдал" нь эрх зүйт төрийн зорьдог "тодорхой байдлаас" ялгаатай. Эрх зүйт төрийн зорилго болгодог эрх зүйн тодорхой байдал нь нийгмийн тогтвортой байдлын тухай хуулийн үзэл баримтлал юм. Захиргааны шийдвэрийн үндэслэлтэй байх зарчим нь түүний процедур сонирхогч

талуудын хувьд тодорхой бол, эрх зүйн тодорхой байдал нь сонирхогч талуудын материаллаг ашиг сонирхол тодорхой байдагт оршино.

Хэрэв багш 18 сарын турш өвчтэй байсан бол түүний цалинг 80 хувиар бууруулах шийдвэр хотын захиргаа гаргажээ. Хотын захиргаа тухайн багшийн цалинг өгснөөс хойш 1 жилийн дараа илүү олгосон цалинг буцааж төлөхийг шаардсан байна. Хотын захиргаа ийм удаан хугацаа өнгөрсний дараа цалинг нэхэмжилснээ компьютерийн алдаатай холбож тайлбарласан. Давж заалдах шатны шүүх тухайн багш илүү цалин авснаа мэдэх боломжтой байсан эсэхийг авч үзээд эрх зүйн хувьд тодорхой байх зарчим мөрдөгдөөгүй учраас хотын захиргааны шийдвэрээс татгалзжээ.

Захиргааны Ерөнхий хуульд энэ зарчим тусгагдаагүй байна.

Хууль ёсны горьдлого

Эрх бүхий байгууллага нь өөрийн бий болгосон эрх зүйн горьдлогыг хэрэгжүүлэх ёстой. Эрх зүйн горьдлого яаж бий болдог арга замуудыг авч үзэх нь чухал юм. Энэ нь хуулийн субъектүүдэд өгсөн мэдээлэл, ижил төстэй асуудлыг шийдвэрлэсэн байдал, бодлогоо нийтэд хүргэсэн байдалтай холбоотой байна. Гэхдээ энэ нь тодорхой бус, захиргааны туйлбаргүй бодлогыг хэрэгжүүлэх аргыг өөрчлөхгүй гэсэн үг биш.

Хөгжлийн тусламжийн яам парламентад Суринамын оюутнууд тусламж авах эрхтэй гэсэн захидал илгээжээ. Гэвч Боловсролын яам оюутнууд сургуулиа орхисон учраас энэ тусламжийг олгохгүй гэсэн хариу өгөв. Төрийн зөвлөлийн шүүхийн хэсэг асуудлыг хэлэлцээд захиргааны шийдвэрт сургуулиа орхисон бол тусламж үзүүлэхгүй гэж анх удаа

заасан. Энэ байр сууриа Боловсролын яам өмнө нь нэг ч мэдээлээгүй бөгөөд оюутнуудад тусламж олгох тухай хуульд заагаагүй учраас энэ нь хууль ёсны горьдлогын зарчмыг зөрчиж байна гэж шийдвэрлэжээ.

Энэ зарчмыг Захиргааны Ерөнхий хуульд тусгаагүй байна.

Тэгш хандах зарчим

Тэгш хандах зарчимд ижил хэргийг адил шийдвэрлэх гэж илэрхийлсэн. Энд үүсэх гол хүндрэл нь ямар хэргийг ижил гэж үзэх, ийм хэргийг ямар төлдөөр нь өөр гэж ангилах зэрэг болно. Тодорхой хэргийг ижил гэж нотлох маш хэцүү байдаг.

Хотын захирагч нэгэн иргэний цэцэрлэгийн хашаа хэт өндөр байгаа учраас түүнийгээ намхан болго гэсэн тушаал гаргажээ. Хариуцагч ийм гомдол өмнө нь олон гарсан боловч нэг ч иргэнд хаашаагаа буулгах эсхүл намсгах тухай захирамж өгөөгүй гэжээ. Ийм хэрэг нь гомдлоор үүсэх хэрэг байв. Хэрэг гомдлоор үүссэн. Гэвч цэцэрлэгийн эзэн өмнө нь гомдол гаргасан этгээдийг нэрлэж чадаагүй учраас хэрэг нь өмнөх хэргүүдтэй адил гэдгийг нотолж чадаагүй бөгөөд шүүх түүний татгалзалыг хүлээж аваагүй байна. Гэвч тэгш хандах зарчим нь Голландын захиргааны хуульд чухал үүрэгтэй байдаг. Тэгш хандах зарчим нь олон улсын гэрээний зарчим бөгөөд Голландын Үндсэн хуульд тусгагдсан, харин Захиргааны Ерөнхий хуульд тусгагдаагүй байна.

Тэнцвэртэй байх зарчим

Тэнцвэртэй байх зарчим нь захиргааны шийдвэр тавьсан зорилгодоо тэнцвэртэй байх утгыг илэрхийлнэ. Жишээ нь иргэн сүүдрэвч хууль бусаар барьсан бол заавал түүнийг бульдозер авчирч нураах шаардлагагүй. Захиргааны

байгууллага нэгдүгээрт, тухайн сүүдрэвчийн эзэнд мэдэгдэл өгвөл зохино. Хэрэв зөрчлийг арилгахгүй бол торгууль ногдуулах тухай хэлж сануулах хэрэгтэй. Тэнцвэртэй байх зарчим Захиргааны Ерөнхий хуульд тусгалаа олсон байна.

Зохистой захиргааны ерөнхий зарчмын гүйцэтгэх чиг үүрэг

ЗЗЕЗ нь хоёр үндсэн чиг үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээр нь захиргааны байгууллага бусад хуулийн этгээдийн зан үйлдлийн дүрмийг тогтоодог. Иймд тэдгээрийг захиргааны байгууллагаас анхан шатны болон давж заалдах шатны журмаар шийдвэр гаргахад хэрэглэнэ. Эдгээрийн ихэнх нь Голландын захиргааны Ерөнхий хуульд тусгалаа олжээ. Үүрэг хүлээлгэсэн шийдвэрийг хэрэгжүүлэхийн өмнө сонирхогч этгээдэд энэ асуудлаар өөрийн санаагаа илэрхийлэх боломж олгох ёстой. Энэ нь болгоомжтой хандах зарчмын нэг хэсэг юм.

Асуудлыг шүүхийн журмаар хэлэлцэхэд ЗЗЕЗ-ыг мөн хэрэглэдэг. Энэ зарчмууд нь ихэвчлэн захиргааны журам болон захиргааны шийдвэрийн агуулгатай холбоотой байдаг. Жишээ нь тухайн тохиолдолд захиргааны шийдвэр үндэслэлгүй байна уу эсхүл захиргааны албан тушаалтан дур зоргоороо авирласан уу гэдгийг шүүх өөрийн үзэмжээр шийдвэрлэдэг.

Шийдвэр гаргах процесс болон ЗЗЕЗ

Голландын эрх зүйн боловсролын тогтолцоонд аналитик аргаар ЗЗЕЗ-тай холбогдсон хэргийг тайлбарлах арга зүй тогтсон байна. Зарчмыг процессийн үе шат тус бүртэй холбож тайлбарлахад илүү ойлгомжтой болдог.

ЗЗЕЗ-ын ихэнх нь Захиргааны Ерөнхий хуульд тусгагдсан гэвч зарим

зарчмын хоорондох зааг хязгаар нь бүрхэг байдаг. Жишээ нь захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа бүх талуудын хөндөгдөж болох ашиг сонирхлыг авч үзээгүй бол асуудлыг шийдвэрлэхдээ болгоомжтой хандах зарчмыг зөрчихөд хүрнэ. Мөн тушаалын агуулга нь албадсан шинжтэй учир асуудлыг шийдвэрлэхдээ болгоомжтой хандаагүй гэж үзэж болно.

Зарим эрдэмтэд дээр дурдсанаас олон зарчмыг ч гаргаж ирдэг. Энэ нь эрх зүйн тогтолцоогоо нийгмийн өөрчлөлтөд тохируулах гэхдээ уян хатан байдлыг эрх зүйн хувьд тодорхой байх явдалтай хослуулах оролдлого хийхэд зайлшгүй тулгарна.

Шийдвэр гаргах процессийг дөрвөн үе шатанд хувааж болно:

- бэлтгэлийн,
- ашиг сонирхолыг тэнцвэржүүлэх,
- шийдвэрийн агуулгыг тодорхойлох,
- энэ агуулгыг бусдад мэдээлэх.

Бэлтгэлийн үе шат

Шийдвэр гаргах эхний шатанд захиргааны байгууллага урьдаас асуудалд субъектив хандсан байх ёсгүй. Ийм учраас шударга байх зарчим чухал юм. Бэлтгэлийн үе шатанд гурван үндсэн дүрэм үйлчилнэ:

- Сонирхогч этгээд процессд оролцоход ямар нэгэн саад учруулах ёсгүй /шударга байх/,
- Асуудлыг нарийвчлан судалж холбогдох мэдээллийг цуглуулсан байх /болгоомжтой хандах/,
- Шийдвэр гаргахын өмнө сонирхогч этгээдэд өөрсдийн ашиг сонирхол, санаа зовоосон зүйлийн талаар захиргааны байгууллагад мэдээлэх боломж олгох /болгоомжтой хандах/,
- Холбогдох баримт, ашиг

сонирхолыг зохистойгоор тогтоох. /
болгоомжтой хандах/

Энэ үе шатанд шударга байх
болон болгоомжтой хандах зарчим
үйлчилнэ. Мэдээжийн хэрэг
захиргааны байгууллага нь хуулийн
дагуу ажиллах ёстой. Өөрөөр хэлбэл
холбогдох хууль, дүрмийг судлах нь
бэлтгэл үе шатын нэг хэсэг болно.

Ашиг сонирхолыг тэнцвэржүүлэх

Өргөдөл гаргасан тохиолдолд
захиргааны байгууллага нь өргөдөл
гаргагч, улсын болон гуравдагч
этгээдийн ашиг сонирхол хэрхэн
хөндөгдөж болохыг “жигнэж” үзсэн
байх ёстой. Ийнхүү жигнэхдээ
холбогдох талуудын байр суурийг
мэдэх, одоогийн хэрэг өмнөх хэрэгтэй
ямар холбоотой. Захиргааны
байгууллага энэ асуудлаар ямар
бодлого баримталж байгаа, Төрийн
албан хаагч аль нэг талд амлалт өгсөн
эсэх /хууль ёсны горьдлого/
Захиргааны байгууллагын чухал гэж
үзсэн ашиг сонирхол тодорхой
хуулийн зорилгод нийцэж байгаа эсэх
/эрх мэдлээ буруу ашиглах/ зэрэг олон
асуудлыг авч үзнэ.

Дүрмийн агуулга

Ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх
нь дүрмийн агуулгыг тодорхойлоход
чухал ач холбогдолтой байдаг. Учир нь
ашиг сонирхолыг жигнэсний үр дүнд
агуулгыг тодорхойлдог. Гэхдээ
агуулгад шууд хамааралтай хоёр
зарчим нь тэгш хандах болон эрх зүйн
тодорхой байдал юм. Тэгш хандах
гэдэг нь ижил хэрэгт адил шийдвэр
гаргана гэсэн үг юм. Эрх зүйн
тодорхой байдал нь захиргааны
тушаалыг буцааж хэрэглэхгүй гэсэн
агуулгаар хэрэглэгдэнэ.

Шийдвэрийг бусдад хүргэх

Захиргааны тушаалын агуулга,
түүнийг гаргах болсон шалтгааныг

нийтэд мэдээлээгүй нөхцөлд
захиргааны байгууллага үйл
ажиллагаагаа явуулах боломжгүй. Энэ
үе шатанд шийдвэрийн үндэслэлийг
гаргах нь чухал юм. Сонирхогч
талуудад болон нийтэд гарсан тушаал,
түүний утга агуулга, үндэслэл болсон
хууль, ашиг сонирхолыг хэрхэн үнэлж
үзсэн талаар мэдэгдвэл зохино. Эдгээр
мэдээлэлгүйгээр талууд өөрсдийн ашиг
сонирхолыг хамгаалахад хүндрэлтэй.
Иймд захиргааны шийдвэрийн
үзэглэсэн хувийг сонирхогч талуудад
илгээх шаардлага бий болно.

Дүгнэлт

Энэ нийтлэлдээ Голландын
захиргааны хуулийн хөгжил болон
ЗЗЕЗ ямар утга агуулгаар
боловсруулагдсаныг тодорхойлов.
Голландын захиргааны хуулийг
шүүхийн шийдвэртэй холбож ойлгоход
илүү хялбар байдаг. Голландын
захиргааны шүүхийн эрх мэдэл байнга
өргөжих хандлагатай хөгжсөн байна.
Үүний нэг хэсэг шүүхээс захиргааны
ерөнхий зарчмуудыг тогтоосонтой
холбоотой.

Шүүхүүд өөрийн эрх мэдлийг
ЗЗЕЗ шинээр тогтоох болон
хэрэглэхэд ашигладаг. Тэдгээр нь
захиргааны шийдвэрийг өргөн эсхүл
хязгаарлагдмал хүрээнд хянахаа
өөрсдөө сонгоно. Ийм учраас
захиргааны байгууллагууд шүүхээс
ямар шийдвэр гарах вэ гэдгийг
таамаглах боломжгүй. Захиргааны
байгууллага болон шүүхийн
хоорондох хурцадмал байдал цаашид
ч хадгалагдах төлөвтэй. Энэ хурцадмал
байдал нь нэг талаасаа нийгмийн
зүгээс асуудалд ардчилалтай уян хатан
хандах шаардлага болон нөгөө
талаасаа эрх зүйн тодорхой байдалтай
байх шаардлагаас үүдэн гарсан бөгөөд
Голландын захиргааны хуулийн
цаашдын хөгжилд хувь нэмрээ
оруулна.

ГАЗРЫН ЭЗЭН, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

Төр, эрх зүйн шинжлэх ухааны Академийн
Ерөнхийлөгч, академич, МУИС-ийн тэргүүлэх профессор,
Хууль зүйн шинжлэх ухааны доктор Т.Сэнгэдорж

Газар гэдэг ойлголтын тухайд

Газар бол хөдөлмөрийн үр дүн биш, харин байгалийн бүтээгдэхүүн, хүнээс өмнө бодитойгоор оршиж байсан, өөрийн мөн чанар, зүй тогтол, хувьсал өөрчлөлттэй, экологийн тулгуур объект болдгийн хувьд биологийн бусад төрөл, зүйл түүнээс олонтаа шалтгаалдаг, өвөрмөц төрх байдал, химийн найрлага бүхий хатуу биет юм. Газар нь нийгмийн оршин тогтнох, аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийн хэрэгсэл, хөдөлмөрийн түгээмэл нөхцөл, үнэ цэнтэй капитал мөн. Тэр нь аливаа баялагийн анхны эх булаг бөгөөд зөв харьцаж чадвал үр шимээ байнга өгдөг, бидний сэтгэхүйд үргэлж өртөж байдаг, танин мэдэхүйн өвөрмөц объект мөн.

Ер нь шинжлэх ухаанд газрыг 3 янзаар үздэг. Үүнд:

1. Газар бол газрын хэвлий, дээд давхарга, ландшафт зэргийг багтаасан газрын ертөнц, газрын бүрхэвч;
2. Бүхий л нутаг дэвсгэрт;
3. Ертөнцийн гадаргуу, хөрс гэсэн утгыг хадгалдаг².

Тэгвэл эрх зүйн үүднээс газар гэдэгт:

- газрын гадаргуу;
- газрын хөрс;
- ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг ойлгодог³.

¹ В.В.Петров. Экологическое право. М.,1995, с25

² Газрын тухай Монгол Улсын хууль. 2002 он, 3 дугаар зүйл

³ БОЯ, Газрын бодлогын хүрээлэн. Газрын сангийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал УБ.,1995 он, 7 дахь тал

Үүнээс үзэхэд шинжлэх ухааны ойлголтоор газрыг өргөн хүрээнд, эрх зүйн үүднээс явцуу утгаар тодорхойлжээ. Энэхүү тодорхой утга нь газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын хүрээг тодорхойлоход арга зүйн ач холбогдолтой.

Монгол Улс ямар хэмжээний газартай вэ?

Монгол Улс 1 сая 564 мянган ам. километр нутагтай ба энэ нь дэлхийн газрын гадаргуугийн 0.31 хувийг эзэлдэг. Монгол газрынхаа хэмжээгээр дэлхийд 17 дугаарт, нэг хүнд ногдох газрын хэмжээгээр нэгдүгээрт ордог. Хэрэв дэлхийн дунджаар нэг хүнд 2,7 га газар оногддог бол Монголд 70 га газар оногддог ажээ⁴. Хоёр их гүрний дунд оршдог энэ их өргөн уудам газрыг өвөг дээдэс маань олон зууны туршид амиа хайрлахгүй хамгаалан тэмцэж, Монголын төр мэргэн бодлогын үрээр бидний үеийг хүртэл бүрэн бүтэн байлгаж ирсэн нь монгол үндэстний нэгэн бахархал мөн.

Тус улсын бүх газар төрийн болон хувийн өмчийн хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл санг бүрдүүлэх бөгөөд түүний 83,4 хувь нь хөдөө аж ахуйн, 0,3 хувь нь хот тосгон, бусад суурины 0.24 хувь нь зам, шугам сүлжээний 11.69 хувь нь ойн сангийн, үлдэх хувь нь улсын тусгай хэрэгцээний газар юм.

⁴ Г.Сүхбаатар. Газар ба БНМАУ-ын тусгаар тогтнол. "АЭ", 1991, №195

Монголд урьд нь хувийн өмч байсан уу?

Энэ нь эрдэмтдийн дунд маргаантай асуудлын нэг. Монголын нэрт түүхч, доктор (Sc.D) Гүнжийн Сүхбаатар Монголд газар хааны мэдэлд улсын өмчид байсан гэж үздэг¹. Манай улсын Ерөнхий сайд асан, эдийн засгийн ухааны доктор (Ph.D) М.Энхсайхан “Хэргийн учир нь газар, бэлчээр нутаг феодалын хувийн өмчид байж, тэдний газар өмчлөл, бэлчээр зохицуулалтаар илэрч байсантай холбоотой”² гэж бичжээ. Хуульч Ц.Сарантуяа “Газрыг хэн ч хувьдаа авч, өөрийн дур хүслээр захиран зарцуулж чадахгүй. Бидний хэн ч шууд утгаараа газрын өмчтөн, газрыг өмчлөх биш, бид зөвхөн газрыг эзэмшигч, ашиглагчид”³ гэж 1991 онд бичиж байв. Гэвч одоо байдал өөр болж, шинэ нөхцөл бий болжээ.

Бидний бодлоор бол нүүдлийн мал аж ахуйн олон зууны туршид эрхэлж байсан Монголчуудын хувьд газар өмчлөх нь сонгодог утгаараа хэрэгжиж байгаагүй, тийм нийгэм, эдийн засгийн нөхцөл ч байсангүй. Өвөлжөө бууцыг үе дамжуулан эзэмшиж байсан хэдий ч түүнийгээ иргэний гүйлгээнд оруулан зарж борлуулж байсангүй. Энэ нь газар өмчлөл бус, харин нутаг эзэмшил юм. Энэ хоёр ойлголтыг зарцуулах эрх бий эсэхээр гол шалгуур болгож ойлгоогүйгээ хоорондоо хольж хутгаж явдал гарч байгаа бололтой.

Монголын их хаад газар нутгийг үр хүүхэд, шадар туслахууддаа хуваан өгч байсан нь түүнийг хувьд өмчлүүлж, цааш нь худалдаж байсан гэсэн үг огтхон ч биш, харин хамгаалан

эзэмшиж бай гэсэн үг юм. Эзэн Чингис хэлэхдээ: “Гурван голын урсгалын зүлэг бол манай өвгөдийн хөгжин бадарсан газар орон тул лавтайяа үүрд мандан бататгагтугай. Яав ч гадны ардыг бүү суулгагтун” гэжээ.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, дэлхий нийтийн жишгээр хөгжиж буй өдгөө цагт газрын нийгмийн асуудал өөрөөр тавигдах болсныг хаа сайгүй ухаарах болжээ.

Хууль гарахаас өмнө газрыг хувьдаа өмчилж байв уу?

Мөнөөх эдийн засгийн эрдэмтэн М.Энхсайхан одоо ч газрыг Монголд хувьдаа өмчилж байна гэж 1991 онд бичээд, түүнийгээ хашаа байшин зарах нэрээр газрыг иргэний гүйлгээнд оруулж байгаагаар тайлбарласан нь үндэстэй зүйл юм Үнэхээр зах зээл, сургууль, цэцэрлэг ойр, хот, суурины төв хэсэгт орших байрлалын хувьд ашигтай хашаа байшинг зарах үнэ захдуу газрын хашаа байшинг зарах үнээс өндөр байгаа нь 1990-ээд оны үеэс ажиглагдаж, одоо нэгэнт бодит зүйл болж биелэлээ олж байна. Иймд газрыг иргэний гүйлгээнд оруулах явдал бүр хэдэн жилийн өмнөөс эхэлж, харин ч Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль амьдралаас хоцорч гарсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл хүссэн хүсээгүй Монгол Улс газрыг хувьд өмчлүүлэх нийгэм, эдийн засгийн зайлшгүй шаардлагатай үед нэгэнт тулж ирснийг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж, эрх зүйн зохицуулалтыг хийхээс өөр аргагүй байдалд хүрчээ.

Өнөөгийн Монголын иргэн газрын шинэ эзэн мөн.

Урьд нь эзэн гэдгийг помещик, хөрөнгөтөн гэдэг утгаар ойлгож байв. Тэгвэл одоо жирийн монгол иргэн газрын эзэн болох боломжтой болов. Үүний эрх зүйн үндсийг Монгол Улсын шинэ Үндсэн хууль

¹ М.Энхсайхан. газрыг хувьд өмчлүүлж болно. “АЭ”, 1991, №141

² Ц.Сарантуяа. Өмч мөн үү. “АЭ”, 1991, №188

³ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он, 6 дугаар зүйл, 3 дахь хэсэг.

“Зөвхөн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж болно”⁴ гэсэн заалтаар бий болгож, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль гарснаар эрх зүйн орчин нь бүрдэж байна.

“Газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэсэн нь “өмчлүүлэхгүй ч байж болно” гэсэн утга хараахан биш бөгөөд харин тус улсын иргэн газар өмчлөхийг зөвшөөрч, уг эрхийг нээлттэй болгосон хэрэг юм. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно гэж Үндсэн хуульд заасан нь иргэд газар өмчлөх талаар хязгаарлагдмал эрхийн чадамжтай болохыг харуулна.

Үндсэн хуульд Монголын түүхэнд анх удаа “газрын эзэн” гэдэг ойлголтыг хэрэглэсэн бөгөөд төр, газрын эзний хооронд үүсэх харилцааны эрх зүйн үндсийг бататган бэхжүүлж, “Төрийн газрын эзэнд газартай холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно” гэж заажээ.

Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээний газар, мөн газрын хэвлийг иргэдэд өмчлүүлэхгүй юм. Тус улсын иргэд газрын эрх зүйн харилцааны субъект төдийгүй, газар өмчлөх эрхийн субьектийн давхар-статустай болов. Энэ нь газрын эзэн-иргэн шинэ эрх, үүргийг бий болгож эрх зүйн байдлыг нь өвөрмөцөөр зохицуулахад хүргэв. Газрын эзэн өөрийн өмчтэй болж, байгалийн

бүтээгдэхүүний тодорхой хэсгийг захиран зарцуулах эрхээр хангагдаж байгаа нь тус улсын түүхэнд гарсан нэгэн шинэ үзэгдэл бөгөөд энэ нь нийгэм, эздийн засгийн бодит шаардлагаар нөхцөлдөн бий болсон юм Төр нь иргэнд нэгэнт өмчлүүлбэл түүний өмчид хууль бусаар халдах эрхгүй бөгөөд өмчлөх эрхийн баталгааг хангах үүргийг өөртөө хүлээх ёстой. Иргэн өөрийн өмчөө яасан ч яахав гэсэн байдлаар бус газарт эзний ёсоор хандаж, хуулийн хүрээнд захиран зарцуулах эрхээ эдлэх нь зүйтэй.

Урьд нь иргэн эрх зүйн харилцаанд зөвхөн газар эзэмших, ашиглах эрхтэй оролцож байсан бол одоо үүгээр хязгаарлагдахгүй, шинээр захиран зарцуулах эрхтэй болж байгаа нь газрын эзэн болж буйг илтгэн харуулж байна. Газрын эзэн газар өмчлөгч, газар өмчлөх эрхийн субьект гэсэн ойлголт нь хувийн газар өмчлөлийн эрх зүйн харилцаанд ижил утгатай юм. Хувийн газар өмчлөлийн эрх зүйн харилцаа нь газрын эрх зүйн харилцааны нэгэн шинэ төрөл бөгөөд иргэдийн газар өмчлөх эрх нь эрх зүйн бие даасан институт болно.

Энэ нь Иргэний эрх зүйн өмчийн эрх зүй, Газрын эрх зүйн газар өмчлөх эрх гэсэн ойлголтын хүрээнд давхар судлагдах учиртай., хууль зүйн шинжлэх ухааны нэгэн шинэ чиглэл юм. Иргэдийн хувийн газар өмчлөлийн эрх зүйн харилцааны субьект нь тухайн газрын эзэн болно Өөрөөр хэлбэл, газар өмчлөх эрхийн чадамжтай, тус улсын 18 насанд хүрсэн иргэн субьект болно. Уг эрх зүйн харилцааны объект нь тэрхүү субьектэд төрөөс олгосон тодорхой хэмжээний газар болно. Төрөөс гэдэг нь эрх зүйн тухайн шатны Засаг дарга газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах байдлаар хэрэгжинэ.

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуульд нийслэлд нэг

⁴ Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль. “Төрийн мэдээлэл” 2003 он, №27

иргэний гэр бүлд 0,07 хүртэл га, аймагт 0,35 хүртэл га, сум, тосгонд 0,5 хүртэл га газрыг өмчлүүлэхээр заасан нь иргэдийн хувийн газар өмчлөлийн эрх зүйн харилцааны объект болно гэсэн үг юм. Иргэдийн газар өмчлөлийн эрх зүйн харилцааны агуулга нь тухайн газар өмчлөгч-субъектийн газрынхаа талаар эдлэх эрх, биелүүлэх үүрэг төдийгүй, эрх үүргээ хэрэгжүүлэх талаар явуулах үйл ажиллагааны цогц гэдэг утгаар бүхэлд нь үзэх шаардлагатай. Иргэдийн газар өмчлөх эрхийн агуулга нь :

- газар эзэмших ;
- газар ашиглах; .
- газрыг захиран зарцуулах;
- газрыг хамгаалах гэсэн 4 үндсэн

элементээр тодорхойлогдоно. ✓

Энд эхний 3 эрх нь уламжлалт шинж чанартай бөгөөд харин 4 дэх эрхийг бид онолын хувьд зайлшгүй байх ёстой элемент гэж үзэж байгаа юм. Хэрэв газар эзэмших нь газрыг мэдэлдээ байлгах, газар ашиглах нь газрын ашигтай чанарыг илрүүлэн гаргаж авах, газрыг захиран зарцуулах нь түүнийг бусдад шилжүүлэх, худалдах, арилжих, бэлэглэх,

барьцаалах зэрэг боломжтой байхыг хэлдэг бол газрыг хамгаалах нь газрын бүтэн байдлыг хангах, эвдрэл, гэмтэл, бохирдолд оруулахгүй байх, хууль бус эзэмшлээс сэргийлэх явдал мөн.

Өмчийн олон хэлбэр бий болж байгаа зах зээлийн харилцааны нөхцөлд өмчид хууль бусаар халдах явдал олонтаа гарч байгаа нь өмч хамгаалахыг өмчлөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг, дөрөв дэх чухал элемент болох эрх зүйн үндэслэлийг зайлшгүй нөхцөлдүүлж байгаа болно. Иймд өмчлөх эрхийн агуулгад шинэ нөхцөл байдлыг харгалзан үзэхгүйгээр хуучныхаа янзаар догма байдлаар хандах нь өнөөгийн эрх зүйн сэтгэлгээнд төдийлөн таарахгүй юм гэдгийг эрх биш ухаарах учиртай. Мөн өмчийн эрх зүй нь өмчийн харилцааг тусгайлан зохицуулсан хууль зүйн хэм хэмжээний бүрдэл цогц, эрх зүйн институт болдог өмчлөх эрх нь иргэдийн өмчтэй байх боломж, субьектив эрх хэмээн заагтай үзэх нь онол практикийн хувьд төдийгүй, эрх зүйн зохицуулалтыг нарийвчлахад арга зүйн ач холбогдолтой.

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа,
шүүхэд нэхэмжлэл гаргах эрх**

12 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх

12.1.Иргэн, хуулийн этгээд дараахь тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

12.1.1. хуульд тусгайлан заасан;

12.1.2. дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн;

12.1.3. захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй;

* * *

ОЮУНЫ ӨМЧИЙН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ТОЙМ

ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрхлэгч,
дэд профессор, докторант Д.Цолмон

Хүний аливаа ухамсартай үйлдэл нь гарал үүслийн хувьд оюуны бүтээгдэхүүн байдаг бөгөөд оюуны хөдөлмөрийн бүтээл нь зуунаас зуун дамжиж уламжлан хөгжиж ирсэн түүхтэй. Хүний оюунаар бүтээгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, бараа болон үйлчилгээний тэмдэг, шинжлэх ухааны нээлт, шинжлэх ухаан, урлаг, утга зохиолын бүтээлүүд, хөгжим, дүрслэх урлаг, архитектур, жүжиг, кино, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэгийн бүтээл гэх мэтийг хууль зүйн талаас нь хэрхэн үнэлэх, ямар журмаар анхдагчаар тогтоож, зохиогчийн эд хөрөнгийн онцгой эрх болон эд хөрөнгийн бус амины эрхийг нь хууль зүйн хувьд ямар арга хэрэгслээр хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээн тогтоох гэх мэт асуудлаар төрөөс хууль зүйн зохицуулалт хийхийг зайлшгүй шаарддаг байна.

Хүний нийгэм урт удаан хугацааныхаа хөгжлийн явцад өмчлөлийн зүйлийн хоёр үндсэн хэлбэрийг бий болгон өмчийн харилцаанд оруулжээ. Энэ нь биет өмчлөлийн зүйлс (tangible things), биет бус өмчлөлийн зүйлс (intangible things) юм. Биет өмчлөлийн зүйлд эд юмс орох бөгөөд үүнийг иргэний эрх-зүйн үүднээс авч үзвэл хөдлөх эд юмс, үл хөдлөх эд юмс гэж ангилна. Харин биет бус өмчлөлийн зүйлд оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн зарим эрх хамаардаг байна.

Хүн төрөлхтөн биет бус өмчлөлийн зүйл* болох оюуны

хөдөлмөрийн үр дүн болсон бүтээлээ "өмч" хэмээн ойлгож, эдийн засгийн ач холбогдол өгч ашиглах явдал түүхэн хөгжлийнх нь нэлээд хожуу үед үүсчээ.

Түүхэн эх сурвалжуудаас үзэхэд 1400-аад оны үеэс оюуны бүтээлийг өмч болгох асуудлын эх үүсвэр тавигдаж эхэлсэн байна. Патентийн түүхэн хөгжлийг үндсэн гурван үе шатаар авч үздэг байна.*

Онцгой эрх олгож байсан үе /15-18-р зуун/: Энэ үед зөвхөн Эзэн хааны таалалд нийцсэн зүйл бүтээхэд онцгой эрх олгодог байв. Энэ эрхийн гол үзэл санаа нь ашиг тустай байх шинжийг агуулсан байх ёстой байв. Зарим тохиолдолд дархлагдсан байх нь нэг чухал шинж болж байжээ.

Үндэсний патент олгож байсан үе /1790-1883/: Шинийг бүтээгч хүн бүр патентийн эрх авахаар өргөдөл гаргах бөгөөд зөвшөөрлийг зөвхөн тодорхой зорилгыг хангасан тохиолдолд олгодог байсан нь энэ үеийн онцлог юм. Шинэ бүтээлийг дотоодын төвшинд хамгаалах нь гол байсан ба энэ нь хилийн чанадад хэрхэхийг харгалзан үздэггүй байжээ.

Олон улсын хэмжээнд зохицуулах болсон үе /1883 - өнөөг хүртэл/: Олон улсын худалдаа хөгжихийн хамт тухайн улсаас гадна бусад улсад шинэ бүтээлийн эрхийн хамгаалалт хийх боломжтой болсон явдал юм. Энэ нь дэлхийн хэмжээнд болон бүс нутгийн төвшинд гаргадаг гэрээгээр

* Intellectual property reading material. WIPO, Geneva., 1997. p-21

зохицуулагдан хөгжиж байна.

Ингээд дээр дурдсан хөгжлийн үе шат бүрийн онцлог шинжийг дэлгэрүүлэн авч үзье.

Онцгой эрх олгож байсан үе

Онцгой эрх гэдэг нь эзэн хаанаас хувь хүнд тусгай эрхийг эдлэх боломжийг олгох хэрэгсэл юм. Эдгээр онцгой эрхийг шинийг бүтээгчдэд олгохдоо маш олон төрлийн эрх, боломж, хөнгөлөлтийг хамтатгадаг байжээ. Тухайлбал, зарим нэгэн дүрэм журамд захирагдах болон албан татвараас чөлөөлөгдөх, газар хуваарилах, хүүгүй зээл олгох, оршин суух эрх олгох болон язгууртны хэргэм зэрэг олгох гэх мэт. Энэ үед шинийг бүтээгчдэд Эзэн хаанаас олгодог байсан тэтгэлэг, дэмжлэг нь олон төрлийн учир шалтгаантай байжээ. Уул уурхайн салбарт бий болгосон шинэ бүтээлд олгодог онцгой эрхийг урьдчилгаа олгох хэлбэрээр дэмжлэг үзүүлдэг байсан ба энэ нь зөвхөн уул уурхайн аж үйлдвэрийн салбарт дагаж мөрдөхөөр тогтоогдсон байжээ.

Дээрх онцгой эрхийг олгож байх эхэн үед тухайн шинэ техник нь нь хилийн чанадад илэрхий болсон эсэхийг үл харгалзан олгодог байжээ. Эзэн хаан дотоодын аж үйлдвэрийг шинээр хөгжүүлэхэд шинэ бүтээлийг чухалчлан үзэж байсан байна.

Венец улсаас дээрх онцгой эрхийн зохицуулалтыг тусгасан "Венецийн Патент" гэсэн анхны хуулийг 1474 онд анх батлан гаргажээ.^{*} Энэ хууль нь өнөөгийн патентийн зарим зарчмыг тусгасан байдаг байна. Тухайлбал, шинэ бүтээл нь тухайн улсдаа үр ашигтай, хэрэгтэй байх, шинийг бүтээсэн анхдагч нь тодорхой хугацаанд онцгой эрхтэй

байх, эрх нь зөрчигдөх тохиолдолд сэргээн тогтоож, эрх зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх гэх мэт.

Харин Английн хувьд технологи шилжүүлэх, аж үйлдвэрийг шинэ тутам байгуулах үйл ажиллагаа 12 дугаар зуунаас эхэлсэн бөгөөд 14 дүгээр зуунаас Вангаас тусгайлсан онцгой эрхийг импортын технологи дээр тулгуурлан шинэ үйлдвэрийг бий болгож байгаа этгээдэд олгож, эрхийг нь хамгаалдаг болсон байна. Энэ хамгаалалт нь шинэ технологийг бий болгож байгаа этгээдэд тухайн технологио суурилуулж ажиллуулах болон түүн дээр ажиллагсдыг сургах хангалттай хугацаанд зөвхөн ганцаар ашиглах эрхийг олгодог байжээ.

Энэхүү зөвхөн ганцаар ашиглах эрх нь үүсгэн байгуулах хүнд жилүүдэд шинэ үйлдвэрийг хөгжүүлэхэд улсаас олгох нөхөн төлбөр болон урт хугацаанд хараат бус байдлыг хамгаалан халхавчлах бамбай нь болж байсан байна.

Эдгээр хугацаа, эрх нь ерөнхийдөө "Патентийн бичиг" /Letters Patent/-ээр баталгааждаг байв. Үүнийг "нээлттэй бичиг" гэж нэрлэдэг байсан ба энэ нь доод талдаа лацадсан тамгатай бөгөөд харин энэ тамга нь захидал харилцааны цаасан дугтуйг наасан лац тамганаас өөрөөр хэрэглэгдэж байжээ. Энэ нь тухайн онцгой эрх хамгаалагдсаныг баталгаажуулсаныг нийтэд албан ёсоор мэдэгдэх арга нь байв. Шинэ үйлдвэрлэлийг дэмжих явцад дэмжлэг тусламж үзүүлдэг онцгой эрхийн систем нь Вангийн орлогыг өсгөхөд зүй бусаар ашиглагдаж эхэлжээ. Энэ талаар Парламентын дотор ч дургүйцэл, эсэргүүцэл гарсан бөгөөд Ван патентийн энэ асуудал нь хуулийн дагуу шүүхээр шийдвэрлэгдэх ёстой гэжээ. Эндээс хамгийн дуулиантай

^{*} Intellectual property reading materail.
WIPO, Geneva., 1997. p-23

шүүх ажиллагаа нь 1615 онд болсон "Лепсвишийн гутлын үйлдвэрийн ажилчид"-ын заргыг шийдсэн хэрэг юм. Гэсэн хэдий ч олгогдсон онцгой эрхийг буруугаар ашиглах явдал 1628 онд "Монополийн хууль"-ийг батлан гаргах хүртэл үргэлжилжээ. Энэ хуулиар аливаа монополийг болон тогтоосон дүрэм, журамд захирагдахгүй байх онцгой эрхийг хязгаарлаж өгчээ.

Онцгой эрх олгох хөгжлийн түүх, түүнтэй холбоотой шийдэгдсэн шүүхийн шийдвэрүүд нь өнөө үеийн патентийн асуудлыг зөв төсөөлөх боломжийг олгож байна.

1760 оноос Англид өрнөсөн аж үйлдвэрийн хувьсгалтай холбоотой патентийн тоо маш хурдацтай өсч эхэлжээ. Англи Улстай бусад орнуудыг харьцуулбал тэдний хувьд аж үйлдвэржилт хожуу эхэлсэн бөгөөд патентийн тоо ч үүнтэй уялдаж харьцангуй доогуур байлаа.

Францад чөлөөт үйлдвэрлэл худалдаанд үл итгэх хандлага нь патентийн бичиг эзэмшигчдийн хувьд нэлээд саад бартаа ихтэй байснаас патентийн үнэлгээ маш доогуур байлаа. Хааны зарлигаар шинэ бүтээлийн эрхээ хамгаалуулах өргөдлөө нэг жилийн дотор гаргаж чадаагүй бол /1762 оны тунхаглал/ шинийг бүтээгч нар эрхээ алдах бөгөөд энэ шийдвэрээс болж онцгой эрх олж авах боломж нь багагүй хэмжээгээр хаагдаж байжээ.

*Үндэсний патент олгож байсан үе**

Америкийн Нэгдсэн Улс /1790/, Франц /1791/ улс бараг нэгэн зэрэг шахуу патентийн хуулиа батлан гаргажээ. Эдгээр хуулиар зайлшгүй,

бодит нөхцөлийг хангасан гэж үзсэн шинийг бүтээгчдэд патентийн зөвшөөрөл олгох үндсийг тавьжээ.

1791 оны 1 дүгээр сарын 7-нд батлагдсан Францын Патентийн хуулийн 1 дүгээр зүйлд "Аж үйлдвэрийн салбарт гаргасан аль ч нээлт, шинэ бүтээл нь зохиогчийнх нь өмч болно, иймээс энэ хуулиар тогтоосон нөхцөл, хугацаанд тухайн зохиогчийн бүхий л таатай байдлыг хууль баталгаажуулж байна" гэжээ.

Үүнээс гадна хууль тогтоогчид үндэсний үзлийг гаргаж байсан байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсын энэ тухай хуульд 1793 онд нэмэлт өөрчлөлт орж, патентийг зөвхөн өөрийн улсын иргэнд олгохоор өөрчилсөн бол Франц улсын хуульд Францад эрхээ хамгаалуулсан патент эзэмшигч шинэ бүтээлдээ хилийн чанадад патент авбал Францад авсан патентийн эрхийн боломжоо алдана гэх мэтээр зохицуулж байжээ.

Энэ шинэ систем нь 19 дүгээр зууны эхний арван жилд үргэлжилсээр ялангуяа Наполеоны байлдан дагуулалтын дараа эзлэгдсэн орнуудад Францын хууль мөрдөгдөж эхэлжээ. Хаанаас олгодог онцгой эрхийн зарчим үргэлжилсээр байсан ч патентийн эрхийн асуудал хааяагүй илэрхий болж байв.

Нэлээд олон оронд аж үйлдвэрийн хувьсгал гарсан нь патентийн тоон хэмжээ нэмэгдэхэд бодитой нөлөөлсөн байна. Зөвхөн АНУ, Франц, Англид 1815-1820 онд гэхэд л жилд 100 гаруй патент олгож байсан байна. 1850-1854 оны хооронд дээрх гурван оронд тус бүр 1000 гаруй патент олгосон ба бусад оронд ч хэдэн зуун патент олгогдсон байна. Тоон хэмжээ өсөхийн зэрэгцээ чанарын хувьд ч дэвшил гарч иржээ.

* Intellectual property reading materail. WIPO, Geneva., 1997. p-25

1836 онд АНУ-аас бусад улсад бүртгэлийн давамгайлах огноог тогтоох болон патент олгохдоо бие даасан шинжилгээ хийдэг болсон байна. Түүнчлэн гадаадын иргэн нь тухайн улсад патент эзэмших боломжтой болжээ. Өөрөөр хэлбэл энэ нь нэг болон ижил төстэй шинэ бүтээл нь гадаадын хэд хэдэн оронд патентлагдах болсон нь дэвшилтэй зүйл болжээ. Гэвч олон улсын хамгаалалт хийхэд процессын хүндрэлтэй байдал болон тодорхой бус ашигт эргэлзэх, төвөгтэй будлиантай байх явдал гарч байлаа.

Патентийн оршин тогтнох явц нь олон улсын худалдааг хөгжүүлэхэд учирч байгаа саад бартааг нэгэн адил мэдэрч байсан байна. Ялангуяа гаалийн асуудалд нэлээд хүндрэлтэй учирч байжээ.

Англи улс нь чөлөөт худалдааг амжилттай хөгжүүлснээрээ бусад оронд үлгэр дуурал үзүүлсэн төдийгүй "патентийн систем" нь чөлөөт худалдааны хамт гаалийн хаалт саадыг гэтлэн давсан байна.

Улмаар техникийн хувьд харьцангуй өндөр хөгжилтэй болсон орнуудын шинийг бүтээгчид, тэдгээрийн эвлэлдэн нэгдсэн холбооныхон болон аж үйлдвэрийнхэн шинэ бүтээлийн олон улсын хамгаалалтыг бий болгох үзэл санааг анх үүсгэн санаачилжээ.

Тухайлбал, 1873 онд Вена хотноо болсон патентийн хурлаар "Иж бүрэн тайлбар бичиг"-ийг гаргасан бөгөөд энэ хурлаар олон улсын хамгаалалтын олон үзэл санааг хүлээн зөвшөөрсөн байна. Нөгөө талаар энэ үетэй давхцан бий болсон эдийн засгийн хямрал нь чөлөөт худалдаа болон патентийн асуудалтай холбоотой аливаа үзэл баримтлалыг дахин шинээр авч

үзэхийг шаардаж байлаа.

Парист олон улсын хурал болж нэмэлт тайлбар бичиг гарган аж үйлдвэрийн өмчийг хамгаалах оновчтой зөв арга замыг тодорхойлох ажиллагаа эхэлсэн юм. 1880 онд болсон дипломат бага хурлаас гаргасан шийдвэрийн дагуу 1883 оны 3 дугаар сарын 20-нд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай конвенцид гарын үсэг зурсан байна.

Олон улсын хэмжээнд зохицуулах болсон үе

Ийнхүү Парисийн Конвенцид гарын үсэг зурснаар* аж үйлдвэрийн өмчийг тэр дундаа патентийн системийг хамгаалах олон улсын хамгаалалтын хөгжлийн үе эхэлсэн гэж үздэг.

Парисийн холбоо нь холбооны гишүүн орнуудын шинэ бүтээлийг Холбоонд хамгаалахад дэмжлэг үзүүлэх, түүнийг бусад гишүүн оронд шуурхай бөгөөд үр ашгтай хамгаалуулах талаар илүүтэй анхааран, тогтмол хэвлэлээр гишүүн орнуудыг хангаж байв.

Стокгольм хотноо 1967 онд болсон дипломат бага хурлаар дээрх конвенцийн үндсэн дээр "Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага"-ыг байгуулахаар болсон юм. /Одоо НҮБ-ийн бие даасан төрөлжсөн байгууллага/. Энэ нь Аж үйлдвэрийн өмчийн болон Зохиогчийн эрхийн холбоог хамтатган, улмаар одоогийн бүтцийг бий болгох эх үүсвэр нь болжээ.

Хэдийгээр оюуны өмчийн бие даасан байгууллагыг бий болгосон ч Парисийн холбоо нь аж үйлдвэрийн өмчийн талаар "тусгайлсан хэлэлцээр" байгуулж болох боломжийг гишүүн

* Intellectual property reading materail. WIPO, Geneva., 1997. p-27

орнууддаа олгосон.

Энэ боломжийг маш өргөнөөр ашигласаар байгаа бөгөөд үүнд Патентийн хамтын ажиллагааны хэлэлцээр /1970 ДООБ/, Европын Патентийн Конвенци /1973, Европын Патентийн байгууллага/-ийг жишээлэн хэлж болох юм. Эдгээр тусгай хэлэлцээр нь Парисийн холбооны бүхий л оронд биш харин хязгаартай хүрээнд хөгжүүлэх бололцоог олгосон байна. Патентийн хөгжлийн түүх нь урт удаан хугацааны турш үргэлжилсээр өнөөгийн үетэй золгожээ.

Зохиогчийн эрхийн хөгжлийн түрхээс

Зохиогчийн эрхийг хамгаалах санаа нь хэвлэлийн салбарт гарсан шинэ бүтээлүүдтэй шууд холбогддог гэж үздэг. Өөрөөр хэлбэл утга зохиолын бүтээлийг гар аргаар олшруулахын оронд механик аргаар олшруулах, хуулбарлах боломжтой болсонтой холбоотой юм. Энэ нь худалдааны шинэ дүр төрхийг бий болгосон төдийгүй хэвлэл болон номын худалдаа эрхлэгчдийг шинээр бий болгосон байна.

Тэр үед Англид тэдгээр хүмүүсийг “ном, бичгийн хэрэгслийн худалдаачид” /stationers/ гэж нэрлэдэг байжээ. Ийм төрлийн бизнес эрхлэхэд нэлээдгүй хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх, цаасны худалдаа, хэвлэх үйлдвэрүүдийг байгуулах, эдгээртэй холбоотой ажлын байр шинээр бий болгох гэх мэт асуудал шийдвэрлэгдэж байлаа.

Гэвч энэ үед эрх олгогдоогүй хуулбар хийж худалдахын эсрэг хамгаалалт байхгүйгээс ном хэвлэх болон худалдахтай холбогдож хийсэн

хөрөнгө оруулалт нь эрсдэл ихтэй, аз туршсан “бизнес” болж, нөгөөтэйгүүр бата биш хэмжээгээр сүйрэл, дампууралд хүргэж байв. Эдгээр нөхцөл байдал нь хамгаалалтын зарим хэлбэрийг аяндаа бий болгосон ба онцгой эрхийг харилцан адилгүй эрх хэмжээний хүрээнд олгож байжээ. Тухайлбал, Англи болон Францад Хаан, Германы холбооны зарим улсад Хун тайж зохиогчид онцгой эрхийг олгож байв.

Эдгээр онцгой эрхийг эдлэгч нь бүтээлийг дахин хуулбарлах, нийтийн хүртээл болгох, тараах эрхийг тодорхой хязгаартай хугацаанд эдлэх бөгөөд эрх нь зөрчигдсөн тохиолдолд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжийг эдлэхийн хамт бусад этгээдээс хууль бус хуулбар хийсэн тохиолдолд хуулбарыг хураан авах, торгууль хүлээлгэх, баривчлах, түүнчлэн хохирлыг барагдуулах бололцоог бий болгож байжээ.

Энэхүү олгож байсан онцгой эрхийн зарим зохицуулалтын үрдүн нь өнөөгийн зохиогчийн эрхийн системийн үндсэн суурь нь болж өгсөн билээ.

17 дугаар зууны сүүлчээр онцгой эрх олгох систем буюу дангаар олгож байгаа титэмчилж өргөмжилсөн эрх нь маш ихээр шүүмжлэгдэх болж, олон зохиогч эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах нь нэмэгдсэн байлаа.

Иймээс зохиогчийн эрхийн асуудлыг “төрөлжсөн хууль”-аар зохицуулах шаардлага зайлшгүй бий болж 1709 онд Англид зохиогчийн эрхийн анхны хууль гарсан гэж үздэг юм. Энэ нь түүхэнд “Эннийн дүрэм” /Statute of Anne/ гэж нэрлэжээ.

* Intellectual property reading material. WIPO, Geneva., 1997. p-24

* Intellectual property reading material. WIPO, Geneva., 1997. p-24

Энэ хуулийн гол зорилт болох номын хуулбар хийх эрх нь гагцхүү уг эрхийг хууль ёсоор олж авсан өмчлөгчид хадгалагдах ба өмчлөгчийн эрхийг хамгаалж, дэмжих асуудал нь төслийн гол хэсэг нь байсан юм. Энэ зарчим нь зохиогч нь номоо анх хэвлэн нийтэлснээс хойш 14 жилийн хугацаанд хэвлэх, олшруулах эрхийг дангаар эдлэх бөгөөд мэдээж хэрэг энэ эрхээ бусдад худалдаж болох ба ихэнх тохиолдолд номын худалдаачдад эрхээ худалддаг байжээ.

Түүнчлэн энэхүү актаар хамгаалалтын 2 үеийг тогтоож өгсөн ба эхний 14 жил дуусахад хамгаалалтын 2 дахь үе эхэлж болохоор зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл эхний 14 жил дуусахад зохиогч нь амьд байвал дараагийн 14 жил буюу 2 дахь үеийн хамгаалалт эхлэх боломжтой юм. Энэ нь зохиогчийн эрхийн хамгаалалт нь бүтээл анх хэвлэгдсэн өдрөөсөө хойш нийт 28 жилийн хугацаанд хамгаалагдах боломжтойгоор зохицуулж байжээ.

Харин энэ актыг хүчин төгөлдөр болж гарахад хэвлэгдсэн байсан номуудад 21 жилээр хамгаалагдах нэг л үеийг тогтоож өгсөн байна.

Энэ актаар нэгэнт хэвлэгдсэн бүтээлийг эрх авалгүйгээр хуулбарлахыг хориглосноос гадна хэвлэгч болон номын худалдаачдын хуулбарлах эрхийн хүрээ, зарчмыг тогтоож өгсөн явдал юм.

Хэвлэгдсэн бүтээлийг бүртгэх болон хураамж төлөх нөхцлийн аль алиныг нь тогтоож өгсөн ба хэвлэгдсэн ном заавал "Stationers Hall"-д бүртгэгдсэн байх бөгөөд, бүртгэгдсэн бүтээлүүдийг их сургуулиуд болон номын сангуудын хэрэгцээнд хуулбар хийн ашиглаж болох нөхцлийг

тогтоосон ч нөгөө талаар хураамж нь заавал төлөгдсөн байх зэрэг зохицуулалтыг багтаажээ..

"Эннийн дүрэм"-ээр 18 дугаар зуунд тогтоосон зохиогчийн эрхийн зохицуулалтаас үүдэн нийтлэг эрх зүйн систем /common law/, зохиогчийн эрхийн хооронд эрх зүйн зохицуулалтын маргаан үргэлжилсээр байлаа.

Энэ нь хэвлэгдсэн бүтээл болон хэвлэгдээгүй бүтээлүүдийн зохиогчийн эрхийн тухай асуудал нь маргааны гол хэсэг нь болж байсан байна.

Харин Францын хувьд "онцгой эрх олгох" системээс зохиогчийн эрх рүү шилжих хөгжилт нь суурь үндсэн өөрчлөлтийг авчрах хувьсгалыг хийж чадсан. Өөрөөр хэлбэл онцгой эрхийн бүх төрөлд төдийгүй хэвлэгчдийн хувьд ч зарчмын өөрчлөлтийг бий болгон "онцгой эрх"-ийг устгаж чаджээ.

1791, 1793 онуудад Францад болсон "Сонгогчдын чуулган"-аас хоёр шийдвэр /хууль/ гаргасан ба энэ нь франц загварын зохиогчийн эрхийн системийг бий болгох үндэс нь болжээ.

1791 оны хуулиар зохиогч нь насан туршдаа бүтээлээ нийтийн хүртээл болгох эрхийг эдлэх ба нас барснаас хойш 5 жилийн хугацаанд энэ эрх нь түүний өв залгамжлагчид шилжихээр зохицуулжээ. 1793 онд дээрх зохицуулалтыг улам баяжуулж зохиогч бүтээлээ дахин хэвлэх эрхийг насан туршдаа эдлэх ба нас барснаас хойш 10 жилийн хугацаанд түүний өв залгамжлагч нь энэ эрхийг нь шилжүүлэн эдэлж болохоор заажээ. Бид эндээс "Эннийн дүрэм"-ийн ялгааг төвөггүй харж болох юм.

Францад дээрх эрхийг "Туурвигчийн эрх" /authors' right/ гэж

тодорхойлдог бөгөөд туурвигч нь насан туршид энэ эрхээ эдлэх боломжоор хангагдах нь бүтээлээ хэвлүүлсэн эсэхээс үл хамаарахаас гадна ямарваа нэгэн бүртгэл хийлгэх, хураамж төлөх гэх мэт хэлбэрийн шаардлагыг тавьдаггүй байжээ.

Хэдий тийм боловч Англи, Францад зохиогчийн эрхийг зөвхөн "өмчийн" эрхээр хамгаалж, бүтээлийн зохиогч болон түүний өв залгамжлагчийн эдийн засгийн талын эрхийн хамгаалалтыг хийж байсан байна.

Хөгжлийн явцад онцгойлон үзэх нэгэн чухал зүйл нь Германы философчдын гаргасан үзэл баримтлал юм. Тухайлбал, аугаа сэтгэгч Кантын үзлээр зохиогчийн эсвэл туурвигчийн эрх нь зохиогч болон эрх эдлэгч өмчлөгчийн зөвхөн эдийн засгийн үр ашиг олох өмчийн хэлбэр биш юм гэж үзэж байлаа.

Тэдний үзэж байснаар туурвигчийн бүтээсэн утга зохиолын бүтээл болон бусад бүтээл нь туурвигчийн алдар хүнд, хувь хүний өөрийн тусгал илэрхийлэлтэй зайлшгүй холбогдох ба энэ нь зохиогч өөрийн нэрээр нэрлэх байгалиас заяасан шударга ёсны эрх нь нэгэн адил хамгаалагдах ёстой юм гэж үздэг байв. Дээрх үзэл баримтлал нь Европ тивийн зохиогчийн эрхийн хөгжилд бодитойгоор тусгалаа олж, тэр дундаа туурвигчийн ёс суртахууны эрх /droit moral or moral rights/ буюу эд хөрөнгийн бус амины эрхийн хөгжилд үндсэн суурь нь болжээ.

Зохиогчийн эрхийн хөгжлийн товч түүхийг Америкийн Нэгдсэн Улсын хувьд авч үзвэл 1976 оны хуулийг батлагдан гарах хүртэл зохиогчийн эрхийн хууль нь үндсэндээ Англи Улсын "Эннийн дүрэм"-ийн зохицуулалтад тулгуурласан байлаа.

1790 онд Америкийн холбооны "Зохиогчийн эрх"-ийн анхны хууль гарч үүгээр дээрх "Эннийн дүрэм"-ийн зохицуулалт илэрлээ олсон байв. Тухайлбал, энэ актаар ном, газрын зураг, бүдүүвч зураг нь анх хэвлэгдсэнээс хойш 14 жилийн хугацаанд хамгаалагдах ба анхны хугацаа дуусахад зохиогч нь амьд байвал хугацаа сунгагдах боловч заавал дахин бүртгүүлж, хураамж төлөх хатуу шаардлага тавигдаж байжээ.

Дээрх зохицуулалт АНУ-д 1976 оныг хүртэл үргэлжилсэн: 1976 онд нэмэлт өөрчлөлт оруулж зохиогчийн эрхийг хамгаалах хугацааны үргэлжлэлийг насан туршид нь болон нас барснаас хойш 50 жилийн хугацаанд байхаар өөрчилжээ. Иймэрхүү өөрчлөлт өөр бусад орны зохиогчийн эрхийн хуульд ч нэгэн адил хийгдэж байв. Гэсэн хэдий ч 1976 оны хууль нь бүртгэлийн болон хураамжийн 1709 оны "Эннийн дүрэм"-ийн шаардлагыг хадгалж үлдсэн хэвээр байна.

Ингээд нийтлэг эрх зүйн болон эх газрын эрх зүйн системийн хооронд зохиогчийн эрхийн үзэл баримтлалын мөн чанарын хувьд ялгаатай байдлыг авч үзье.

Нийтлэг (common law) зүйн системтэй орнуудад зохиогчийн эрхийг /copyright/ нэг буюу хэд хэдэн зохиогч хамтран нэг удаа бий болгодог өмчлөлийн зүйлийн нэг хэлбэр гэж үзэн, энэ нь өмчлөлийн бусад зүйлийн нэгэн адил худалдааны эргэлтэд амархан "өртдөг", өмчийн эдийн засгийн потенциалыг хамгаалахад эрхийн бүрэлдэхүүн хэсэг нь чиглэгддэг гэж үздэг байна.

Тэгвэл эх газрын (ром-германы) эрх зүйн системтэй орнуудад

туурвигчийн эрх нь /author's right/ "өмчийн" үндсэн шинжийг хадгалдаг, зохиогчийн эрхийг хамгаалахдаа өмчийн эдийн засгийн агуулгаар нь нийтлэг эрх зүйн системийн адил цар хүрээнд хамгаалах ёстой гэж үздэг.

Гэвч туурвигчийн эрхийн /author's right/ ялгаа болгож байгаа хэмжигдэхүүнийг оюун ухааны болон философийн үзэл баримтлалын үүднээс авч үздэг байна. Өөрөөр хэлбэл туурвигчийн бүтээсэн бүтээл нь туурвигчийн алдар хүнд, хувь хүний өргөн хүрээтэй тусгал илэрхийлэлтэй зайлшгүй холбогдох ба энэ нь зохиогч өөрийн нэрээр нэр өгөх байгалиас заяасан шударга ёсны эрх нь

бүтээлийн эдийн засгийн потенциалын нэгэн адил хамгаалагдах ёстой юм гэж үздэг байна.

Зохиогчийн эрхийг олон улсын хэмжээнд хамгаалах үе нь 1886 онд "Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн Конвенц"-д гарын үсэг зурснаар эхэлсэн юм. Бернийн конвенцид хийгдэж байгаа хожмын өөрчлөлтүүд нь зохиогчийн эрхийн олон улсын хамгаалалтыг улам боловсронгуй болгох, түүнчлэн зохиогчийн эрх болон хамаарах эрхийн хүрээнд технологийн дэвшилтэй холбогдон бий болж байгаа шинэ нөхцөл байдлыг аятай зохицуулахад чиглэгдэж байна.

* * *

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа,
шүүхэд нэхэмжлэл гаргах эрх**

15 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

15.1. Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх энэ хуульд заасны дагуу үүсгэсэн захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

15.2. Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим захиргааны хэргийг дараахь журмаар хянан шийдвэрлэнэ:

15.2.1. аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны;

15.2.2. Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэргийг хяналтын шатны.

15.3. Монгол Улсын дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй.

* * *

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ГОЛ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТУХАЙ

ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч,
докторант Б.Отгонбаяр

Монгол Улс 1997 оноос эхлэн Дэлхийн худалдааны байгууллага /цаашид "ДХБ" гэнэ/-ын гишүүн нь болсноос хойш даруй 5 гаруй жил өнгөрөөд байна. Гэтэл манай ард иргэд, албан тушаалтнууд, түүний дотор хуульчид энэ томоохон байгууллагын талаар болон уг байгууллагаас баталж гаргасан гэрээ, хэлэлцээрийн талаар хэр зэрэг мэдэж байна вэ гэдэг асуулт өөрийн эрхгүй урган гарч байна.

Хуульчдын дунд "Дэлхийн худалдааны байгууллагын талаар та юу мэдэх вэ?", "ГАТТ гэж юу вэ?" гэсэн асуулт тавихад ДХБ-ын талаар хагас дутуу хариулж, харин ГАТТ-ын талаар дийлэнх нь ямар ч ойлголтгүй байдаг. Тэр ч байтугай, "ГАТТ нь ямар нэгэн улсын нийслэл болов уу" гэсэн хариултыг өгч байсан тохиолдол ч гарсан. Хуульчид энэ байгууллагын талаар иймэрхүү төвшингийн мэдлэгтэй байхад жирийн иргэдийн энэ талаархи мэдлэг ямар байх нь ойлгомжтой билээ.

Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орохдоо уг байгууллагын өмнө Монгол Улсын Засгийн газраас хүлээсэн олон амлалт үүргийн дотор ДХБ, түүний гол хэлэлцээрийн талаар ард иргэддээ тайлбарлан таниулж өргөн сурталчлах үүрэг гарцаагүй орж байгаа юм.

Иймд энэ байгууллагын талаар, нэн ялангуяа, энэ байгууллагын үндсэн зорилго, чиг үүргийн талаар, түүнчлэн уг байгууллагаас баталсан гол хэлэлцээрүүдийн талаар хуульчдад

товч ойлголт өгөх нь зүйтэй гэж үзэж энэхүү өгүүллэгийг бичлээ.

Дэлхийн худалдааны байгууллага ямар байгууллага вэ?

Дэлхийн худалдааны байгууллага гэж засгийн газар хоорондын байгууллага бөгөөд тус байгууллага нь гишүүн орнуудаас худалдааны талаархи үндэсний хууль тогтоомж, дүрэм журмаа хэрхэн бүрдүүлж биелүүлэхээ тодорхойлоход нь тэдэнд тус дэм үзүүлэх зорилготой бөгөөд эрх зүйн болон зохион байгуулалтын үндэс суурийг нь хангадаг.

Энэ байгууллага нь хамтаар шүүн хэлэлцэх, хэлэлцээ хийх болон маргаан шийдвэрлэх замаар улс орнуудын хооронд худалдааны харилцааг хөгжүүлэх тавцан нь болж өгдөг юм.

ДХБ нь 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Маррокогийн Маракеш хотноо болсон уулзалтын үеэр гарын үсэг зурсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрээр байгуулагдаж албан ёсны үйл ажиллагаагаа 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс явуулж эхэлсэн юм.

ДХБ нь ГАТТ-ын¹ залгамжлагч байгууллага мөн. ДХБ нь ГАТТ-ын зохион байгуулалтын бүтэц, зарчмуудыг өөрийн гэрээ, хэлэлцээрт нэгтгэсэн байна.

¹ "ГАТТ" гэж General Agreement on Tariffs and Trade гэсэн англи нэрийн товчлол бөгөөд монгол хэлнээ хөрвүүлбэл Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр гэсэн үг юм. Энэхүү хэлэлцээр буюу байгууллагын нэр нь ГАТТ хэмээн алдаршсан тул олон улсын практикт энэ товч нэрийг хэрэглэж заншижээ /Зохиогч/.

2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар ДХБ нийт 144 гишүүнтэй бөгөөд дэлхийн худалдааны 90 гаруй хувийг эзэлдэг. Одоогийн байдлаар 30 гаруй улс уг байгууллагад нэгдэн орох хүсэлтээ гаргаад байна. Эдгээр орон нь хөгжиж буй орнууд буюу эдийн засаг нь шилжилтийн үедээ байгаа улс орнууд юм /Тухайлбал, Армени, Азербайджан, Белорусс, Бутан, Вьетнам, Кампучи, Балба, ОХУ, Украин, Югослав г.м./².

ДХБ-ын үндсэн зорилго нь худалдааны урсгалыг саадгүй, чөлөөтэй, шударга ба урьдчилан харж болохуйц байлгах талаар гишүүн орнуудад туслах явдал юм.

ДХБ нь дээрх зорилгоо дараахь арга замаар хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- худалдааны хэлэлцээрийг удирдан зохион байгуулах;

- худалдааны хэлэлцээ хийхэд зориулсан чуулганы хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах;

- худалдааны маргаан шийдвэрлэх;

- үндэсний худалдааны бодлогыг хянах;

- техник туслалцаа болон сургалт зохиох замаар хөгжиж буй орнуудын худалдааны бодлогын асуудалд туслалцаа үзүүлэх;

- бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллах.

ГАТТ-ын товч түүх ба хөгжил

ДХБ-ын үйл ажиллагааны талаар судалж үзэхийн тулд ГАТТ-ын тухай гарцаагүй ярих шаардлагатай болдог. Иймээс ГАТТ гэж юу болох, ГАТТ хэрхэн яаж үүсч хөгжсөн тухай товч дурдах нь зүйтэй юм.

² Уг тоо баримтыг ДХБ-ын тухай танилцуулга бүхий ДХБ-ын Вэбхуудаснаас авсан болно. Интэрнетын хаяг: http://www.wto.org/english/thewto_e/whatis_e/tif_e/org6_e.htm

ГАТТ нь дараахь хоёр үндсэн чиг үүрэгтэй:

- олон улсын худалдааны байгууллага

- олон талт олон улсын хэлэлцээр

ГАТТ бол ДХБ-ын эрх зүйн үндсийн гол бүрэлдэхүүн хэсэг нь юм.

ГАТТ-ыг байгуулах түүх нь дэлхийн хоёрдугаар дайны дараахь жилүүдэд буюу 1946-1948 онуудад НҮБ-ын хүрээнд Олон улсын худалдааны байгууллага байгуулах талаар чармайлт гаргаж байсан тэр үеэс эхлэлтэй.

ГАТТ нь Дэлхийн II дайны дараа олон улсын худалдаа, валютын солилцоо болон хөгжлийн сангийн асуудлуудыг эрхлэх шинэ байгууллагуудын бүтэц бий болгох зорилт тавьсан Бреттон Вудын¹ системийн нэг хэсгийг бүрдүүлсэн байгууллагуудын нэг нь билээ.

Дайны дараахь тэр үед Бреттон Вудын системийн улс орнууд нь энгийнээр хэлэхэд протекционизмыг халж чөлөөт худалдааг хөгжүүлэхийг хүсч байлаа.

Протекционизм гэдэг нь чөлөөт худалдааны эсрэг зүйл бөгөөд чөлөөт худалдааг хязгаарлахыг хэлнэ.

Чөлөөт худалдааг хязгаарлах нь ямар сөрөг үр дагавартай болохыг түүх бэлхнээ харуулж байгаа билээ.

Тухайлбал, судлаачид Англи, Германыг дэлхийн 1, 2 дугаар дайныг өдөөсөн хоёр гол орон гэж үздэг байна.

¹ Бреттон Вуд гэж АНУ-ын Шинэ Хэмпшир дэх жижигхэн хот бөгөөд энд 1944 оны 7 дугаар сарын 1-22-ны өдрүүдэд АНУ, Их Британи, Франц Улсын сайд нар бусад 41 Холбоот улс орны төлөөлөгч-шинжээчидтэй уулсан юм.

“Кеннедийн”, “Токиогийн” үе шатууд хэмээн алдаршсан, 1960-1979 оны хооронд хуралдсан бага хурлууд ихээхэн хувь нэмрээ оруулсны зэрэгцээ 1986-1994 оны хооронд үргэлжилсэн “Уругвайн үе шат” нь ГАТТ-ын хувь заяанд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм.

Ийнхүү олон арван жилийн туршид хийсэн хэлэлцээний үр дүнд ГАТТ-ын системийг боловсронгуй болгох асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 1994 оноос шинэчлэгдсэн Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр буюу “ГАТТ-1994” үйлчилж эхэлсэн байна.

Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээр гэж ямар хэлэлцээрийг хэлэх вэ?

Дэлхийн худалдааны байгууллагаас олон тооны олон талт гэрээ, хэлэлцээр, тохиролцоо, тайлбар, жишиг зэрэг 180 гаруй эрх зүйн баримт бичиг батлан гаргажээ.

Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээрт дараахь багц хэлэлцээр хамаарна. Үүнд:

1. 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр

-1947 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн II-ын IV зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн XVII зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн төлбөрийн тэнцвэрт хамааралтай зүйл, заалтуудтай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн XXIV зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд үүргээс чөлөөлөгдөх талаархи тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн XXVIII зүйлийг тайлбарлахтай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн Марракешийн протокол.

2. Олон талт хэлэлцээр байна:

-Барааны худалдааны тухай олон талт хэлэлцээр;

-Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр; -Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээ хэрэглэх тухай хэлэлцээр;

-Сүлжмэл эдлэл болон хувцасны тухай хэлэлцээр;

-Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр;

-Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр;

-1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр/демпингийн эсрэг/;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр;

-Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр;

-Тарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр;

-Импортын лицензийн журмын тухай хэлэлцээр;

-Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр;

-Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр.

3. Үйлчилгээний худалдааны

Дайн хийх гол шалтгаан нь эдийн засгийн өрсөлдөөн байв. Тэр үеийн хүчирхэг Англи улс нь протекционизмыг дэмжиж чөлөөт худалдаа хийхийг хязгаарлаж байжээ. Англи улс тэр үед Герман улсаас өөрийн колони орнуудтай наймаа хийхэд нь хориг, хязгаар тавьж байжээ. Ийм учраас энэ нь дайн эхлэх гол шалтгаан болсон ч гэж үздэг юм байна.

Дайны дараахь жилүүдэд дэлхийн олон орон протекционист системийг халж чөлөөт худалдааг хөгжүүлэхийг хүсч байлаа.

Тэр үед анхаарал татаж байсан 3 чухал асуудал байв. Үүнд:

- олон улсын худалдааг хөгжүүлэх /хил дамжуулан худалдаа хийх/;

- хөрөнгө оруулалтыг дэмжиж хөгжүүлэх;

- гадаад валютын солилцоог бий болгон хөгжүүлэх.

Тэр үед дотоодын мөнгийг чөлөөтэй хөрвөх гадаад валютад шилжүүлж болдоггүй байлаа.

Дээрх анхаарал татсан 3 асуудалтай холбогдуудан дайны дараа олон чухал үйл явдал өрнөсөн байна. Тухайлбал:

- 1945 онд Сан Францискод НҮБ байгуулагдсан. НҮБ-ын хүрээнд улс орнууд Олон улсын худалдааны байгууллага байгуулах чармайлтыг гаргаж эхэлсэн байна.

- 1946 онд Олон улсын валютын сан болон Дэлхийн Банк байгуулагджээ. Олон улсын валютын сан, түүнчлэн тэр үед Сэргээн босголт болон хөгжлийн олон улсын банк хэмээн нэрлэгдэж байсан Дэлхийн банк нь Бреттон Вудын системд татагдан орсон байлаа. Бреттон Вудын

системийн орнуудын 2 гол төлөөлөгч нь АНУ болон Англи улс байв.

- 1947 онд Бреттон Вудын системийн орнууд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн өмнөх "түр хэлэлцээр"-т гарын үсэг зурав. Уг хэлэлцээрийг Олон улсын худалдааны байгууллага байгуулах хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн боловч ОУХБ нь хэрэг дээрээ хэзээ ч байгуулагдаагүй байна. Учир нь ОУХБ-ыг байгуулах шаардлага, хэрэгцээ байхгүй гэж үзээд ГАТТ-ыг ОУХБ-ын оронд байгуулсан байна⁴.

Ийнхүү ГАТТ-д 1947 оны 10 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурж 1948 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдсөн байна.

Хэдийгээр ГАТТ байгуулагдсанаар олон улсын худалдаанд томоохон хувь нэмэр оруулсан гэдэг нь ойлгомжтой ч ГАТТ нь гагцхүү тун энгийн гэж хэлж болох худалдааг зохицуулж байлаа. Энэ нь тийм ч чанга зохицуулалт биш байв. Тэр үед ГАТТ маш сул байгууллага байв. Ийм ч учраас ГАТТ-ын талаар дахин хэлэлцээ хийж эхэлсэн байна. Дахин хэлэлцээ хийх явц нь хэд хэдэн үе шатыг дамжжээ.

Тухайлбал, ГАТТ-ын хүрээнд тариф бууруулах асуудлаар 1947 онд Женевт, 1949 онд Францын Аннеси хотод, 1950 онд Английн Торки хотод, 1956 онд дахин Женевт бага хурлууд тус тус зохиогджээ. Түүнчлэн ГАТТ-ыг боловсронгуй болгоход "Диллоны",

⁴. 1944 оны 7 дугаар сард хуралдсан Бреттон Вудын бага хурлаар Олон улсын валютын сан болон Дэлхийн банкийг тус тус байгуулсан болно. Уг хоёр байгууллага болон ГАТТ буюу ДХБ нь Бреттон Вудын байгууллагууд гэдэг нэрээр алдаршсан бөгөөд элгээр байгууллага нь хамтдаа Бреттон Вудын Системийг бүрдүүлдэг байна /Зохиогч/.

“Кеннедийн”, “Токиогийн” үе шатууд хэмээн алдаршсан, 1960-1979 оны хооронд хуралдсан бага хурлууд ихээхэн хувь нэмрээ оруулсны зэрэгцээ 1986-1994 оны хооронд үргэлжилсэн “Уругвайн үе шат” нь ГАТТ-ын хувь заяанд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм.

Ийнхүү олон арван жилийн туршид хийсэн хэлэлцээний үр дүнд ГАТТ-ын системийг боловсронгуй болгох асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 1994 оноос шинэчлэгдсэн Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр буюу “ГАТТ-1994” үйлчилж эхэлсэн байна.

Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээр гэж ямар хэлэлцээрийг хэлэх вэ?

Дэлхийн худалдааны байгууллагаас олон тооны олон талт гэрээ, хэлэлцээр, тохиролцоо, тайлбар, жишиг зэрэг 180 гаруй эрх зүйн баримт бичиг батлан гаргажээ.

Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээрт дараахь багц хэлэлцээр хамаарна. Үүнд:

1. 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр

-1947 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн II-ын 1B зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн ХҮП зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн төлбөрийн тэнцвэрт хамааралтай зүйл, заалтуудтай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн ХХIҮ зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд үүргээс чөлөөлөгдөх талаархи тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн ХХҮIII зүйлийг тайлбарлахтай холбогдсон тохиролцоо;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн Марракешийн протокол.

2. Олон талт хэлэлцээр байна:

-Барааны худалдааны тухай олон талт хэлэлцээр;

-Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр; -Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээ хэрэглэх тухай хэлэлцээр;

-Сүлжмэл эдлэл болон хувцасны тухай хэлэлцээр;

-Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр;

-Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр;

-1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн YI зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр /демпингийн эсрэг/;

-1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн YII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр;

-Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр;

-Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр;

-Импортын лицензийн журмын тухай хэлэлцээр;

-Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр;

-Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр.

3. Үйлчилгээний худалдааны

тухай ерөнхий хэлэлцээр /ГАТС/;

4. Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр /ТРИПС/;

5. Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг;

6. Худалдааны бодлого хянах механизмын тухай хэлэлцээр;

7. Олон талт худалдааны хэлэлцээрт:

-Иргэний агаарын тээврийн онгоц худалдах тухай хэлэлцээр;

-Засгийн газрын хангалтын тухай хэлэлцээр;

-Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр;

-Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээр.

/Тайлбар: эдгээр 4 хэлэлцээрийг гагцхүү нэгдэн орсон улс орон дагаж мөрдөх үүрэг хүлээнэ/

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн тухай

ДХБ байгуулах тухай хэлэлцээрт тэмдэглэсний дагуу 1948-1993 онд мөрдөгдөж байсан ГАТТ буюу Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийг "ГАТТ-1947" буюу "ТХЕХ-1947" гэж нэрлэх болсон. Харин ДХБ-ын бүрэлдэхүүнд орсон Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийг "ГАТТ-1994" буюу "ТХЕХ-1994" гэж нэрлэдэг бөгөөд "ГАТТ-1947", "ГАТТ-1994" нь эрх зүйн хувьд өөр өөр баримт бичиг юм¹.

Одоогийн байдлаар, ГАТТ нь ДХБ-тай зэрэгцэн оршин тогтнож байна. ДХБ-ын бүрэлдэхүүнд "ГАТТ-1994" ордог бөгөөд үүнээс үл хамааран "ГАТТ-1947" үйл ажиллагаагаа бие даан үргэлжлүүлсэн хэвээр байгаа

билээ.

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр нь дэлхийн экспортын 90 орчим хувийг эзэлдэг 125 улс оролцсон олон талт хэлэлцээр бөгөөд үндсэн зорилго нь гадаад худалдааг аль болох чөлөөтэй хийх, алдагдалгүй байлгах үндсийг бүрдүүлэн улс орнуудын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр, хандив оруулахад оршино.

ГАТТ нь худалдаа хийх үндсэн зарчмуудыг тусгасан гэрээний үүргээс гадна түүнтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх олон улсын худалдааны шинэ арга зам боломжийг нээх асуудлыг хэлэлцдэг томоохон байгууллага юм.

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр нь Оршил, 38 зүйл бүхий 4 хэсэг, 9 хавсралт, оролцогч улс орнуудын үндэсний гаалийн хөнгөлөлтийн жагсаалтуудаас бүрдэнэ.

1 дүгээр хэсэг буюу 1, 2 дугаар зүйл нь татвар хураамж авах горимыг тодорхойлно. 2 дугаар хэсэг буюу 3-23 дугаар зүйлүүдэд тарифын бус арга хэмжээг авах журмыг тодорхойлсон байдаг. 3 дугаар хэсэг буюу 21-30 дугаар зүйлүүд нь зохион байгуулалт-техникийн асуудлыг хамарсан байна. Тусгайлан тэмдэглэхэд, 13 дугаар зүйлд шинэ тулгар орнуудын эдийн засгийн хөгжилд үзүүлэх засгийн газруудын тусламжийн тухай заасан байдаг бөгөөд уг хэлэлцээрт нэмэлт болон орсон 1 дүгээр хэсэгт энэхүү заалтыг өргөжүүлжээ. "Худалдаа ба хөгжил" гэсэн 1 дүгээр хэсгийг 1966 онд нэмэлт болгон оруулсан ба энэ хэсэг нь хөгжиж буй орнуудад үзүүлэх тусгай хөнгөлөлтүүдийг агуулсан байна.

ГАТТ-ын үндсэн зарчмууд

ГАТТ-ын хүрээнд дор дурдсан хэдэн зарчим нэн чухал үүрэгтэй бөгөөд эдгээр нь бүгд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт тусгагдсан болно. Үүнд:

¹ Г.Сэсээр. Дэлхийн Худалдааны Байгууллагын эрх зүйн зарим асуудал. УБ, 2000 он, 6-7 дахь талд үз.

- “Үндэсний нэн таатай нөхцөл олгох дэглэм” /англиар “Most-Favoured-Nation Treatment” эсхүл “MFN Treatment” гэнэ/ гэдэг зарчим бөгөөд энэ зарчмын дагуу хэлэлцээрт оролцогч улс орнууд өөр хоорондоо худалдаа хийхдээ бусад улсынхтай адил хэмжээний татвар суутгах үүрэг хүлээдэг байна. Ийнхүү оролцогч бүх улс ямар нэгэн улсыг ялгаварлан гадуурхалгүй, тэгш эрхийн үндсэн дээр худалдаа хийж, гаалийн хураамж багасах тохиолдолд бүх оролцогч орон түүний үр ашгийг тэгш хүртэх эрхтэй.

- ГАТТ-ын дараагийн чухал зарчим болох “Үндэсний дэглэм” гэдэг нь татвар ногдуулах /хураах/, дотоодлоо бараа таваар худалдаалах, тээвэрлэх, хуваарилах, ашиглахад импортын бараанд дотоодын бараатай өрсөлдөх адил нөхцөл бүрдүүлэхэд оршино. Энэ зарчмын дагуу импортын бараанд ногдуулах татвар нь ижил төрлийн дотоодын бараанд ногдуулах татвараас дээшгүй байх ёстой.

- Тарифын механизмын тусламжтай худалдааны эрх ашгийг

хамгаалах зарчим нь ГАТТ-ын бас нэг чухал зарчим мөн. Энэ зарчим ёсоор аливаа гишүүн улс орноос худалдаа, эдийн засгийн эрх ашгаа хамгаалах шаардлага гарах үед тарифаас бусад механизм ашиглахыг нь хориглодог. Тарифын механизмаар дамжуулан тухайн улс орны гадаад худалдааны салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээ нь бусад гишүүн улс орны хувьд ил тод байх ёстой.

- Эцэст нь, ГАТТ-ын мөн нэг чухал зарчим болох худалдааны үндсийг тогтвортой хангах зарчмын тухай тэмдэглэх нь зүйтэй юм. Энэ зарчмын дагуу гишүүн улс орнууд өөр хоорондоо худалдаа хийхдээ хэлэлцэж тохирсон гаалийн хураамжийн төвшинг баримталж байх ёстой. Үүнээс гадна, орон бүр бараа тус бүрээр гаалийн хураамжийн хэмжээгээ тодорхойлж тарифын жагсаалт гаргах ёстой. Тохирсон тарифын хэмжээг дахин хэлэлцэн өөрчилж болох боловч бусад гишүүн улс орон үүний хариуд мөн өөрсдийн тарифыг өөрчлөхийг эрмэлзэх тул ГАТТ ийм хандлагыг төдийлөн дэмждэггүй байна.

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ГУРАВДУГААР БҮЛЭГ Хэргийн оролцогч

16 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн

16.1. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн хэргийн оролцогч гэнэ.

16.2. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж буюу өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд мөн.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА-АЗИ, НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН ХЭТИЙН ТӨЛӨВ, МОНГОЛ УЛСЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Хууль зүйн магистр Ш.Үнэнтөгс

Олон улсын харилцааны хөгжлийн хандлага

Ерээд оны эхнээс олон улсын тавцан дээр зарчмын шинж чанартай өөрчлөлтүүд гарч байна. Энэ нь дэлхий ертөнцийг тусгаарлаж байсан үзэл суртлын хаалт нуран унаж, үүнээс улбаалан дэлхийн II дайнаас хойш бүрэлдэн тогтсон олон улсын харилцааны баримтлал өөрчлөгдөж, шинэ тогтолцоонд шилжиж байна. Өөрөөр хэлбэл ЗХУ, АНУ хоёрын хоорондын зөрчилдөөнөөс үүдэн гарч болзошгүй хүйтэн дайны аюулыг сэргийлэх явцын хүрээнд хийгдсэн техник технологийн дэвшил нь улс орнуудын хөгжил цэцэглэлтийг түргэтгэж өгснийг үгүйсгэх аргагүй. Тэгвэл энэ тогтолцоо "дэлхийн шинэ дэг журам" урьдаас юугаараа ялгаатай, онцлогтой, хэр найдвартай тогтолцоо вэ гэдэг нь "манан дундах" тулгамдсан асуудал болоод байна.

Нэг тогтолцоо нөгөөд шилжиж буй нь хуучин тогтолцоонд бүтцийн гурван том өөрчлөлт авчирсан гэж болох юм.

Нэг. Социализм, коммунизмын онол улс төр, эдийн засгийн хувьд үндсэндээ дампуурсан гэж болно.

Хоёр. АНУ-ын эдийн засгийн хүчин чадал аажим буурч ноёлох байр суурь суларч байгаа. Гэхдээ АНУ-ын хүчин чадал үнэмлэхүй хэмжээгээр унаж байгаа асуудал биш юм. Энэ нь дэлхийн санхүүгийн зах зээл дээр ноён доллар дангаар эзэгнэхээ больж евро, иен, юань ч чөлөөтэй хөрөвдөг болсон нь нэгийг хэлж байна.

Гурав. Дэлхийн тавцанд улс орнуудын харилцан хамаарал улам бүр өсч байгаа явдлыг мөн нэрлэж болох байна. Энэ нь зөвхөн олон улсын худалдаа, үндэстэн дамнасан корпорациуд зэрэг эдийн засгийн салбараар хязгаарлагдахгүй, сансарын холбоо, мэдээллийн салбарт хийгдэж буй хувьслууд оюуны харилцан хамаарлыг бий болгож байна. Тухайлбал, ОХУ-д болсон төрийн эргэлт хийх гэсэн 90-ээд оны эхний үеийн оролдлого, Югослав, Иракийн асуудал, Дэлхийн банкны оролцоотой Аргентины санхүүгийн хямрал, Хятадын оюутны хөдөлгөөнийг нухчин дарсан зэрэгт нөлөө үзүүлснийг хэлж болно.

Өмнөх тогтолцооны эдгээр бүтцийн өөрчлөлт нь цаашид ямар үр дүнд хүргэх талаар олон улсын харилцаа судлаачид янз бүрээр тайлбарлаж байна. Тухайлбал,

Олон улсын харилцааны тэнцвэрийн онолыг баримтлагчид:

АНУ-ын хүчин чадал буурч буйг хүлээн зөвшөөрөхийн хамт, дэлхий ертөнц хүчний олон туйлтай тогтолцоонд шилжиж байна гэж үзэж байна. Хэдий хоёр хэт их гүрэн цэрэг зэвсгийн асар их нөөцтэй авч зэвсэглэлээр хөөцөлдөх санхүүгийн хүчин чадал ерөнхий дүнгээрээ бүрэн шавхагдсан. /Иракт довтолсон дайны ажиллагаа бол буурай ганц оронд тулгасан цохилт л байсан/ Иймээс ирээдүйд Хятад, Европ, Энэтхэг болон Япон бие даасан улс төрийн хүч болон гарч ирнэ гээд олон туйлтай тогтолцоог ихэд үнэлж ирээдүйд 5-6 том гүрэн дундаа хүчээ тэнцүүлж байх

хувилбарыг ирээдүйн олон улсын харилцааны тогтвортой хэвшил гэж үзэж байна.

Харин жанжлалд дулдуйдсан тогтвортой байдлын онолчид:

Дэлхийн улс төр, эдийн засаг, соёлын салбарт ноёлож байсан АНУ цаашид уг үүргээ гүйцэтгэж чадахгүй боллоо хэмээн үзэж байна. Иймээс шинэ тогтолцоонд ямар нэгэн улс ноёлохоо больж тэргүүлэгч орон үгүй учир том гүрнүүдийн хооронд улс төр-эдийн засгийн өрсөлдөөн ширүүсч, хүчний шинэ хуваарилт бий болж, шинээр эвсэл холбоод үүсэх төлөв ажиглагдаж байна.

Үндсэндээ энэ хоёр онол аль аль нь хэт их гүрнүүд устаж, хэдэн орны хамтын тогтолцоо үүснэ гэдэг дээр санаа нэгдэж байна. Харин шинэ тогтолцоо хэр найдвартай байх вэ гэдэг асуудалтай юм. Энэ талаар эхний онолчид тогтвортой байдал ноёлоно гэж буй бол, хоёр дахь нь тогтворгүй байдал давамгайлна гэж байгаа.

Эцэст нь энэ бүхнээс үндэслэлд цаашид олон улсын харилцааны хөгжлийн хандлагыг зэрэг, сөрөг, төвийн гэж гурав ангилж болох юм.

- *Хөгжлийн зэрэг хандлагатайд:* Хоёр үзэл суртлын сөргөлдөөн эцэс боллоо. Их гүрнүүдийн харилцаа сайжирч хамтран ажиллах чадвар бүрэлдэж буй.

- *Төвийн хандлагатайд:* зэрэг, сөрөг тал руу эргэж болох үйл явц.

Дэлхийн эдийн засгийн бүлэглэлүүд бий болж, бүс нутагт биеэ даасан хүчнүүд Хятад, Энэтхэг, Япон, Солонгос, Иран, Бразил хүчжиж байгаа.

- *Сөрөг хандлагатайд:* үндэсний дөвийлгөх үзэл, шашны хэт үзэл сурталжилт дахин сэргэж, үндэстэн хоорондын болон газар нутгийн зөрчил хурцдан, их гүрнүүдийн

оролцоо багасснаар зэвсэглэлээр хөөцөлдөх, ялангуяа цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх болсон зэрэг нь багтаж байна. Үүнд лалын ертөнц, олон улс дамнасан зохион байгуулалттай террорист үйл ажиллагаа зэргийг нэрлэж болох юм.

Иймд энэ зууны олон улсын харилцааны хөгжлийн төлөв дээрх гурван зарчмаар явагдах нь тодорхой болж түүнд тулгуурласан философи боловсруулагдаж байна гэхэд болно.

Ази, Номхон далайн орнуудын хамтын нийгэмлэгийн ерөнхий төлөв, Монголын эзлэх байр суурь

АНУ-ын ерөнхийлөгч, эцэг Буш хэдхэн жилийн өмнө Японд айлчлах үеэрээ Васэдагийн Их Сургууль дээр хэлсэн үгэндээ “Ази, Номхон далайн шинэ хамтын нийгэмлэг”-ийн үзэл санааг анх дэвшүүлсэн гэдэг. Энэ үзэл санаа нь цагийн аясыг дагасан хоосон чамирхал бус Ази-Номхон далайн бүс нутгийн шинээр бүрэлдсэн бодит байдлын илэрхийлэл байсан юм.

Хүйтэн дайн эцэслэснээр ч бүс нутгийн хоорондын цэрэг стратегийн зөрчил үргэлжилсээр байгаа хэдий боловч тэдний хооронд худалдаа эдийн засгийн уялдаа холбоо улам бүр нэмэгдэх төлөвтэй. Юуны өмнө Азийн тэр дундаа Зүүн Азийн орнуудын хурдацтай эдийн засгийн хөгжил дэлхийн анхаарлын төвд байна. “Зүүн Азийн эдийн засгийн гайхамшиг” /The East Economic Miracle/ төсөл ч үүнийг нотлож байна. Гэхдээ одоогоор нүүрлээд байгаа эдгээр азийн баруудын эдийн засгийн хямрал нь тухайн бүс нутаг, орнуудын диктатурт дэглэмийн урхагтай төрийн хэт оролцоо-зохицуулалт бүхий санхүү, мөнгөний алдаатай стратеги болон өрнөдийн орнуудын санаатай явуулж буй үйлдэл болох нь харагдаж, цаашид нэг их нөлөөлөхгүй нь тодорхой боллоо. Өөрөөр хэлбэл азийн хүн ам 2

тэрбум гаруй хэрэглэгч бүхий асар өргөн зах зээл юм.

Нэгэнтээ АНУ-ын Сангийн сайд Бенсен хэлэхдээ: Азийн хүн ам дундаж орлоготой америкчүүдтэй тэнцэх худалдан авах чадвартай хүн амын тоо 75 саяаас давах тооцоо гарч буй тухай дурьдсан нь бас нэгийг хэлж байна.

Өөрөөр хэлбэл, эх газрын Хятад, Тайван, Гонконгоос бүрэлдсэн нэг ёсны "Их хятад"-ын эдийн засгийн бүс бүрэлдэж байна. Мөн БНХАУ-ын санаачлагаар АСЕАН+3 буюу БНХАУ, БНСУ, Японы эдийн засгийн эвсэл - Азийн дэлхийн худалдааны байгууллагын загварыг бүрдүүлэхээр төлөвлөж буй сураг ч байдаг.

Сүүлийн арваад жил тэрбум гаруй хүн амтай хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац жилд 10 хувиас давж байна. Өнөөдөр дэлхий нийтийн дотоодын нийт бүтээгдэхүүний 23 орчим хувийг АНУ, 16 хувийг Япон эзлэж байгаа боловч энэ зууны эхний хагаст Хятадын эдийн засаг үнэмлэхүй хэмжээгээр дэлхийн хамгийн том болох нь гарцаагүй юм.

Одоогоор Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт хамгийн өндөр хурдацтай байгаа. Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 1,2 триллион ам.доллараар 2002 онд дэлхийд тав, гадаад худалдааны эргэлт 500 тэрбум доллар, валютын нөөц 286 тэрбум доллараар гуравдугаар байранд орсон. Өөрөөр хэлбэл БНХАУ дундаж чинээлэг хүмүүсийн нийгэм байгуулах, өөрөөр хэлбэл нийгмийн асуудлыг шийдвэрлэх тухай одоо ярьж байна.

Нөгөө талаас хятадын эдийн засаг бусдын адил бөгөөд тийм ч айхтар өгсөх шугамаар хөгжиж буй биш учраас эрх баригчид нь энэ тухай тун бага ярьж байгаа. Энэ нь 1980-1994 онуудад эдийн засгийн "хэт халалтын" 4 үе шатуудыг үзчихсэн. Үүнийг

зохицуулахын тулд Хятадын засгийн газраас зоримог арга хэмжээ авсны дүнд "зөөлөн газардах" бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн гэдэг.

Гэсэн хэдий боловч БНХАУ Азийн дөрвөн барын үр шимийг нь үзэж, хэрэгжүүлж чадаагүй "*Хөөж гүйцэх*" хөгжлийн стратегийг амжилттай хэрэглэж ирсэн ч түүнийгээ халж, өөрийн гэсэн үзэл баримтлалыг боловсруулан эдийн засгийн өсөлтөөс хяналтгүй замбараагүйтэл, огцом саатал, уналт руу шилжихээс сэргийлэх бодлого барьж байна.

Нөгөө талаас Ази-Номхон далайн бүс нутагт ардчилалын салхи үлээх бус шуурч эхэллээ. Улс төрийн диктатур цэргийн дэглэм ноёрхсон оронд эдийн засгийн хиймэл өсөлт үсрэнгүй болохыг дээрх орнууд харуулж байна. Гэвч боловсролтой чинээлэг хүн амын давхарга нэмэгдэхийн сацуу улс төрийн ардчилалыг шаарддаг нь тодорхой болдоо. Ардчилсан улсууд хоорондоо түншилж нөхөрлөж чаддаг, хоорондоо дайн хийхгүй, алан хядлагагүй, дүрвэгсэдийг төрүүлдэггүй нь нэгэнт өргөжин тэлэхийг дагалдан бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн баталгаа улам бүр гүнзгийрнэ гэхэд хилсдэхгүй.

Энэ бүхэнд мэдээлэл, технологийн өргөн сүлжээ ихээхэн үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Бүс нутгийн талаархи их гүрнүүдийн байр суурь

Энэ бүс нутгийн ирээдүйн төлөвийг мэдэхийн тулд АНУ, ОХУ, Хятад, Япон зэрэг улсын байр суурийг мэдрэх хэрэгтэй.

ЗХУ задран унаснаар зөвлөлтийн цэргийн аюул үндсэндээ Азийн олон орны хувьд бодит бус боллоо.

АНУ: Ийм нөхцөлд АНУ-аас Япон, Өмнөд Солонгос зэрэг оронтой

байгуулсан гэрээнүүд хэвээр байх аваас хэнээс юуг хамгаалахад чиглэх вэ гэдэг асуудал бүс нутгийн гол гогцоо болон гарч ирээд байна. Азийн аюулгүй байдалд АНУ-ын гүйцэтгэх үүрэг Солонгосын хойгоос бусад нутгаас цэргээ гаргахад азд цэргийн хүчний хоосон орон зай үүсч тэнцвэрт бус байдал үүснэ гэдгээс АСЕАН-ийн орнууд ихэд эмээж байгаа. Учир нь:

- Америк-Японы гэрээг хэвээр хадгалах нь япон эдийн засгийн асар их чадавхиа цэргийн болгон хувиргах. Өөрөөр хэлбэл цэргийн их гүрэн болгох сонирхолгүй.

- Мөн Хятадын эдийн засгийн боломжийг дагалдан цэргийн хүчин хүчирхэгжихээс Азийн орнууд эмээж байна.

- Энэтхэг-Пакистаны зөрчилдөөнийг тэнцвэржүүлэгч хүч нь амеркийн цэргийн үүрэг болох нь тодорхой харагдаж байна. /Түүнчлэн энд лалын ертөнц + бусад улс гэж нэмж болох юм/

Энэ бүхнээс харахад АНУ-ын цэргийн хүчний гүйцэтгэх үүрэг аажмаар өөрчлөгдөж бүс нутгийн болзошгүй аюулаас сэргийлэгч болж хувирах хандлагатай юм.

Америкаас Азитай хийх худалдааны хэмжээ америкийн гадаад худалдааны 36 хувь буюу 63 тэрбум долларт хүрээд байна. Энэ нь ч АНУ-тай худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөтгөх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн азийн зарим нөлөөлөх орон америкийн нөлөөг сулруулах бодлого явуулсаар байгаа бөгөөд гол нь АНУ-ын дотоодол, өөрөөр хэлбэл Конгресс, ард иргэд нь дэлхийн цэргийн цагдаагийн үүргийг дэмжихгүй болоод байна.

ОХУ: ЗХУ-ыг бодвол ОХУ Ази номхон далайн орон гэж хэлэх

үндэслэлтэй болжээ. ОХУ нь Сибирь, Алс дорнодын байгалийн баялагаас улам бүр хамаарах болж, Балти, Хар далай хавийн боомтоо алдснаас хойш Номхон далайн боомтуудын ач холбогдол эрс өссөн. Цэргийн хүчний хувьд их гүрэн хэмээгддэг орос гүрэн тус бүс нутгийн эдийн засагт оролцох оролцоогоо өргөтгөх зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Өөрөөр хэлбэл Сибирь, Алс дорнодыг хамарсан 1992 онд боловсруулсан “Интергратор 21” төсөлд их найдлага тавьж байгаа.

Гэвч дэд бүтэц хөгжөөгүй, хууль тогтоомж тодорхой бус, Япон зэрэг бүс нутгийн орнуудтай газар нутгийн маргаантай, Москва болон орон нутгийн эрх үүргийн ялгаа тодорхойгүй, замбараагүй байгаа зэргээс шалтгаалан явц удаан байна. Шинэ Оросын удирдлага энэ зүйлд ихээхэн чармайлт тавьсангүй. Хэдийгээр шинээр сонгогдсон ерөнхийлөгч В.В.Путин дэлхий нийт, бүс нутгийн хүрээнд ихээхэн нэр хүнд бүхий байж, үйл ажиллагаа явуулж байгаа боловч энэ нь зөвхөн *“үхсэн буурын толгойноос амьд ат айна”* гэгчээр зөвлөлүүдийн их гүрний хоосон орон зайг үгүйлсэн сэтгэл зүй дээрх чадварлаг, хоромхон зуурын тоглолт гэж хэлж болно. Гэвч НҮБ-ын байнгын гишүүний хувиар бүс нутгийн аюулгүйн систем боловсруулахад голлох үүрэгтэй оролцдог.

Түүнчлэн АСЕАН-ны удирдлагад оролцдог зэрэг нь бүс нутгийн ажиллагаанд оролцох оролцоог бодитой болгож байдаг.

Гэвч сая болж өнгөрсөн Ирак, АНУ-ын эвслийн хоорондох дайнд тодорхой байр суурь баримтлаж байсан авч Ирак болон тус бүс нутаг дахь өөрийн улсын стратегийн ашиг сонирхолыг хамгаалах талаар шийдвэртэй алхам хийж чадсангүй. Аялдан дагалдагчийн байр сууринаас

дотоодын улс төрийн хэт намжим байдал ихээхэн түгшүүр төрүүлдэг. Өөрөөр хэлбэл саяхан сэлгээ хийсэн нам, төр ямархуу байр суурь баримтлах, улс төрийн тогтвортой байдлын номлолоо шаргуу баримтлах эсэх нь хамаг зүйлийн гогцоо болж байна.

Мэдээж энд дорно дахины, өөрөөр хэлбэл эртний хятадын төрийн уламжлалыг бодолцоход ч тэр төрийн бодлогын залгамж чанараа хадгалсаар байх нь ойлгомжтой боловч хамгийн гол нь цаг хугацааны фактор үүнийг эрс үгүйсгэж байна. Учир нь хуучин нээлттэй атлаа хаалттай дэглэмийг номлосон Дэнизмийн үе үзэл суртлаар халхавчлан санхүүгийн ертөнцийг базах, өөрсдийн үзэмжээр чиглүүлэн хөдөлгөх цаг дуусч, харин ч капиталистуудын хүснээр бодлого боловсруулдаг болж байх шиг. Энэ бол нууц биш зүйл, бас хэт их гайхмаар ч, хачирхаад байхаар зүйл биш нь ойлгомжтой. Одоо БНХАУ-ыг 60 гэр бүл тодорхойлж байна. Өмчийн хэт ялгаа бүхий, өөр өөр дэглэмийг хүлээн зөвшөөрөхүйц уур амьсгал бүрэлдсэн энэ нийгэмд хуучин удирдагчдын бодлогоор хамаг зүйл ярс хийтэл шийтэгддэг нь үеэ элээж, өнгөн талдаа, дээд давхаргадаа л бүх юм ном, жамын дагуу байгаа мэт боловч дундаас доод шатанд бүх зүйл мөнгөний үнэ цэнээр хэмжигдэн түүндээ хөтлөгдөн захирагдаж байгаа. Иймд энэ эзэнт гүрний доогуур маш том ангал ухагдаж, ширүүхэн хөдлөхөд л нимгэн -өнгөн дээд давхарга нуран унаж, живхэд бэлэн болоод буй нөгөө л эзэнт гүрнүүдийн тавилан хүлээж буйг хэлэх хэрэгтэй. Гэвч хятадын онцлогийг харуулж харин ч өөрийн үзэл суртлаа доорх ангалын байдалтай хэрхэн уялдуулан хэсэг тэсч үлдэх, эсвэл шоо шинэ гүрний ойлгоц бүрлүүлэх гэсэн хоёр алхам л үлдээд байгаа гэж хэлж болох юм. Үүнээс өөр ямар нэг гарц

байгаа нь харагдахгүй байна.

Дээр өгүүлсэн бүхнээс үүдээд ойрын ирээдүйд хятадын эдийн засгийг юу хүлээж байна вэ гэдэг нь туйлаас чухал. Дахин давтахад энэ орны бүх зүйлийн хөдөлгөгч хүчин зүйл бол эдийн засаг байсан, байсаар ирсэн, байх ч болно. Өөр юу ч биш. Иймд үнэлэлт дүгнэлт өгч аль нэг талыг барьж явцуурах, бас тус орны аж ахуйн хөгжилд огцом ахиц гараад ирнэ гэж таамаглахаа түр хойш тавиад өнөө цаг үед анхаарлаа хандуулжгаа. Ер нь статистик үзүүлэлтүүд, судлаач, дипломатчдын өгүүллүүд, жирийн ахуй хязгаарын байдал зэрэг олон зүйлд тулгуурлан ажиглахад хятадын дээд амжилтын үе шувтарч, нийт орныхоо аж ахуйн бүтцийг өөрчилж, дэлхийн зах зээлд зохицуулах удаан хугацааны, ээдрээтэй үе хүлээж байна. Энэ үе “хэт халалт”-ын 4 үе шатыг давсантайгаа адилхан амжилттай өнгөрч нөгөө л “зөөлөн газардах” уу, эсвэл үгүй юу гэдгийг цаг хугацаа харуулах бизээ.

Ямартай ч хятадын эдийн засгийн энэ эгзэгтэй байдал тус бүс нутагт, тэр дундаа манай их хөрш Орост яаж нөлөөлөх нь бидний хувьд чухал асуудал.

Эцсийн дүндээ бүхий л талаас нь аваад үзэхэд урд хөршийн маань эдийн засгийн хөгжлийн амжилттай байдал манай оронд ашиггүйгээр барахгүй маш их аюултай! Хятад эдийн засгийн хэт их гүрэн болчихвол биднийг, манай улсыг өнө удаан хугацааны турш Хятадын нөөцийн хавсаргын байранд тавьчихана. Өөрөөр хэлбэл түүх давтагдах болно. Тухайлбал, манай улс одоо ердөө гуравхан төрлийн стратегийн бүтээгдэхүүн экспортлож байна. Тэдний ихэнх нь урд хөрш рүү. Ашигт малтмалыг эс тооцвол арьс шир, ноос ноолуурын дийлэнх буюу 90 гаруй хувийг урагшаа, бүр нарийн ярьвал БНХАУ-ын Хэбэй мужид нийлүүлж байна. Хэбэй манай түүхий

тэрбум гаруй хэрэглэгч бүхий асар өргөн зах зээл юм.

Нэгэнтээ АНУ-ын Сангийн сайд Бентсен хэлэхдээ: Азийн хүн ам дундаж орлоготой америкчүүдтэй тэнцэх худалдан авах чадвартай хүн амын тоо 75 саяаас давах тооцоо гарч буй тухай дурьдсан нь бас нэгийг хэлж байна.

Өөрөөр хэлбэл, эх газрын Хятад, Тайван, Гонконгоос бүрэлдсэн нэг ёсны "Их хятад"-ын эдийн засгийн бүс бүрэлдэж байна. Мөн БНХАУ-ын санаачлагаар АСЕАН+3 буюу БНХАУ, БНСУ, Японы эдийн засгийн эвсэл - Азийн дэлхийн худалдааны байгууллагын загварыг бүрдүүлэхээр төлөвлөж буй сураг ч байдаг.

Сүүлийн арваад жил тэрбум гаруй хүн амтай хятадын эдийн засгийн хөгжлийн хурдац жилд 10 хувиас давж байна. Өнөөдөр дэлхий нийтийн дотоодын нийт бүтээгдэхүүний 23 орчим хувийг АНУ, 16 хувийг Япон эзлэж байгаа боловч энэ зууны эхний хагаст Хятадын эдийн засаг үнэмлэхүй хэмжээгээр дэлхийн хамгийн том болох нь гарцаагүй юм.

Одоогоор Хятадын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт хамгийн өндөр хурдацтай байгаа. Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 1,2 триллион ам.доллараар 2002 онд дэлхийд тав, гадаад худалдааны эргэлт 500 тэрбум доллар, валютын нөөц 286 тэрбум доллараар гуравдугаар байранд орсон. Өөрөөр хэлбэл БНХАУ дундаж чинээлэг хүмүүсийн нийгэм байгуулах, өөрөөр хэлбэл нийгмийн асуудлыг шийдвэрлэх тухай одоо ярьж байна.

Нөгөө талаас хятадын эдийн засаг бусдын адил бөгөөд тийм ч айхтар өгсөх шугамаар хөгжиж буй биш учраас эрх баригчид нь энэ тухай тун бага ярьж байгаа. Энэ нь 1980-1994 онуудад эдийн засгийн "хэт халалтын" 4 үе шатуудыг үзчихсэн. Үүнийг

зохицуулахын тулд Хятадын засгийн газраас зоримог арга хэмжээ авсны дүнд "зөөлөн газардах" бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн гэдэг.

Гэсэн хэдий боловч БНХАУ Азийн дөрвөн барын үр шимийг нь үзэж, хэрэгжүүлж чадаагүй "*Хөөж гүйцэх*" хөгжлийн стратегийг амжилттай хэрэглэж ирсэн ч түүнийгээ халж, өөрийн гэсэн үзэл баримтлалыг боловсруулан эдийн засгийн өсөлтөөс хяналтгүй замбараагүйтэл, огцом саатал, уналт руу шилжихээс сэргийлэх бодлого барьж байна.

Нөгөө талаас Ази-Номхон далайн бүс нутагт ардчилалын салхи үлээх бус шуурч эхэллээ. Улс төрийн диктатур цэргийн дэглэм ноёрхсон оронд эдийн засгийн хиймэл өсөлт үсрэнгүй болохыг дээрх орнууд харуулж байна. Гэвч боловсролтой чинээлэг хүн амын давхарга нэмэгдэхийн сацуу улс төрийн ардчилалыг шаарддаг нь тодорхой болдоо. Ардчилсан улсууд хоорондоо түншилж нөхөрлөж чаддаг, хоорондоо дайн хийхгүй, алан хядлагагүй, дүрвэгсэдийг төрүүлдэггүй нь нэгэнт өргөжин тэлэхийг дагалдан бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн баталгаа улам бүр гүнзгийрнэ гэхэд хилсдэхгүй.

Энэ бүхэнд мэдээлэл, технологийн өргөн сүлжээ ихээхэн үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

Бүс нутгийн талаархи их гүрнүүдийн байр суурь

Энэ бүс нутгийн ирээдүйн төлөвийг мэдэхийн тулд АНУ, ОХУ, Хятад, Япон зэрэг улсын байр суурийг мэдрэх хэрэгтэй.

ЗХУ задран унаснаар зөвлөлтийн цэргийн аюул үндсэндээ Азийн олон орны хувьд бодит бус боллоо.

АНУ: Ийм нөхцөлд АНУ-аас Япон, Өмнөд Солонгос зэрэг оронтой

байгуулсан гэрээнүүд хэвээр байх аваас хэнээс юуг хамгаалахад чиглэх вэ гэдэг асуудал бүс нутгийн гол голцоо болон гарч ирээд байна. Азийн аюулгүй байдалд АНУ-ын гүйцэтгэх үүрэг Солонгосын хойгоос бусад нутгаас цэргээ гаргахад азид цэргийн хүчний хоосон орон зай үүсч тэнцвэрт бүс байдал үүснэ гэдгээс АСЕАН-ийн орнууд ихэд эмээж байгаа. Учир нь:

- Америк-Японы гэрээг хэвээр хадгалах нь япон эдийн засгийн асар их чадавхиа цэргийн болгон хувиргах. Өөрөөр хэлбэл цэргийн их гүрэн болгох сонирхолгүй.

- Мөн Хятадын эдийн засгийн боломжийг дагалдан цэргийн хүчин хүчирхэгжихээс Азийн орнууд эмээж байна.

- Энэтхэг-Пакистаны зөрчилдөөнийг тэнцвэржүүлэгч хүч нь амеркийн цэргийн үүрэг болох нь тодорхой харагдаж байна. /Түүнчлэн энд лалын ертөнц + бусад улс гэж нэмж болох юм/

Энэ бүхнээс харахад АНУ-ын цэргийн хүчний гүйцэтгэх үүрэг аажмаар өөрчлөгдөж бүс нутгийн болзошгүй аюулаас сэргийлэгч болж хувирах хандлагатай юм.

Америкаас Азитай хийх худалдааны хэмжээ америкийн гадаад худалдааны 36 хувь буюу 63 тэрбум долларт хүрээд байна. Энэ нь ч АНУ-тай худалдаа эдийн засгийн харилцаагаа өргөтгөх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн азийн зарим нөлөөлөх орон америкийн нөлөөг сулруулах бодлого явуулсаар байгаа бөгөөд гол нь АНУ-ын дотоодод, өөрөөр хэлбэл Конгресс, ард иргэд нь дэлхийн цэргийн цагдаагийн үүргийг дэмжихгүй болоод байна.

ОХУ: ЗХУ-ыг бодвол ОХУ Ази номхон далайн орон гэж хэлэх

үндэслэлтэй болжээ. ОХУ нь Сибирь, Алс дорнодын байгалийн баялагаас улам бүр хамаарах болж, Балти, Хар далай хавийн боомтоо алдснаас хойш Номхон далайн боомтуудын ач холбогдол эрс өссөн. Цэргийн хүчний хувьд их гүрэн хэмээгддэг орос гүрэн тус бүс нутгийн эдийн засагт оролцох оролцоогоо өргөтгөх зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Өөрөөр хэлбэл Сибирь, Алс дорнодыг хамарсан 1992 онд боловсруулсан "Интергратор 21" төсөлд их найдлага тавьж байгаа.

Гэвч дэл бүтэц хөгжөөгүй, хууль тогтоомж тодорхой бус, Япон зэрэг бүс нутгийн орнуудтай газар нутгийн маргаантай, Москва болон орон нутгийн эрх үүргийн ялгаа тодорхойгүй, замбараагүй байгаа зэргээс шалтгаалан явц удаан байна. Шинэ Оросын удирдлага энэ зүйлд ихээхэн чармайлт тавьсангүй. Хэдийгээр шинээр сонгогдсон ерөнхийлөгч В.В.Путин дэлхий нийт, бүс нутгийн хүрээнд ихээхэн нэр хүнд бүхий байж, үйл ажиллагаа явуулж байгаа боловч энэ нь зөвхөн *"рхсэн буурын толгойноос амьд ат айна"* гэгчээр зөвлөлүүдийн их гүрний хоосон орон зайг үгүйлсэн сэтгэл зүй дээрх чадварлаг, хоромхон зуурын тоглолт гэж хэлж болно. Гэвч НҮБ-ын байнгын гишүүний хувиар бүс нутгийн аюулгүйн систем боловсруулахад голлох үүрэгтэй оролцдог.

Түүнчлэн АСЕАН-ны удирдлагад оролцдог зэрэг нь бүс нутгийн ажиллагаанд оролцох оролцоог бодитой болгож байдаг.

Гэвч сая болж өнгөрсөн Ирак, АНУ-ын эвслийн хоорондох дайнд тодорхой байр суурь баримтлаж байсан авч Ирак болон тус бүс нутагдах өөрийн улсын стратегийн ашиг сонирхолыг хамгаалах талаар шийдвэртэй алхам хийж чадсангүй. Аялдан дагалдагчийн байр сууринаас

хандсаар хоцорч, өөрийн ашиг сонирхолоо хангуулах талаар АНУ-аас гуйх л үлдээд байна. Мөн Хятадын эгзэгтэй байдал буюу эдийн засгийн хувьсал буруу гишгэж явбал хэт хяналтгүй байдлаас шалтгаалан олон зуун сая хятадууд Орос нутагт хяналтгүйгээр цагаачлан орж одоо бий болоод байгаа Сибирь, Алс дорнодод үүссэн байдлаас илүүтэйгээр үндэснийх нь аюулгүй байдалд хүчтэйгээр нөлөөлж болзошгүй юм. Эцэст нь хэлэхэд Их Оросын хэмжээнд хүрч очиход наад зах нь хагасзуу гаруй шахам жил шаардлагатай гэж үзэж болох байна.

Япон: Хэрвээ Орос цэргийн их гүрэн бол Япон эдийн засгийн хэт их гүрэн болох нь тодорхой. Иймд тус бүс нутагт Японы үүрэг роль ямар болох нь илэрхий. Гэхдээ дэлхийн дайнд ялагдсан уг орон одоо болтол Оростой найрамдлын гэрээ байгуулаагүй. Хятад болон зүүн өмнөд ази, далайн орнуудын өмнө нүглээ бүрэн наминчилж дуусаагүй байгаа. Иймд Япон шинэ байр сууриа тодорхойлох болж байна. Тэгээд ч Японы томоохон бизнесмен, нөлөөлөх улс төрчид Японыг азиад буцаан авчирх буюу НеоЭйшанизм үзэл дэвшүүлэх боллоо.

Энэ онол нь: Япон Ази-Номхон далайн стратегийн тулгын гурван чулуун дээр тогтоно гэсэн утга бүхий юм.

- Бүс нутгийн энх тайван байдлыг хангах механизмыг хүчтэй болгох, АНУ-тай цэрэг стратегийн хүрээнд хийсэн гэрээг батгах;

- Хуучин социалист орнууд ялангуяа ОХУ, Хятад болон Вьетнамыг бүс нутгийн хамтын нийгэмлэгийн хариуцлагатай гишүүн болгон нэгтгэж авах асуудал багтдаг үзэл юм.

Ялангуяа Япон улс эдийн засгийн аврага, улс төрийн давжаа биетэн хочноосоо салах. Өөрөөр хэлбэл НҮБ-

ын байнгын гишүүн болох дэлхийн энх тайван байдлыг хангахад мөнгө хандивладаг улс байх биш хүн хүчний болоод эрх зүйн оролцоогоо өргөтгөх бодлого баримтлах боллоо.

Хэдийгээр тус улсад эдийн засгийн хямрал сүүлийн 10 жилийн турш үргэлжилж, санхүү, банкны зах зээл нь дэлхийн хэмжээнд байтугай бүсийн хэмжээний цар хүрээгээ алдсаар, хумигдсаар байгаа хэдий боловч тус улсаас буурай хөгжилтэй улс орнуудтай түншилж буй операц-шинэ бодлого нь үр дүнд хүргэх нь ойлгомжтой бөгөөд тэдэнд шинэ боломжийг нээж өгч байна.

Хятад: 1989 оны Тяньаньмэний талбайд болсон явдлаас хойш одоо БНХАУ дипломат ганцаардлаас гарсан төдийгүй Ази-Номхон далай, дэлхий нийтэд байр сууриа бэхжүүлж чадлаа. Эхний шатанд Азийн орнуудтайгаа харилцаагаа хэвийн болгосон төдийгүй зарим орнуудтай дипломат харилцаагаа сэргээсэн. Тайвань болон Гонконгд буй хятад үндэстнээрээ дамжуулан асар их хөрөнгө оруулалт хийж байна. Хоёр дахь алхам буюу АНУ болон Европын орнуудтай харилцаагаа сэргээхдээ асар их хэрэглэгчтэй зах зээлээ овжин ашиглаж ирлээ. Үүнд европын ажилгүйдэлд нэрвэгдээд буй нь амархан урхинд оруулах шалтаг өгч байна.

БНХАУ-ын дарга удаа дараа АНУ-д айлчилж харилцаагаа хэвийн болгосон нь, мөн АНУ-ын шинэ ерөнхийлөгч дайны хэнээтэн бага Ж.Буш БНХАУ-ын талаархи АНУ-ын шинэ бодлогыг тодорхойлохдоо *БНХАУ нь АНУ-ын стратегийн гол өрсөлдөгч хэмээн зарласан зэрэг нь улс төрийн хувьд томоохон ялалт болж дэлхий нийтэд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн их гүрний зиндаанд шуудхан түлхчихсэн сайхан бололцоо олгосон юм. Хэдий тийм ч Хятадын

дотоодын улс төрийн хэт намжим байдал ихээхэн түгшүүр төрүүлдэг. Өөрөөр хэлбэл саяхан сэлгээ хийсэн нам, төр ямархуу байр суурь баримтлах, улс төрийн тогтвортой байдлын номлолоо шаргуу баримтлах эсэх нь хамаг зүйлийн гогцоо болж байна.

Мэдээж энд дорно дахины, өөрөөр хэлбэл эртний хятадын төрийн уламжлалыг бодолцоход ч тэр төрийн бодлогын залгамж чанараа хадгалсаар байх нь ойлгомжтой боловч хамгийн гол нь цаг хугацааны фактор үүнийг эрс үгүйсгэж байна. Учир нь хуучин нээлттэй атлаа хаалттай дэглэмийг номлосон Дэнизмийн үе үзэл суртлаар халхавчлан санхүүгийн ертөнцийг базах, өөрсдийн үзэмжээр чиглүүлэн хөдөлгөх цаг дуусч, харин ч капиталистуудын хүснээр бодлого боловсруулдаг болж байх шиг. Энэ бол нууц биш зүйл, бас хэт их гайхмаар ч, хачирхаад байхаар зүйл биш нь ойлгомжтой. Одоо БНХАУ-ыг 60 гэр бүл тодорхойлж байна. Өмчийн хэт ялгаа бүхий, өөрөөр дэглэмийг хүлээн зөвшөөрөхүйц уур амьсгал бүрэлдсэн энэ нийгэмд хуучин удирдагчдын бодлогоор хамаг зүйл ярс хийтэл шийдэгддэг нь үеэ элээж, өнгөн талдаа, дээд давхаргадаа л бүх юм ном, жамын дагуу байгаа мэт боловч дундаас доод шатанд бүх зүйл мөнгөний үнэ цэнээр хэмжигдэн түүндээ хөтлөгдөн захирагдаж байгаа. Иймд энэ эзэнт гүрний доогуур маш том ангал ухагдаж, ширүүхэн хөдлөхөд л нимгэн -өнгөн дээд давхарга нуран унаж, живхэд бэлэн болоод буй нөгөө л эзэнт гүрнүүдийн тавилан хүлээж буйг хэлэх хэрэгтэй. Гэвч хятадын онцлогийг харуулж харин ч өөрийн үзэл суртлаа доорх ангальн байдалтай хэрхэн уялдуулан хэсэг тэсч үлдэх, эсвэл цоо шинэ гүрний ойлгоц бүрдүүлэх гэсэн хоёр алхам л үлдээд байгаа гэж хэлж болох юм. Үүнээс өөр ямар нэг гарц

байгаа нь харагдахгүй байна.

Дээр өгүүлсэн бүхнээс үүдээд ойрын ирээдүйд хятадын эдийн засгийг юу хүлээж байна вэ гэдэг нь туйлаас чухал. Дахин давтахад энэ орны бүх зүйлийн хөдөлгөгч хүчин зүйл бол эдийн засаг байсан, байсаар ирсэн, байх ч болно. Өөр юу ч биш. Иймд үнэлэлт дүгнэлт өгч аль нэг талыг барьж явцуурах, бас тус орны аж ахуйн хөгжилд огцом ахиц гараад ирнэ гэж таамаглахаа түр хойш тавиад өнөө цаг үед анхаарлаа хандуулцгаая. Ер нь статистик үзүүлэлтүүд, судлаач, дипломатчдын өгүүллүүд, жирийн ахуй хязгаарын байдал зэрэг олон зүйлд тулгуурлан ажиглахад хятадын дээд амжилтын үе шувтарч, нийт орныхоо аж ахуйн бүтцийг өөрчилж, дэлхийн зах зээлд зохицуулах удаан хугацааны, ээдрээтэй үе хүлээж байна. Энэ үе "хэт халалт"-ын 4 үе шатыг давсантайгаа адилхан амжилттай өнгөрч нөгөө л "зөөлөн газардах" уу, эсвэл үгүй юу гэдгийг цаг хугацаа харуулах бизээ.

Ямартай ч хятадын эдийн засгийн энэ эгзэгтэй байдал тус бүс нутагт, тэр дундаа манай их хөрш Орос таяж нөлөөлөх нь бидний хувьд чухал асуудал.

Эцсийн дүндээ бүхий л талаас нь аваад үзэхэд урд хөршийн маань эдийн засгийн хөгжлийн амжилттай байдал манай оронд ашиггүйгээр барахгүй маш их аюултай! Хятад эдийн засгийн хэт их гүрэн болчихвол биднийг, манай улсыг өнө удаан хугацааны турш Хятадын нөөцийн хавсаргын байранд тавьчихана. Өөрөөр хэлбэл түүх давтагдах болно. Тухайлбал, манай улс одоо ердөө гуравхан төрлийн стратегийн бүтээгдэхүүн экспортлож байна. Тэдний ихэнх нь урд хөрш рүү. Ашигт малтмалыг эс тооцвол арьс шир, ноос ноолуурын дийлэнх буюу 90 гаруй хувийг урагшаа, бүр нарийн ярьвал БНХАУ-ын Хэбэй мужид нийлүүлж байна. Хэбэй манай түүхий

эдийн төвлөрсөн бэлтгэл бааз байж, дараагийн шатны хувиарлагчийн үүрэгтэй бэлтгэл муж болон “төрийн бодлого”-оор дэмжигдэж байна.

Харин дээр өгүүлсэнчлэн Хятадын эдийн засгийн хөгжил хэт эсрэгээрээ эргэвэл бас аюултай ч зарим зүйлд ашигтай байхыг үгүйсгэмгүй.

МОНГОЛ УЛС:

Монгол Улсын байр суурь хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

Хэдхэн жилийн өмнө Монгол Улс ЗХУ, БНХАУ-ын дундын улс мэт, улс төр эдийн засгийн асуудал нь ЭЗХТЗ-ийн хүрээнд ЗХУ, Зүүн европтой холбогдсон байлаа.

Тэгвэл өнөөдөр Монгол Улс “хоёр хөршийн найрсаг ханлцааны хүрээ”-нээс халин гарч дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх оронтой чөлөөтэй харилцах, Азийн орны статусаа эргээн сэргээх бололцоотой болоод байна. Ардчилал өрнөсөн богинохон хугацаанд манай орон дэлхийн нөлөөтэй орон АНУ, Япон, Өмнөд Солонгос, БНХАУ болон Ази-номхон далайн бусад оронтой хэвийн харилцаатай боллоо. Монгол Улс ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэж, Монгол Улсын шилжилтийн үеийг туулахад туслах зорилготой донор орнуудын хамтлагыг бий болголоо. Гэвч энэ нь хэр удаан үргэлжлэх эсэх нь чухал зүйл.

Манай орны гадаад харилцаанд гарч буй шинэ зүйл бол АНУ, Япон зэрэг Ази номхон далайд төдийгүй дэлхийд нөлөөлөх орнууд тодорхой үүрэг гүйцэтгэх болсон явдал юм. Үүний үндсэн шалтгаан нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиндаа тусгаж, баталгааг хангах механизмыг бүрдүүлж эхэлсэн явдал юм.

Энэ ч үндсэн дээр донор орнууд хоёр хөршид маань ардчилсан тогтолцоонд шилжсэн орон хэрхэн хөгжидөг болохыг жишээ болгон үзүүлэхийг зорьсон бололтой. Гэвч үнэн чанартаа АНУ Монголыг сонирхон алдан, сонирхон алдан байнд ч биш, банзанд ч биш гэдэг шиг, авч ч болохгүй, хаяж ч болохгүй тууштай бус бодлого явуулж, өрнөдийнхөн болон бусад холбоотноо хамруулан татаад байгаагийн гол гогцоо нь ОХУ-БНХАУ хоёрын хэт ойртолтыг сэргэмжлэх зорилгын үүднээс л хийгдэж буй ажиллагаа гэж ойлговол зохино. Гэсэн хэдий боловч уг “цус ойртолтыг сэргэмжлэх” стратегийг санаачлагчид одоохондоо төрийн эрхээ гардан авч чаддаггүй, эрх баригчдаа итгүүлэн бодлого болгон боловсруулж амжаагүй л яваатай холбоотой болов уу. Бас бус хүчин зүйл хүйсийн хэв маяг, мэдрэмж ч нөлөөлдөгийг үгүйсгэх аргагүй. Харин нэгэнт төсөөлөгдчихсөн энэ бодлогыг өргөжүүлэх, өөрийн ашиг сонирхлоо түүнд уялдуулан шургуулж, хэрэгжүүлэх бололцоог хангахад өөрийн гадаад бодлогынхоо нэг том дэд хэсэг болгон авхаалжтай ажиллаж чадах эсэх нь манай төр засаг, үндсэндээ ГХЯ-ны том шалгуур байх ёстой. Гэхдээ ийн ажиллах завсартаа тэрхүү гүрнүүдийн эдийн засгийн том ашиг сонирхолыг нутаг дэвсгэртээ зохиомлоор ч атугай бий болгох ёстой. Энэ нь бат бэх суурь дэвсгэр болж, хөөргөн хөгжингүй орны харцыг татахад нөлөөлж магадгүй болов уу. Түүнээс биш Монгол Улс энэ бүс нутагт өөрийн хүндтэй байраа эзэлтэл нилээн зай бий.

Мөн Японы хувьд Азийн орон манай орныг сонирхох газар зүйн шалтгаан бас бий.

Эдгээр зүйлээс шалтгаалан манай гадаад харилцаа Япон, АНУ-аас хамааралтай болох төлөвтэй байна. Гэвч нөлөө нь есөж буй БНХАУ-ын

АНУ-тай харилцах харилцаанаас мөн адил хамаардаг болох төлөв ажиглагдаж эхлээд байгаа. Энэ нь умард, өмнөд хөршийн баланс алдагдаж өмнөд хөршөөс үзүүлэх нөлөө, ашиг сонирхол улам нэмэгдэх байдалтай холбоотой. Түүнчлэн манай засаг төрөөс гадаадтай харилцах бүхий л цонхоо сүүлийн арван жил Бээжинд төвлөрүүлэн түүгээр дамжуулан шийдвэрлэдэг болоод байгаа нь үүнд нөлөөлөх суурь болж байж болох юм. Хэдийгээр үүнд газар зүйн байрлал шууд хамааралтай ч зарим тохиолдолд бас бус хүчин /агаарын тээвэр, транзит тээвэр, нутаг дэвсгэр түрээслэх, энхийг сахиулах хүчин байрлуулах/ зүйл, эдийн засгийн чадавхиа золиослон байж илүү үр дүнтэй харилцаа, хамаарлыг бий болгодог шүү дээ.

Түүнчлэн Ази-Номхон далайн тэр дундаа Зүүн ази манай гадаад харилцаанд тэргүүлэх нөлөөтэй гэж үзэж байна. Энд дэлхийн АНУ, Япон, ОХУ, Хятад гэх мэт томоохон гүрнүүдийн ашиг сонирхол төвлөрч байдаг, тэгээд ч Монгол Улс тэдний ашиг сонирхолын хүрээнд багтаж байгаа юм.

Иймд энэ бүс нутагт олж авсан байр сууриа бататгах хэрэгтэй.

Монгол Улсын цаашид баримтлах зарчим:

Юуны өмнө далайд гарцгүй Монгол орон дэлхийн улс төр, зах зээлийн харилцаанд татагдан оролцохдоо чухам аль бүс нутгаар дамжин орох вэ? гэсэн асуудал хурцаар тавигдаж байгаа. Үүнд Ази-Номхон далайн бүс, Зүүн хойд ази /Япон, Солонгос, ОХУ/ хамгийн ирээдүйтэй болох нь тодорхой боллоо.

Газар зүйн хувьд ойр дөт, далайд түүгээр л дамжих төдийгүй, улсын цаашдын хөгжилтөнд эдгээр орнууд

шаардлагатай капитал, техник технологийн эх үүсвэрийг нийлүүлэх, ашиглах боломж бүрдэж байгаад анхаарах хэрэгтэй.

Хамгийн гол нь энэ түншлэлээс Монголын түүхий эд голлосон экспортын бүтцийг өөрчлөхөд Япон, Солонгосын хамтын ажиллагаа нэн шаардлагатай. Энэ бүхэн нь тухайн бүс нутгийн эдийн засгийн нягт хамтын ажиллагаанаас шууд хамааралтай болоод байна.

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААН ДАХЬ МОНГОЛ УЛС

Монгол Улсын олон улсын харилцаанд хөгжлийн онол, бодлогыг хэрэгжүүлэх ерөнхий томъёолол

Монгол оронд үйлдвэрлэлийн уналт үргэлжилж, үндэсний валютын ханш нэн доогуур байгаагаас нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр хэмжихэд хөгжлийн төвшингөөр өмнөдийн буурай хөгжилтэй орнууд, төр байтугай зарим үзүүлэлтүүдээр нэн буурай орны тоонд орж байна.

Энэ байдлаас хэрхэн гаргахад хөгжлийн стратеги, үзэл баримтлал боловсруулж, хэрэгжүүлэх нь өнөө цаг үеийн нэн чухал зорилт болоод байна. Гэхдээ Монгол Улс өөрийн хүлээх хариуцлагыг тод ухамсарлаж үүнийгээ хэрэгжүүлэх ёстой. Энэ зарчим нь хөгжилд дөхөм үзүүлэх ерөнхий нөхцлийг бүрдүүлэхэд оршино. Улс орны өөрийн чармайлтаг хандивлагч орнууд орлож чадахгүй, тэгэх ч үгүй.

Хөгжингүй умардын орнуудын Засгийн газар эдийн засгийн хувьд бүтээх чадвартай социал байдлын хувьд тэгш нийгмийн байгууллыг эрмэлзэж буй орнуудын бодлогыг илүү дэмжиж байдаг. Хэрэв ямар нэгэн хөгжиж буй орон хүний хувийн санаачлагыг дарангуйлж байх юм бол

жишээ нь мэдээлэл чөлөөтэй олж авах эрхийг хязгаарлаж байхад гаднаас үзүүлэх тусламж үр нөлөө үзүүлж чадахгүй гэж хөгжингүй орнууд үзэж шалгуур тавьдаг.

Ер нь зах зээлийн эдийн засагт тууштай шилжиж чадахгүй, хуучинтайгаа зууралдаж, хүний эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулж чадахгүй орнууд хөгжлийн тусламжинд найдах хэрэггүй. Тэгэх нь илүүц зүйл бизээ.

Хөгжиж буй орнуудад хамгийн чухал алхам бол ядууралтай тэмцэх, хоол хүнсний эрүүлжүүлэх, хөдөө нутгийн хөгжүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, боловсрол сургалтын асуудлыг сайжруулахад гол бодлогоо тусгадаг. Өөрөөр хэлбэл хөгжлийн тусламжийг хэр зөв шингээж байгаагаас их зүйл хамаардаг билээ.

Өнөөдөр үзэл бодлын зөрчилдөөн, Өрнө, Дорнын маргалдаан конфликт шувтарч, Монгол орон ийм нээлттэй орчинд хөл алдахгүйн тулд үндэсний хөгжлийн цэгцтэй үзэл баримтлал, бодлого үгүйлэгдэж байна.

Иймд хөгжлийн асуудлыг өнөөдрийн тогтолцооны трансформацийн /шилжилт/ асуудалтай уялдуулж үзэл баримтлал, бодлого боловсруулахын чухалыг онцлон тэмдэглэмээр байна. Мөн хуучин социалист системд мөн адил трансформацийн үйл явц явагдаж байсан, одоо ч дуусаагүй байна.

Тэгэхдээ энэ шилжилт хэр өгөөжтэйг дараах байдлаар шалгадаг:

- цаг хугацааны хүчин зүйлс
- зардлын хүчин зүйлс;
- хүлээн зөвшөөрөх байдал – актентаци;
- практик чадвар эдгээр болно.

Цаг хугацааны хүчин зүйл нь шилжилтийн үйл явцад шаардагдах цаг хугацааны хэрэгцээ, үйл явцын

үргэлжлэх хугацаа билээ. Монголын хувьд стратегийн бодлого, үзэл баримтлалаас шалтгаалан нилээд удаан явагдах төлөв ажиглагдаж байна.

Шилжилтийн зардлыг тодорхойлох нь нилээд төвөгтэй. Хуучин тогтолцооны үр ашиггүй байдлыг зайлуулахтай холбогдсон зардал энд хамаарахгүй. Ийм зардал хангамжийн дутагдал, бүтээгдэхүүний чанар, экологийн бохирдлоор ихэсдэг. Хуучин тогтолцооны үргүй зардлыг зайлуулах нь системийн трансформацийн зорилго байх ёстой. Энэ утгаараа ч М.Энхсайханы Засгийн газрын явуулж байсан бодлого зөв алхам эхлүүлсэн. Харамсалтай нь эхэлсэн зөв алхам, бодлого үйл ажиллагааг бүрдүүлэхэд шаардагдсанаас илүү зардалыг дараа дараагийнх нь тодорхой бус засаглал, ямар ч баримтлах бодлого зорилтгүй Засгийн газрууд балласан билээ. Харин одоогийн Н.Энхбаярын Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй алхамууд нь хэдийгээр зөв боловсрогдсон боловч сонгуулийн амлалтад баригдан, дараагийн алхамдаа тушаа болохоос эмзэг мэргэжлийн удирдлагаар хангаж, чигч ажиллах явдал дутагдалтай байгаа нь ажиглагдаж байна.

Шилжилтийн зардал нь трансформацийн бодлогоос шалтгаалсан байх ёстой. Энэ нь шилжилтийн үеийн бодлогоос үүдэн гардаг. Өөрөөр өмч хувьчлал, техник технологийн зардал, бүтцийн шинэ тогтолцоо бий болгох гэх мэтчилэн...

Эцэст нь хүлээн зөвшөөрөх байдал буюу актентацийн шалгуур нь системийн өөрчлөлтийг хүн ам хэрхэн зөвшөөрч, санал нийлж байгаагаар холбоотой юм. Гэхдээ энэ харьцаа зөвшөөрсөн, няцаасан харьцаагаар тодорхойлогддог.

Иймд энэ харьцааг нэмэгдүүлэх нь улс төрийн удирдлагад итгэх итгэл буюу төрийн тогтвортой ажиллагаа,

хувь хүнд учирсан байдал, хуучин тогтолцоогоо санагалзсан байдал, түүнийг санагалзах, улс төрийн боловсрол, ирээдүйгээ хэрхэн төсөөлж байгаагаас шалтгаална. (Үүнийг хэлэхэд шар, хар, цагаан байх нь гол бүс хамгийн гол нь тогтвортой засаглал энүүхэн 10 жилд шаардлагатай байгаа. Үүнээс үндэслэн засаглалын тэнцвэржилт, бүтцийн асуудлыг ч эргэн харах. Үндсэн хуулиар эрх мэдлийн хувиарлигдсан байдалд ч бодолцох зүйл нилээн бий. Учир нь зарим нэгэн мэриймтгий зүтгэлтний хэт зүтгэл, илэрхийлэлтээс шалтгаалан анхдагч логик алдагдсан тэрхүү тодорхой бүс үялдаа холбоосыг залруулах зайлшгүй шаардлага байна.)

Практик чадвар гэдэг нь шилжилтийн тодорхой үзэл баримтлалыг бодлого болгон хэрэгжүүлэх байдал, тухайлбал бодлогын тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх, техникийн талаар хэрэгжүүлэх явдлыг ойлгодог. Эдгээр шалгуурыг оновчтой ашиглан шилжилтийн бодлогыг хянаж байвал бас трансформацийн үйл явцын

амжилтад эерэг нөлөөлөх бололцоотой.

Дээр ерөнхий тулгуур шалгууруудыг шилжилтийн үедээ байгаа хөгжиж буй орнууд дотооддоо хэрхэн хэрэгжүүлж буйгаас хамаарч тухайн улс орны гадаад бодлого, хөгжлийнх нь стратеги, үзэл баримтлал төлөвшин тогтож, цаашилбал олон улсын харилцааны төвшинд тухайн бүс нутагтаа өөрийн байр суурийг тогтооход чухал түлхэц болдог байна.

Ийм тохиолдолд Монгол Улсын үндэсний хөгжлийн цэгцтэй бодлого, үзэл баримтлал бүрэлдэх таатай нөхцөл боломж олгогдох болно.

Эцэст нь хэлэхэд энэ бүх зүйлд бичсэн стратеги, үзэл баримтлал, бодлого боловсруулж хэрэгжүүлэх гээд байгаа маань аль нэг дотоод, гадаадын донорын тусламж, санхүүжилтээр төслийн мөнгө аваад хэн нэг, хэсэг бүлэг хүмүүсээр хийлгэх цаасан баримт бичиг, дугуй ширээний ярилцлага, семинар, улс төрийн болоод урлаг соёлын шоуг хэлээгүйг ойлгон хүлээн авна биз ээ.

* * *

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэргийн оролцогч

17 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадвар

17.1.Захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэхэд иргэн, хуулийн этгээд оролцох эрхтэй.

17.2.Хуулийн этгээдийн эрхгүй боловч тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай холбоо, сан зэрэг нэгтгэлийг шүүгч захирамж гаргаж уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж болно.

* * *

АВЛИГЫН ЭСРЭГ: ТЭМЦЭЛ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны
секторын эрхлэгч, доктор Д.Зүмбэрэлхам

Сингапурын Үндэсний Их сургуулийн профессор ноён Жон Куа 1998 онд манай оронд ажиллаад авлигын нөхцөл байдлын талаар бичсэн илтгэлийнхээ дүгнэлтийн хэсэгт “Авлигын асуудал улс болгонд байдаг боловч Нигер улсад энэ асуудлыг шийдвэрлэхэд нэн төвөгтэй байдалд ороод байгаа юм. Засгийн газар нь буруутай этгээдийн асуудлыг мөрдөж, шүүх нь хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа юм. Засгийн газрын байгууллагууд бизнес төв болон хувирч тэнд авлига ид цэцэглэж байна. Улс төрчид, төрийн албан хаагчид, цэргийнхэн, бизнесийн хүрээнийхэн, нийгэм нь бүхэлдээ авлигад автсан. Хүн болгон авлига өгч, авч энэ нь тус улсын өдөр тутмын амьдралын энгийн зүйл болоод байна. Нигерчүүд авлигыг ингээд ердийн зүйл гэж үзэх болсон нөхцөлд авлигатай тэмцэх оролдлого амжилтанд хүрэхгүй юм. Монгол Улсад авлига нь Нигер улсын дэргэд хараахан газар аваагүй байна. Цаашид Нигер улсын замаар орох эсэх нь тус орны улс төрийн лидерүүд, хүн ам авлигын эсрэг тэмцэх үүрэг хариуцлагаа хэрхэн ухамсарлахаас хамаарна. Хэрэв улс төрийн ийм хүсэл эрмэлзэл байхгүй бол цаашид авлига нь ирээдүйд Монголын амьдралын хэв загвар болох явдалаас урьдчилан сэргийлэх аргагүй болно” гэжээ. Энд нэг талаас Монголд авлига хэт газар аваагүй гэж хэлсэн мэт боловч манай улсыг авлигаа дийлэхээ больсон Нигертэй харьцуулсан нь тохиолдлын хэрэг биш гэлтэй.

Олон улсын практикаас үзвэл авлигатай хийх тэмцлийг үр дүнтэй, иж бүрэн явуулна гэвэл зохион байгуулалт, хууль эрх зүйн

зохицуулалт, олон нийтийн дэмжлэг авах гэсэн гурван чиглэлээр зэрэг ажиллах шаардлага тавигддаг байна. Үүнийг зарим судлаачид авлигатай тэмцэх гурван фронт ч гэж нэрлэх нь бий бөгөөд эдгээрийн аль нэг чиглэлд нь дутуу анхаарвал тэр нь тэмцлийг доголдуулж, улмаар нийт үр дүнг нь саармагжуулах нөхцөл болдог ажээ:

Авлигын эсрэг арга хэмжээ авч ирсэн байдлыг дээрх шалгуураар авч үзвэл 1996 онд Авлигын эсрэг хуулийг батлаж гаргасан нь эрх зүйн тухайн үзэгдэлтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн нааштай алхам болсон хэдий ч энэ хуулиар арга хэмжээ авагдах буюу ял шийтгэгдсэн хүн өнгөрсөн жилүүдэд огт бүртгэгдээгүйгээр түүний практик ач холбогдол үгүйсгэгдэж байгаа юм. Олон нийтийн дунд явуулах соён гэгээрүүлэх ажлын тухайд энэ талын ухуулга сурталчилгаа мэдэргэдэхүйц хэмжээнд явагдаагүйг хүн бүр хэлнэ. Төрөөс авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээг авчихсан гэж харагдаж үзэгдэх зүйлгүй байгаа нь мөн л нийтэд тодорхой байна. Үүнээс үзвэл авлигатай тэмцэлд үндсэн фронтуудын алинд нь ч манай улсын хувьд дорвитой, даацтай, нийгэмд нөлөөлөхүйц үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулж чадаагүй гэсэн дүгнэлт хийж болохоор байгаа юм.

Авлигатай тэмцэхийн тулд хамгийн эхэнд шийдвэрлэвэл зохих асуудал нь түүнтэй холбоотой эрх зүйн зөрчлүүдийг оновчтой тодорхойлох явдал билээ. Яагаад гэвэл бид ямар үзэгдэлтэй тэмцэх гэж байгаагаа зөв, бүрэн тодорхойлолгүйгээр түүний

эсрэг үйл ажиллагаа явуулж үр дүнд хүргэнэ гэдэг мэдээжийн санашгүй зүйл. Энд юуны өмнө авлигатай холбоотой нэр томъёоны асуудлууд дээр тогтож үзүүштэй зүйл нилээд байгаа мэт санагдана. Энэ нь зөвхөн үгийн сонголтын асуудал биш бөгөөд тэдгээрт агуулагдаж байгаа эрх зүйн ойлголтуудын тухай яригдаж байгаад гол учир нь байгаа юм.

1996 онд Авлигын эсрэг хууль гарах хүртэл “авлига” гэдэг үг манай эрх зүйн нэр томъёоны санд байгаагүй ба Эрүүгийн хуульд байсан, одоо ч өөрчлөгдөөгүй байгаа “хээл хахууль” гэдэг нэр томъёогоор одоогийн авлигад хамааруулан үздэг эрх зүйн зөрчлүүдийг илэрхийлж хээл хахууль өгөх, авах, зуучлах гэсэн хэлбэрүүдийг дотор нь багтааж ирсэн билээ. Гэтэл Авлигын эсрэг хуульд шинээр тусгагдаад зогсоогүй шууд л тухайн хуулийнхаа гарчиг болж дэвшсэн “Авлига” гэдэг нэр томъёонд “...хээл хахууль авах, хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, боломжоо ашиглах, нийнхүү ашиглуулахаар түүнд шан харамж буюу хөнгөлөлт, давуу талыг хувь хүн, хуулийн этгээдээс олгох явдлыг ойлгоно” гэжээ. Эндээс үзвэл “авлига” нь дотроо:

- хээл хахууль өгөх,
- хээл хахууль авах,
- хувьдаа материаллаг ашиг хонжоо олох,
- хувьдаа бусад ашиг хонжоо олох,
- шан харамж авах,
- давуу тал олгох,
- хөнгөлт үзүүлэх зэрэг олон хэлбэрийг агуулдаг аж.

Хээл хахуультай холбоотой нийгмийн үзэгдлийг нийтэд нь “corruption” гэдэг ерөнхий нэр томъёогоор илэрхийлдэг олон улсын жишгээр бол манайд энэ үгний монгол хувилбар болж “авлига” гэдэг үг эрх зүйн нэр томъёоны санд шинээр орж ирсэн нь

тохиолдол биш бөгөөд харин ч үгийн сонголт зөв хийгдсэн гэж хуульчид үздэг юм билээ. Харин уг ойлголтод багтах эрх зүйн зөрчлүүдийн хэлбэрүүдийг Авлигын эсрэг хуульд тусгасан жагсаалт нь бүрэн гарсан уу, ойлгомжтой, оновчтой болж чадсан уу гэвэл энэ талаар багагүй маргаантай байдаг.

Энэ талын ойлголтыг өөрийнхөө орны хууль тогтоомжид тусгагдсан, гадаадын зарим орон, олон улсын баримт бичгүүдэд тусгагдсанаар харьцуулж үзэхэд авлига, хээл хахууль, шан харамж гэсэн үндсэн гурван ойлголт байдаг гэсэн дүгнэлтэд хүрэхээр байгаа юм. Авлига нь хэдийгээр хээл хахууль авах талын утга агуулга боловч энэ талын нийгмийн үзэгдлүүдийг бүхэлд нь төлөөлнө. Хээл хахууль нь хэдийгээр өгөх талын агуулгатай боловч түүнийг өгөх, авах, зуучлах гэсэн үйлдлүүдийг аль алиныг нь илэрхийлэх боломжтой. Шан харамж гэдэг нь аливаа үйлдэл, эс үйлдлийг хууль ёсоор, албан үүргийнхээ дагуу хийсний нь төлөө албан бус шагналын хэлбэрээр өгөгддөг зүйл юм.

Авлигын эдгээр ойлголтод багтах үйлдэл ба эс үйлдэл нь материаллаг ба материаллаг бус ашиг хонжоо олох гэсэн үндсэн хоёр хэлбэртэй. Одоогоор Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заагдсан авлигын төрлүүд нь шинж чанараараа эл хоёр үндсэн хэлбэрүүдэд хуваагдах бөгөөд ер авлигын байж болох бүх төрөл, хувилбаруудыг хуульд тоочиж бүрэн тусгах боломжгүй билээ. Иймд авлигын тухай ойлголтыг Авлигын эсрэг шинэ хуульд тодорхойлохдоо энэ мэт асуудлуудыг анхаарч үзүүштэй санагдана.

Албан үүргийнхээ дагуу аливаа эрх олгогдсон этгээд бусдаас хээл хахууль авсныхаа төлөө өөртөө хувийн материаллаг болон

материаллаг бус ашиг хонжоо олох үүднээс тэрхүү боломжоо урвуулан ашигласан үйлдэл ба эс үйлдэл, мөн албан үүргээ биелүүснийхээ төлөө хууль бус шан харамж авах, иргэд, хуулийн этгээдийн зүгээс энд дурдсан үйлдэл ба эс үйлдлийг хийлгэх гэж хээл хахууль, шан харамж өгөх явдлыг бүхэлд нь авлига гэж тодорхойлбол илүү цэгцтэй болмоор байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо хүчин төгөлдөр байгаа Авлигын эсрэг хуульд тусгагдсан шиг төрийн албан тушаалтнаар зөвхөн хязгаарлагдахгүй жирийн иргэд болон төрийн, хувийн секторын ажилтнууд бүгд авлигын субъект байж болно гэж үзэж байна. Ингэж үзэх болсон шалтгаан нь авлига гэдэг нийгмийн үзэгдлийн өөрийнх нь мөн чанартай холбоотой. Авлигыг зөвхөн төрийн албан тушаалтны хүрээнд ойлговол түүний эсрэг явуулах бидний тэмцэл зөвхөн энэ явцуу хүрээнд хязгаарлагдана гэсэн үг юм.

Эрх зүйн зохицуулалттай холбоотой өөр нэг асуудал бол авлигын хэргийг илрүүлэх, нотлоход дөхөм үзүүлэх үүднээс зарим заалтыг холбогдох хуулиудад оруулах явдал юм. Авлигын хэрэг нь ихэвчлэн цөөн хүний хүрээнд, гэрч баримт багатай үйлдэгддэг, авлига өгсөн, авсан талууд аль аль нь хөзрөө дэлгэх сонирхолгүй байдаг зэргээс үүдээд түүний илрүүлэлтэд хүндрэл учирдаг, шүүхэд бусад эрүүгийн хэргийн жишгээр нотлоход хүндрэлтэй байдаг, эдгээрээс болоод авлигач, хахуульч этгээдүүдэд ял завших бололцоо гардаг нь энэ талаар явуулж байгаа тэмцэлд бодитой саад учруулдаг билээ. Үүнтэй холбоотойгоор авлигын үйлдлүүд нотлогдвол санаа зорилго нь нотлогдсон гэж үзэж гэм буруутайд тооцох, албан ёсны орлогоос хэт давсан хөрөнгийнхөө эх сурвалжийг тайлбарлах үүргийг иргэдэд ногдуулах, өндөр албан тушаалын этгээдийг баривчлах, байцаахад шат дамжлага

багатай чирэгдэлгүй журам тогтоох зэрэг заалтуудыг холбогдох хуулиудад тусгах шаардлага тавигдана. Ингэснээр ардчилал ба хүний эрхийн асуудалд ямар нэгэн хохирол учрана гэж бодохгүй байна. Яагаад гэвэл энэ бол мөн л авлигатай эрчимтэй тэмцдэг ардчилсан, хөгжилтэй орнуудын туршлага юм.

Зохион байгуулалтын хувьд хоёр л сонголт бий. Нэг нь одоо байгаа хуулийн байгууллагуудын бүтцээрээ Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх, нөгөө нь хараат бус агентлагийг шинээр тусгайлан байгуулж дээрх чиг үүргийг түүнд дагнан хариуцуулах хувилбарууд байгаа юм. Эхний сонголтын хувьд бид Авлигын эсрэг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 4 жилийн хугацаанд энэ хуулийн хэрэгжилтийг ямар байгууллага хариуцаж, аль хэмжээний үр дүнд хүрэв гэдгийг эргээд харахад л хангалттай. Хэдийгээр социологийн судалгаанд үндэслэн зарим байгууллага авлигад идэгдсэн гэж хэлж болох боловч бидэнд энэ талын албан ёсны статистикийн баримт бага болохоор манай хууль хэрэгжүүлэх байгууллагууд бүгдээрээ авлигад хүлэгдээд хөдөлж чадахаа больсон гэж хэлэх боломжгүй. Гэхдээ эдгээр байгууллага ямар нэгэн байдлаар авлигын эсрэг тэмцэлд уриалгахан биш хандаж байгааг Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийн байдал бидэнд бэлэхэн харуулж байна. Бид гэмт хэрэгтэй тэмцэх ердийн бүтцээрээ ажиллалал цаашид энэ мэт үр дүн багатай байх төлөв ажиглагдаж байгаа юм.

Хоёр дахь хувилбарын тухайд бол бид энэ замаар замнаж үр дүнд хүрсэн бусдын туршлагыг харах хэрэгтэй болно. Энэ талаар бидэнд газар нутгийн хувьд хамгийн ойр нь Сингапур, Хонг-Конг улсуудын туршлага байгаа юм. Транспэренси Интернэйшнлээс жил бүр гаргадаг судалгааны дүнгээр Азийн орнууд

дундаас зөвхөн эдгээр хоёр орон л олон улсын хэмжээнд авлига хамгийн багатай эхний 15 орны тоонд багтаж байдаг. Эдгээр улсад авлигын эсрэг тэмцэл харьцангуй богино хугацаанд эсрэг үр дүнд хүрсэн шалтгаан нь төстэй бөгөөд хоёуланг нь авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх дагнасан чиг үүрэгтэй хараат бус байгууллага байгуулагдсан явдал уг амжилтын үндэс болсон гэж олон улсын шинжээчид үздэг байна. Ийм байгууллага байгуулагдах болсон шалтгаан нь ч мөн ижлэвтэр байдаг. Тухайлбал Сингапурт 1951 онд цагдаагийнхан нь хар тамхины хэрэгт орооцолдсон дуулиант хэргийн дараа Авлигын хэргийг мөрдөн байцаах товчоо гэдэг хараат бус байгууллага байгуулагдсан байхад Хонг-Конгод Авлигын эсрэг хараат бус комисс гэдэг байгууллага байгуулагдсан түүх мөн энэ улсын цагдаагийн байгууллага тухайн үзэгдэлтэй шийдвэртэй тэмцэл явуулж чадаагүйтэй холбоотой байсан гэж мэргэжилтнүүд тайлбарласан байдаг.

Бодитой үр дүнд хүрсэн эдгээр улсуудын туршлагыг манай улсын хувьд авч хэрэглэх нь бидний авлигын эсрэг тэмцлийг амжилтад хүргэх гол арга зам байж мэднэ. Эдгээр загвар нь зөвхөн манай улсын ч биш авлигын асуудал глобал болж байгаа өнөө үед дэлхийн олон орны сонирхлыг татаж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

Хонг-Конгийн Авлигын эсрэг хараат бус комисс нь дотроо Олон нийттэй харилцах газар, Авлигаас урьдчилан сэргийлэх газар, Мөрдөн байцаах газар гэсэн тус тусдаа өөр өөр чиг үүрэгтэй 3 газраас бүрддэг байна. Олон нийттэй харилцах газар бол нийгмийн гишүүдтэй нягт холбоотой байж авлигыг үзэн яддаг, тэсвэрлэдэггүй үзлийг нийгмийн сэтгэхүй, ёс заншлын хэмжээнд хүргэх зорилтыг өмнөө тавьдаг. Мөн олон нийтийг авлигын эсрэг зохион

байгуулалттай үйл ажиллагаа явуулах, хөдөлгөөн өрнүүлэхэд нь туслаж урамшуулахад ажлаа чиглүүлдэг байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх газар нь төрийн болон хувийн секторт авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Ингэхдээ тэдний үйл ажиллагааг хүнд сурталгүй, шат дамжлага багатай явуулах, үүнд зохицсон чирэгдэл багатай бүтэцтэй байж чадаж байгаа эсэхийг хянах үүргийг бас хүлээдэг. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны чирэгдэл, бүтцийн доголдол хоёрыг хоёуланг нь хянадаг гэсэн үг. Ингэснээр төрийн болон хувийн секторын аль алинд нь хахууль авах боломжийг багасгахад ажлаа чиглүүлдэг ажээ.

Мөрдөн байцаах газар нь мөрдөн байцаах чиг үүргийг гүйцэтгэдэг. Төрийн болон хувийн секторт хахууль авах явдал адилхан гэмт хэрэг гэж тооцогддог учраас энэ газар эдгээр секторуудыг хариуцсан хоёр хэсэгт хуваагддаг. Мөрдөн байцаах газар эхлээд иргэдийн гомдлын мөрөөр ажиллах хэлбэрийг хэрэглэж байсан бол одоо өөрийн санаачлагаар мэдээ цуглуулах үйл ажиллагааны идэвхтэй хэлбэрийг ашиглаж байна. Авлигын хэргийн талаар мэдээлэл авах мэдээллийн сайн сүлжээтэй болж чадсан. Мөн энэ газар хөнгөн гэмт хэрэгт өөрөө анхааруулга өгөх, арга хэмжээ авах эрхтэй. Энэ нь зардал багатай бөгөөд цаад хүндээ нөлөөлөх талаар илүү үр дүнтэй сайн арга хэмжээ гэж үздэг. Харин томоохон хэргүүдийг цааш нь эрүүгийн хэрэг болгож шийтгүүлэхийн тулд прокурорт шилжүүлдэг юм байна.

Манайд ч гэсэн ийм хараат бус дагнасан байгууллага байгуулахад улс орны онцлогоос шалтгаалан харшлах зүйл төдийлөн ажиглагдахгүй байна. Харин энэ байгууллагыг хаанаас байгуулж, томилгоо хийж, ажлыг нь

МАНСУУРУУЛАХ БОДИС БА ХУУЛЬ БУС АЖИЛЛАГАА

Монгол Улсаас БНКаЗУлсад суугаа ЭСЯ-ны нэгдүгээр
нарийн бичгийн дарга, доктор О.Пунцагдаш

Орчин үед мансууруулах бодис, түүнийг хэрэглэгчид аливаа улс гүрэн, нийгэмд терроризм, экстремизмээс дутуугүй аюул занал учруулах болсон нь мансууруулах бодисын наймаа асар их хор уршиг бүхий сөрөг үр дагавартай байдагтай шууд холбоотой юм. Мансууруулах бодисын тархалт, хэрэглээ нь:

- Хүн амын эрүүл мэндийн байдал, удмын санд,
- Улс гүрнүүдийн эдийн засагт,
- Хэв журам, нийгмийн сэтгэл зүйд,
- Аливаа улс гүрний үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, шууд занал хийлдэг байна.

Мансууруулах бодисын наймаатай хийх тэмцэл маш их төвөгтэй учраас түүнийг үндсээр нь устгахад туйлын хэцүү, бараг боломжгүй юм. Энэ нь орчин үед мансууруулах бодис хэрэглэгчид улам олширч, наймаачид асар их орлого олж байгаатай шууд холбоотой.

Оксфордын их сургууль, НҮБ-ын захиалгаар мансууруулах бодисын дэлхийн зах зээлийн хууль бус борлуулалтын талаар томоохон хэмжээний судалгаа 1997 онд хийжээ. Тус сургууль дэлхийн зарим улс гүрэн, НҮБ, Интерпол, Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллага, тэдгээрийн бүс нутгийн төлөөлөгчийн газар, байгууллагуудын судалгааны төв, хороо, комиссын олон тооны илтгэлийг үндэслэн дүгнэлт гаргасан байна. Ингэснээр дэлхийн хэмжээнд 200 сая гаруй хүн /энэ бол зөвхөн албан

ёсоор бүртгэгдсэн мансууруулах бодис хэрэглэгчид/ мансууруулах бодис байнга хэрэглэж байгаа нь тогтоогджээ. Мөн дэлхийн зах зээл дэх мансууруулах бодисын худалдааны эргэлт 1994 оны байдлаар төмөр, зэс, автомашиныхаас аль хэдийн давсан бөгөөд эрүүгийн бүлэглэлүүдийн мэдэлд байгаа санхүүгийн эх үүсвэрийн 70 хувь нь тэдгээрийн хууль бус наймааны орлогоос буй болдог гэсэн дүгнэлт гарчээ. Энэ асар их орлого нь мансууруулах бодисын наймаачдыг дэлхийн хууль бус бизнест зонхилох байр суурь эзлэхэд хүргэж байна.

Мансууруулах бодисын наймаа 75 хувийн ашигтай байдаг аж. Өөрөөр хэлбэл мансууруулах бодисын 75 хувь нь борлуулалтаас хасагдаж, устгагдсан нөхцөлд л уг наймаа ашиггүй болдог байна. Тэгвэл дэлхийн тусгай албад мансууруулах бодисын наймааны 10 хувьтай тэнцэх хэсгийг л илрүүлдэг байна. Энэхүү байдал нь мансууруулах бодисын наймаачид жилд дунджаар 50 тэрбум доллар /энэ нь НҮБ-ын гишүүн улсуудын гуравны хоёрын үндэсний бүх орлогын хэмжээтэй тэнцэж байгаа гэсэн үг/-ын ашигтай байх боломж олгодог бөгөөд эл орлогын ихэнх нь терроризм, шашны экстремизмийг санхүүжүүлэхэд зарцуулагддаг нь нууц биш болжээ.

Орчин үед дэлхийд мансууруулах бодис их хэмжээгээр үйлдвэрлэдэг бус нутагт Өмнөд Америкийн зарим улс, Зүүн Өмнөд Азийн Мьяма, Тайланд, Лаос, Афганистан, Пакистан тус тус хамрагддаг байна. Мансууруулах бодисын найрлага бүхий ургамалыг

тарьж боловсруулах, худалдаалах нь эдгээр бүс нутгийн хүн амын амьжиргааны орлогын гол эх үүсвэр болдог байна.

Иймээс ч улам бүр нарийн зохион байгуулалтад орж, дэлхийн зах зээлд нэвтэрч байгаа мансууруулах бодисын наймаачидтай тэмцэх явдал дэлхий нийтийн орчин үеийн тулгамдсан асуудлын нэг боллоо.

Өнөө үед дэлхийн бараг бүх улсад мансууруулах бодисын эсрэг тэмцлийн арга хэлбэрээр нь дэлхийн улс гүрнүүдийг үндсэн 3 бүлэгт хувааж үздэг.

1. Эхний бүлэг улсуудад Голланд, Бельги, Герман, Португал, Испани, Швейцарь багтдаг. Эдгээр улс “аюулгүй мансууруулах бодис”-ыг тодорхой хэмжээгээр хадгалах, худалдахыг зөвшөөрдөг. Тухайлбал, Голландын парламент иргэддээ боловсруулсан 30 грамм конопли /гашиш и марихуана/-г хадгалахыг албан ёсоор зөвшөөрсөн хууль гаргасан байдаг. Түүнчлэн тусгай зөвшөөрөл бүхий, үйл ажиллагаанд нь зарим хязгаарлалт тогтоосон зоогийн газрууд/кафе/-д эдгээрийг худалдахыг зөвшөөрдөг. Харин нэг хүнд нэг удаа 30 граммаас илүү “бүтээгдэхүүн” зарах, сэтгэцэд хүчтэй нөлөөлөл бүхий мансууруулах бодис худалдах, мансууруулах бодисын зар сурталчилгаа хийх, насанд хүрээгүй хүүхдэд худалдах, мансууруулах бодис худалддаг зоогийн газрууд сургуулиудад 500 метрээс дотогш ойрхон байрлахыг тус тус хориглодог байна.

Харамсалтай нь Европын Холбооны жуулчны агентлагууд, цагдаагийн байгууллагуудын хүлээн зөвшөөрснөөр Голланд дээрх хуулийг мөрдөж эхэлснээс хойш Баруун Европын улсын “мансууруулах бодисын нийслэл” болжээ. Их

Британийн гааль, /акцизное управление/ тус улсад саатуулагдсан героины 80 хувь нь Голландаар дамжуулж тус улсад оруулсан буюу тэнд хадгалагдсан байдаг гэж үздэг. Францын нийслэлд хэрэглэж буй героины 80 хувийг Голландаас оруулж ирсэн байдгийг Парисын цагдаагийн газар тогтоосон байна. Мансууруулах бодисын холбогдолтой хууль тогтоомжоо өөрчлөхийг Голландчууд өөрсдөө ч хүлээн зөвшөөрсөн уур амьсгал олон нийтийн дунд бий болжээ. Энэ нь Дордехт дэх мансууруулах бодис хэрэглэгчдийн нөхөн сэргээх эмчилгээний төвийн захирагч франц Коопманы “Мансууруулах бодисын талаарх манай төрийн бодлого бүрэн дампуурсан боловч уг бодлогыг дэмжигчид өөрсдийгөө зөвтгөсөөр, буруутай үзэл баримтлалаа хянаж үзэхийг хүсэхгүй байна” гэснээс тодорхой байгаа юм.

2. Мансууруулах бодисын наймааны эсрэг хууль тогтоомжийн заалтаа улам чангатгаж байгаа улсуудын бүлэгт Турк, Иран, Энэтхэг, Өмнөд Солонгос, Хятад, Бангладеш, Индонези, Малайзи, Тайланд, Египит, Саудын Араб багтдаг.

Эдгээр улсын зарим нь мансууруулах бодисыг тараагчид, хүүхдүүдийг мансууруулах бодисын хэрэглээнд татан оруулагчдад цаазаар хороох ял ногдуулах заалтыг хууль тогтоомждоо тусгасан байдаг. Тухайлбал, Ираны хууль тогтоомжоор 30 граммаас илүү хэмжээний героин авч яваад саатуулагдсан хүнд цаазлах ял оноодог байна.

БНХАУ мансууруулах бодисын эсрэг төрийн тууштай бодлого явуулж байна. Тус улс 1950 онд зохих хууль тогтоомжийг батлан гаргаж мөрдснөөс хойш мансууруулах бодисын хэмжээ нь өсөөгүй байна. БНХАУ-ын Төрийн Зөвлөл

“Мансууруулах бодис хэрэглэгчдийг албадан эмчлэх журам”-ыг 1995 онд баталжээ. Энэ журмын дагуу мансууруулах бодис хэрэглэгчдийг шүүхийн шийдвэргүйгээр цагдаа болон тэдгээрийг эсэргүүцэх хорооны шийдвэрээр албадан эмчилгээнд эхний удаа 6 сарын хугацаагаар илгээдэг. Энэ курс эмчилгээний дараа засраагүй хүмүүсийг шүүхийн шийдвэрээр засан хүмүүжүүлэх лагерь буюу хорих газарт 3 жилийн хугацаагаар хүргүүлдэг журамтай юм. Зөвхөн Хятадын Өмнөд-баруун хэсгийн Юньнань мужид мансууруулах бодис хэрэглэгчдийг албадан эмчлэх 87 төв, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 8 лагерь ажилладаг.

Түүнчлэн сайн дураараа эмнэлгийн тусламж хүссэн мансууруулах бодис хэрэглэгчдийг төлбөргүйгээр эмчлэх тусгай төвүүд эмнэлгийн байгууллагын харьяанд ажилладаг. Тухайлбал, Нимбо хот дахь профессор Ян Гудуны институтэд 1991-2000 онд 8000 мансууруулах бодис хэрэглэгч сайн дураараа төлбөргүйгээр нэг сарын курс эмчилгээ хийлгэсэн бөгөөд тэдгээрийн 5 дахь эмчлүүлэгч тус бүр нь 2 жил, зарим нь 4-5 жил мансууруулах бодис хэрэглээгүй байна. Хятад улс ийнхүү тууштай бодлого явуулж байгаа боловч түүний зарим эх сурвалжийн мэдээгээр тус улсад өнөөдөр албан ёсоор бүртгэгдсэн 900.000 орчим мансууруулах бодис байнга хэрэглэгч бүртгэгджээ.

Хятадын Дээд шүүх Юньнань, Гуандун мужийн шүүхэд 50 граммаас илүү мансууруулах бодисын хэрэгт холбогдогчдод цаазлах ял ногдуулах шийдвэрийг бие даан гаргах эрхийг 1991 оноос эхлэн олгосон байна. НҮБ-аас зарласан Мансууруулах бодисын эсрэг тэмцлийн өдөр Хятадад мансууруулах бодисын наймааны хэрэгт холбогдсон хэдэн зуун хүнийг жил бүр цаазалдаг болжээ.

3. Гурав дахь бүлэгт хамрагддаг Франц, АНУ, Их Британи өөрсдийн хууль тогтоомжоор мансууруулах бодисын зах зээлийн хууль бус борлуулалтад хатуу хяналт тавьдаг боловч холбогдогчдод ялын дээд хэмжээ оногдуулдаггүй. Эдгээр улс мансууруулах бодисын наймаачидтай тэмцэхэд ихээхэн хөрөнгө зарцуулдаг. Тухайлбал, Франц, Их Британид мансууруулах бодис хэрэглэгчдийг албадан эмчилдэг. Эдгээр улсууд мансууруулах бодисын наймаачдад эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ чиглэлийн хууль тогтоомжоо чангатгаж мансууруулах бодис их хэмжээгээр авч яваад саатуулагдсан этгээдүүдэд бүх насаар нь хорих ял ногдуулах болжээ. АНУ-д 1986 онд гаргасан хуулийн холбогдох заалтын мөнгөн орлогынхоо бодит эх үүсвэрийг нуун дарагдуулсан гүйлгээ хийсэн этгээдэд эрүүгийн хүнд зүйл ангиар ял оногдуулдаг.

Түүнчлэн мансууруулах бодис үйлдвэрлэгч улсууд энэ чиглэлийн үйлдвэрээ өөр зориулалтаар зохион байгуулахад нь эдгээр улс санхүүгийн урамшуулал олгох арга хэмжээг хэрэгжүүлдэг аж. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгчийн Засаг захиргаа 2000 оны 8 дугаар сард Колумбид хөдөө аж ахуйн бусад ургамал тариалахад нь зориулан 1,3 тэрбум долларын санхүүгийн тусламж үзүүлжээ. Эдүгээ европын холбоо болон бусад донор улс Афганистаны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг үндсээр нь өөрчилж зохион байгуулахад дээрхийн адил санхүүгийн тусламж үзүүлэх асуудлыг боловсруулж байна.

АНУ-д хэрэгжүүлсэн дээр дурдсан арга хэмжээний дүнд мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо тус улсад (1979-1994 онд) 50 хувиар цөөрчээ.

Дэлхийн улс гүрнүүдэд мансууруулах болон сэтгэцэд хүчтэй

нөлөөлөх бодисын хэрэгт холбогдогчдод ногдуулах эрүүгийн хариуцлагыг чангатгах нь зүйтэй гэсэн хандлага зонхилж байгаа юм. Тухайлбал, АНУ-д бүх насаар нь хорих ял ногдуулж байна.

Орчин үед НҮБ-ын тогтоосноор мансууруулах бодисын 65 хүртлэх хувь нь Төв Азийн улсуудын нутаг дэвсгэрээр дамжин тээвэрлэгдэж байна. Зөвхөн Казахстанар дамжуулан жилд дунджаар 150 тонн мансууруулах бодис тээвэрлэж байгаа бөгөөд үүнээс хичнээн нь тус улсын нутаг дэвсгэрт үлдэж байгааг тогтоох боломжгүй гэж үздэг. Афганистанд мансууруулах бодис тариалалт сүүлийн хэдэн жил байнга өссөн тухайлбал, опийний тариалалтын хэмжээ 1998 оныхтой харьцуулахад 3 дахин өсч, өнөөдөр зарим үзүүлэлтээр дэлхийн бүх опийний 70-75 хувийг тус улсад тариалж байгаа нь дээр дурьдсан нөхцөл байдал нөлөөлж байгаа нь тодорхой юм.

Орчин үед мансууруулах бодисын үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, хэрэглэхтэй залхаан цээрлүүлэх, либераль гэсэн үндсэн хоёр аргаар тэмцэж байна. Эхнийх нь мансууруулах бодисын наймаачидтай хүчний байгууллагуудаас хийж буй тууштай, ширүүн тэмцэл юм. Энэ аргаар тэмцэхэд мансууруулах бодисын эсрэг хууль тогтоомжийн заалтыг чангатгаж, хүчний холбогдох байгууллагуудын эрх мэдлийг нэмэгдүүлснээр тодорхой үр дүнд хүрдгийг дэлхийн зарим улсын тухайлбал, Японы туршлага бэлхэнээ харуулж байгаа юм. Япон улс өнгөрсөн зууны 50-иад оноос энэ салбарын хууль тогтоомжийн заалтаа чангатгаснаар мансууруулах бодистой холбогдол бүхий гэмт хэргийн улмаас ял шийтгүүлэгчдийн тоо эрс цөөрсөн байна.

Казахстаны тусгай албад

мансууруулах бодисын эсрэг эрчимтэй тэмцэл хийж байна. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын хорооны мэдээллээр тус улсад мансууруулах бодис нэвтрүүлж байсан 15 сувгийг илрүүлж, мансууруулах бодистой холбоо бүхий гэмт хэргийн 13 бүлэглэлийг устгажээ. Түүнчлэн хүчний байгууллагууд 56 тонн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг илрүүлж устгасан нь 2 жилийн өмнөхөөс даруй тав дахин их хэмжээ юм.

Өнөөдрийн байдлаар Казахстаны Үндэсний аюулгүй байдлын хороо тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн бүх улсын тусгай албадтай мансууруулах бодисын олон улсын хууль бус борлуулалтыг таслан зогсоох асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулж энэ салбар дахь үйл ажиллагаагаа нягт уялдуулан зохицуулж байна.

Ойрын үед БНКаЗУ-д мансууруулах бодисын наймаанд холбогдол бүхий хүмүүсийн гүйлгээг хаах зорилготой байгууллага хоорондын тусгай сан байгуулахаар төлөвлөж байна. Саяхан Казахстан, АНУ-ын хооронд мансууруулах бодисын зах зээлийн борлуулалтыг салбарт хяналт тавих, хэв журам сахиулах асуудлаар харилцан ойлголцох тухай Меморандумд Астана хотноо гарын үсэг зурав. Энэхүү Меморандумын дагуу АНУ, Казахстан улсын хил хамгаалалтыг бэхжүүлэхэд зориулан орчин үеийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр тохирсон байна.

Мансууруулах бодисын эсрэг тэмцлийн чухал хэсэг нь улс гүрнүүд дотооддоо мансууруулах бодис хэрэглэгчдийн талаар эрүүл мэндийн байгууллагуудаас хэрэгжүүлэх арга хэмжээ байдаг. Мансууруулах бодис хэрэглэснээр хүний биеийн ердийн хүчин чадлыг эрс доройтуулж, түүний эрүүл мэндийг хохироодог хор

уршигтай юм.

Сүүлийн хэдэн жил Баруун европт мансууруулах бодис хэрэглэсэн, түүний дотор ДОХ-оор өвчилснөөс нас барагчдын тоо эрс нэмэгджээ. Тэнд ДОХ-оор өвчилсөн 10 хүн тутмын 8 нь мансууруулах бодис хэрэглэснээс болсон байна. Түүнчлэн мансууруулах бодис хэрэглэгчдийг эмчлэх нь ихээхэн төвөгтэй бөгөөд удаан хугацаа шаарддаг хэцүү ажил юм.

Мансууруулах бодис хэрэглэгчидтэй тэмцэх өөр нэг чухал хэлбэр нь түүнээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх

явдал бөгөөд үүнд эрүүлийг хамгаалах, боловсрол, залуучуудын болон сэтгэл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд чухал үүрэгтэй байдаг. Энэ талаар Казахстаны хэвлэлийн албан ёсны сурвалжийн эх мэдээлэл байна.

Мансууруулах бодистой хийх тэмцэл бол дэлхий нийтийн өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Иймээс манай улс энэ талаарх хууль тогтоомжоо боловсронгуй болгох, хил залгаа хөрш орнуудтайгаа нягт хамтран ажиллах нь тулгамдсан асуудлын нэг болдоо.

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)

(Улаанбаатар хот)

(Хэсэгчлэн авав)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэргийн оролцогч

19 дүгээр зүйл. Нэхэмжлэгчийн эрх, үүрэг

19.1. Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

19.1.1. нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай эвлэрэх;

19.1.2. захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцох;

19.1.3. нотлох баримт гаргаж өгөх, хэргийг буцаалгах, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;

19.1.4. шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргахыг шаардах;

19.1.5. шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;

19.1.6. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах;

19.1.7. хуульд заасан бусад эрх.

19.2. Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:

19.2.1. захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;

19.2.2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;

19.2.3. захиргааны хэргийн шүүхийн тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх.

ПРОКУРОРЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Улсын ерөнхий прокурорын орлогч,
Төрийн хууль цаазын шадар зөвлөх Б.Цэрэнбалтаг

Улсын Их Хурлаас 1998 онд баталсан эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр нь прокурорын үйл ажиллагааны гол чиг баримжаа болж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд прокурорын байгууллагын хувьд юуг шинэчлэх ёстой байсан бэ гэвэл:

Прокурорын хяналтын хуучин арга барилаас татгалзах, үйл ажиллагаа, агуулгын хувьд шинэчлэх нь чухал байв. Энэ шинэчлэлийг хийх үндэс нь “Прокурорын байгууллагын тухай” хуулийг өөрчлөн боловсронгуй болгох явдэл байлаа. Нөгөө талаас энэ нь нийгмийн хэрэгцээ шаардлага байсан юм.

Иймд “Прокурорын байгууллагын тухай” хуулийн өөрчлөлтийг агуулгаар нь шинэчлэх чиглэл байлаа. Өөрөөр хэлбэл Прокурорын байгууллагын тухай хуульд чанарын шинэчлэлт хийсэн бөгөөд харин үг, үсэг найруулгын шинжтэй нь цөөн болно.

Прокурорын байгууллагын тодорхойлолтыг прокурор гэдэг төрийн албан хаагчийн гүйцэтгэвэл зохих чиг үүргээс тусад нь анх удаа тодорхойлж, ийм байдлаар хуулийн өөрчлөлтийн эхний үндсийг тавьсан бөгөөд энэ нь прокурорын чиг үүргийг боловсронгуй болгож өөрчлөх, түүнийг хөгжлийн хэтийн хандлагад нийцүүлэхэд чиглэгдсэн болно.

Хуучин хуулиар (ялангуяа Эрүүгийн байцаан шийтгэх хууль) эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гол шийдвэрүүд, ялангуяа хэрэг шийдвэрлэх асуудлыг олон тооны субъектүүд хариуцаж, хоорондоо уялдаа авцалдаагүй,

давхардсан шийдвэрүүдийг дур мэдэн гаргаж, хэн эцсийн шийдвэр гаргаж байгаа нь ойлгомжгүй тойрог маягтай болж, үүнийхээ төлөө хэн ч хариуцлага хүлээдэггүй байдал хэвшиж тогтсон байв. Байцаан шийтгэх ажиллагааны шийдвэрийг ямар албан тушаалтан /хэрэг бүртгэгч үү, мөрдөн байцаагч уу, прокурор уу/ зангидаж гаргах нь ойлгомжгүй байсаар, эцэстээ иргэд чирэгдэж хохирч байлаа. Прокурорын бүрэн эрхийн асуудал ч зохих байдлаар хуульчлагдаж чадаагүй байв. Энэ бүхэн санаа зовоосон, шийдвэрлэвэл зохих асуудал юм. Эдгээр ужгирсан байдлыг эвдэхэд прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчлэлт чиглэгдлээ.

Хуулийн шинэчлэлтийг Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд нэгэн адил хийж ижил агуулгатай болсон явдал юм. Прокурор нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат бүрийг хянах, түүнд оролцохыг шаардаж байсан ч шинэ хуулиудаар хэрэгжих боломжгүй боллоо. Юуны өмнө эрүүгийн хэрэг үүсмэгц прокуророос эрүүгийн хэргийн дугаар олгох шинэ чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой болсон бөгөөд энэ нь цаг алдалгүй прокуророос хэрэгт хяналт тавих, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд анхны үе шатаас оролцох цоо шинэ боломжийг бүрдүүлж өгөв. Эрүүгийн хэрэгт тавих прокурорын хяналтын эхлэх цэгийг янз бүрээр ойлгон, хэрэгжүүлж ирснийг ийнхүү тодорхой болголоо.

Нөгөө талаар эрүүгийн хэргийн дугаар олгох нь зөвхөн техникийн

шинжтэй асуудал огт биш бөгөөд Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, эрүүгийн тоо бүртгэлийн ажлын үндсэн хэсэг гэдэг утгаар ойлгож чиг үүргийг хэрэгжүүлбэл зохино. ✓

Хяналтын ажлын өмнөх хуулиудын зохицуулалт ихээхэн өөрчлөгдлөө. Иймээс прокурорын хяналтын хуучин арга барил тохирохгүй болсон. Одоо прокурорын хяналт /хөндлөнгийн хяналт бүр ч биш/ гэхээсээ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг мэргэжил арга зүйгээр удирдах, хөтөлж явуулах үүрэг давамгайлж түүнд нийцсэн арга барил шаардлагатай болж байна.

[Үүнтэй холбогдсон үндсэн гол өөрчлөлт нь шүүхийн шатнаас өмнөх эрүүгийн хэргийн талаархи шийдвэрүүдийг прокурор дангаараа гаргадаг болсон явдал юм. Гаргах шийдвэрийнхээ хуулийн үндэслэлийг сайжруулах, мөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд байнгын тасралтгүй хяналт тавих мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндэс нь прокурор байцаан шийтгэх ажиллагааны үе шат бүрт оролцох, биеллэн хяналт тавих явдал юм. Энэ нь ажлын амьд холбоо байх учиртай. Заавал оролцож байх, хуулийг хэрэгжүүлэх ажлын шаардлага ч бий. Өөрөөр хэлбэл байцаан шийтгэх бүхий л ажиллагаа явагдаад дууссан хойно хэргийг прокурор хянадаг арга барил хуучирч халаагаа өгч байна. Эрүүгийн хэрэгт тавих хяналт цаг хугацаа алдвал ямар ч ач холбогдолгүй гэдэг нь ойлгомжтой асуудал боллоо. Эдгээр чанараараа прокурорын хариуцах ажлын хүрээ нэмэгдэж, хүлээх үүрэг хариуцлага тодорхой болсон юм.

Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын аль алинд нь прокурорын үүргийн шинжтэй заалтууд нилээд өргөжиж тусгагдсан байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар

прокурорын эрх, үүрэг ихээхэн нэмэгдсэн нь хуучин, шинэ хуулийг харьцуулж хийсэн судалгаагаар харагдаж байна. Үүнийг багшлалж үзэхэд прокурорт 30 гаруй эрх, үүрэг шинээр буюу өргөжиж нэмэгдсэн байдал харагдаж байна /Энэ талаар прокурорын ном гарын авлагаас нарийвчлан үзэж болно/. ✓

Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан аргачилсан заавруудад прокурорын эрх, үүргийг шат шатанд нь тодорхой зааж өгсөн. Хууль түүнд холбогдон гарсан журам, заавруудаар аль ч шатны прокурорын хүлээх үүрэг, хариуцлагыг ихээхэн тодорхой болгосны зэрэгцээ түүний биелүүлэх хугацааг нэгэн адил тодруулж тусгалаа. Харин үүнд тасралтгүй хяналт тавих үүргийг дээд шатны прокурор хүлээнэ.

Прокурорын үүргээ хэрхэн биелүүлсэн байх үнэлэмж өөрчлөгдөж, ажил дүгнэх шалгуур үзүүлэлтүүд шинэчлэгдэж байна. Үүнээс гадна улсад гаргадаг статистикийн мэдээ байна. Дээрх хоёр асуудлыг тус тусад нь ойлгож хэрэгжүүлэх нь чухал юм. Прокурорын байгууллагын тухай хуульд шинээр тусгагдсан зарим онцлог заалт бий. Тухайлбал: энэ хуулийн 32 дугаар зүйл нь дээд шатны прокурорт ногдуулсан үүргийн шинжтэй онцлог заалтыг нэрлэж болно. Эдгээр заалтыг эрх гэдэг талаас нь ойлгохгүй байх нь чухал юм.

Энэхүү зүйлд доод шатны прокурорын гаргасан шийдвэрээс гадна, зарим тал /нэг/ нь шүүхийн гаргасан шийдвэр /хэргийг цагаатгах тогтоол/ байгаа тул шүүхтэй ч холбоотой ажиллаж, дээд шатны прокуророос үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн үг юм. Прокуророос хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад прокуророос тавих хяналтыг төвлөрүүлж ирсэн арга барилыг шинэчилж, дотооддоо хяналт тавих, давхар хяналтын зарчмыг

оновчтой хэрэгжүүлэх нь чухал асуудлын нэг мөн.

Доод шатны прокурорын үйл ажиллагаа хэргийн талаар гаргасан шийдвэрийг хянаж байх давхар хяналтын механизмыг тогтооход дотоод ажил чиглэгдэх ёстой. Нөгөө талаар шинэ хуулиар дээд шатны прокурор нь доод шатны нэгжтэйгээ болон прокуроруудтай ажиллах боломжийг өмнөхөөс илүү бүрдүүлж өгсөн давуу талтай. Энэ нь дотоод хяналтыг улам бүр үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Бид өмнө нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчтай ихэвчлэн ажиллаж, доод шатны прокурортой ажиллах, тэдэнд хариуцлага тооцох ажил үлдэж, орхигдож байсан тал бий. Доод шатны прокурорыг удирдлага чиглэлээр байнга хангах нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн асуудалд шууд прокурорт хамааралтай, өөрөөр хэлбэл прокурор дангаараа хэргийн талаархи шийдвэр гаргадаг болсонтой холбоотой юм.

Прокурорын байгууллагын тухай шинэ хуулиар хяналт тус бүрээр прокурорын эдлэх бүрэн эрхийн асуудлыг тодорхой заасан нь өмнөхөөс онцлогтой байна. Энэхүү хуульд заасан прокурорын бүрэн эрхийг эрх мэдэл гэж ойлгохоосоо хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх арга, бодит боломж гэж ойлговол зохионо. Түүнчлэн эрх хэмжээ, бүрэн эрхийг аль шатны прокурор, хэдийд эдлэх вэ гэдэг нь учир зааг ялгаатай ойлголт юм.

Аймаг, нийслэл, дүүргийн прокурор бүхнийг шийдэх ёстой гэж ойлгож болохгүй. Өөрийнхөө шийдэх үе шат, төвшиндөө тэр эрх хэмжээгээ эдэлдэг. Бүхнийг урдуур нь орж шийдээд байвал бусад прокурорын бие даасан ажиллагааг алдагдуулаад зогсохгүй, байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын хуульд заасан давж заалдах, гомдол гаргах

эрхийг хязгаарласан ноцтой зөрчил болдог.

Харин дээд, доод шатны прокурорууд бодол, саналаа харилцан солилцож байх нь нэн чухал юм. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажлын үр дүн ч прокурорын үйл ажиллагаанд зохих ёсоор хамааралтай гэж ойлговол зохино. Энэ нь прокурорын үүрэг агуулгын хувьд өргөжсөнтэй холбоотой. Иймд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа прокурорын мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах нь чухал гэдгийг дахин тэмдэглэж байна. Юуны өмнө хэргийн идрүүлэлтэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Прокурорын хяналтын ажлын зайлшгүй хэсэг нь эзэн этгээдийг олж тогтооход чиглэгдэх ёстой юм.

Нөгөө талаар хэргийн шийдвэрлэлтийн зохистой харьцааны /шүүхэд шилжүүлсэн, хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн, үлдэгдэл хэргийн эзлэх хувийн жин/ асуудал нэн чухал ач холбогдолтой. Мөрдөн байцаалтын явцад хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн хэрэг илүү жин дарвал зөв зохистой харьцаа биш бөгөөд прокуророос дүн шинжилгээ хийх шаардлагатайг харуулж байна. Бусдыг хилсдүүлж, хохироохгүй байхад /хилсээр хэрэгт татахгүй, хорихгүй байх, бусдын эрхийг хууль бусаар хөндөхгүй байх/ прокурорын хяналт бүрэн чиглэгдвэл зохино.

Хэргийг хуулийн хугацаанд шуурхай шалгаж шийдвэрлэж байх, хэргийн хуулийн хугацаа сунгах ажиллагаанд прокуророос тавих хяналт хатуу, чанга байх хэрэгтэй. Хэдийгээр хэргийг хугацаанд шийдвэрлэхгүй будсыг чирэгдүүлж, хүнд суртал гаргаж буй явдал байсаар байна. Мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт нь зөвхөн хүнд, онц хүнд хэргийг шийдвэрлэхэд чиглэгдэж, үүгээрээ өмнөхөөс онцлогтой болсон байна. Хүнд, онц хүнд хэргийн эзлэх

хувийн жингээр эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэргийн аюулыг тодорхойлдог учраас онцлон үзэх асуудал, дараахь шинэ шардлага гарч ирж байна.

Юуны өмнө энэ төрлийн хэргийн илрүүлэлтийн хувийг ямагт өндөр байлгах, үүнийг прокурор хуулиар хэрэг илрүүлэх үүрэгтэй холбож үзэж байх, цаана нь ноцтой үр дагавар гарсан хохирол учирсан байдагт доорхи шаарлагын үндэс оршино. Хэргийн газрын үзлэгт прокурор оролцож байх шаардлага тавигдаж байгаа бөгөөд ялангуяа онц хүнд хэргийн газарт прокурор очиж ажиллах ёстой. Хяналт тавих гэдэг утгаар биш очиж ажиллах, ул мөр илрүүлэх, бэхжүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох ажиллагаанд биечлэн оролцох хэрэгтэй юм. Бусад байцаан шийтгэх /нэгжлэг хийх, таньж олуулах, туршилт хийх, задлан шинжилгээ хийх г.м/ ажиллагаанд байнга оролцож, шинжээч томилох асуудлаар заалт чиглэл өгөх дүгнэлт гаргахад биечлэн оролцож байх шаардлагатай. Санаатай хэрцгий балмад аргаар үйлдсэн хэрэгт илүүтэй анхаарал төвлөрүүлж, байнга хяналт тавих хэрэгтэй байна.

Хүнд, онц хүнд хэргийн дотор улс орны эдийн засаг, хил хязгаарын халдашгүй дархан байдалд хохирол учруулсан хил, гааль татвартай холбоотой хэрэг, албан тушаал авлигын хэргийн шийдвэрлэлтийг мөн илүү анхаарах, шийдвэртэй арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байхад прокурорын үйл ажиллагааг бүрэн чиглүүлэх шаардлагатай болдоо. Уг асуудалд өмнөхөөс өөрөөр хандах хэрэгтэй болсон бөгөөд энэ нь прокурорын байгууллагын хувьд бодлогын чухал асуудал юм. Дээрх төрлийн хэрэгт ногдуулах, ял шийтгэлийг чангатгах, шүүхээс ногдуулж буй ял шийтгэлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх асуудалд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Эцэст нь тэмдэглэхэд шинэ хуулиар прокурорын үйл ажиллагаа олон түмэнд улам ил тод явагдах болов. Эрүүгийн хэргийг хэрхэн шийдвэрлэснийг иргэд олон түмэн зөвхөн прокуророос асуух боллоо. Олон түмэн сонирхож байгаа хэргээ прокурор хэрхэн шийдвэрлэхийг ажиглан харж байгаа энэ нөхцөлд прокурор өмнөхөөс илүү хуулийн хүрээнд шударга, ёс зүйгээ баримталж ажиллах явдал чухал байна.

* * *

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэргийн оролцогч

23 дугаар зүйл. Хамтран хариуцагч

23.1. Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байж болох ба тэдгээр нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй.

23.2. Хамтран хариуцагчид нь ашиг сонирхлын зөрчилгүй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй, түүнчлэн хэргийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл хэн нэгийгээ томилон өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулж болно.

* * *

ӨМГӨӨЛЛИЙН НУУЦЫН ТУХАЙ

Өмгөөлөгч Б.Эрдэнэцогт

Иргэн, хуулийн этгээдээс өмгөөллийн байгууллага, мэргэжлийн өмгөөлөгчид хандан эрх зүйн туслалцаа авахаар тохиролцон хэлцэл хийгдсэн үеэс өмгөөлөх байгууллага, өмгөөлөгч нь тухайн иргэн, хуулийн этгээдийн амин хувийн болон байгууллагын нууцыг хадгалах үүргийг хуулиар хүлээсэн байдаг.

Үйлчлүүлэгч, төлөөлүүлэгчийн хууль ёсны эрх ашиг, ашиг сонирхлыг хамгаалахын тулд эрх зүйн туслалцаа үзүүлэх явцдаа олж мэдсэн зүйл/мэдээ, баримт сэлт, биет зүйл/ тэдгээрт өгсөн эрх зүйн зөвлөгөө нь өмгөөллийн нууцад хамаарна. 1992 оны шинэ Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт: “Хүн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, 17 дахь хэсэгт Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж эрх зүйн суурь хуулиндаа тогтоож өгсөн нь органик болон бусад хууль тогтоомжоор хувь хүн, хуулийн этгээдүүдийн нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах үндэс нь болж өгсөн байна.

2002 онд батлагдсан “Өмгөөллийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлд өмгөөллийн нууцын талаар эрх зүйн зохицуулалтад “Өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа эрх зүйн туслалцаатай холбоотой бүхий л мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарна” гэж заасан нь хүний эрх, эрх

чөлөөг дээдэлсэн, өмгөөлөгчдийн үйл ажиллагаагаа явуулахад хэнээс ч хамааралгүй байх эрх зүйн баталгаа юм.

Түүнчлэн дээр зохицуулалтад өмгөөлөх байгууллага, өмгөөлөгчийн эрх, үүргийг хуульчлан тогтоож, өмгөөллийн нууцыг задруулах, амин хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хориглосон нь мэргэжлийн өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах алхам болжээ.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх явцдаа өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ /хувь хүн, байгууллага, төр/ нууцыг олж мэддэг бөгөөд түүнтэй нь холбогдуулан өмгөөлөгчийн гэрчээр болон бусад байдлаар байцаах, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор асуух, хуульд зааснаас бусад тохиолдолд өмгөөлөгчийн яриаг чагнах, албан байранд нь өмгөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой материал баримт бичгийг гаргуулан авахыг хориглодог. Мөн өмгөөллийн нууцыг хадгалах үүргийг хүлээнэ.

Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн 2001 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “Монголын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийн 5 дугаар зүйлд өмгөөллийн нууцын тухай, 7 дугаар зүйлд “Өмгөөллийн нууцыг хадгалах нь” өмгөөлөгчөөс хувь хүн, хуулийн этгээдэд эрх зүйн туслалцаа үзүүлэхэд баримтлах зарчмын тухай заасан байдаг. Дээрх зарчмыг өмгөөлөгч зөрчвөл үйлчлүүлэгчдээ хохирол учруулах бөгөөд өөрөө ч сахилгын хариушлага хүлээдэг байна.

НОТАРИАТ ЯМАР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ВЭ?

“Эрх зүйн шинэтгэл” төслийн
ажилтан Иммануэль Гебхардт

“Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1997 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан “Нотаратын тухай” хуулийг мөрдөн ажиллаж байна. Энэ хуулиар нотариатын үйл ажиллагааг эрхлэн явуулах 3 төрлийн нотариатч байна гэжээ. Үүнд нотариатч, өмгөөлөгч нотариатч болон нотариатчийн үүрэг гүйцэтгэгч төрийн захиргааны албаны хүмүүс байх юм. Өмгөөллийн хуулийн дагуу өмгөөлөгч, нотариатчийн үүргийг давхар гүйцэтгэхийг зөвшөөрдөг байна.

Монгол Улсын хувьд үндэсний нотариатын нэг танхимтай ба энэ нь удирдлагын төв бөгөөд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг, түүний салбарууд аймаг, нийслэлд ажилладаг. Нотариатын байгууллага нь ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд Хууль зүйн яаманд бүртгүүлж, зохион байгуулалт, үйл ажиллагааг дүрмээр зохицуулдаг.

Нотариатын танхим нь Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран нотариатын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Нотариатчаар Монгол Улсын харьяат, хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг ажиллуулахыг зөвшөөрдөг. Нотариатчийг сонгон шалгаруулах ажлыг нотариатын танхим зохион байгуулна.

Нотариатын танхимын дэргэд нотариатчдийг сонгон шалгаруулах

мэргэжлийн, орон тооны бус комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнийг Хууль зүйн сайд баталдаг. Хэрэв нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзсан шийдвэрийг тухайн иргэн эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй. Нотариатч болон өмгөөлөгч нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн яамнаас өгдөг.

Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэшлийн шалгаруулалт явуулах тухай асуудлыг нотариатын тойрог, нотариатчдын орон тоо, хэрэгцээг харгалзан тухай бүр шийдвэрлэнэ.

Нотариатын тойрог түүнд ажиллах нотариатчын тоог Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоодог. Аймаг, нийслэлийн Засаг дарга хүн амын байршил, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг харгалзан нотариатын тойрогт ажиллах нотариатчын тооны талаар саналаа боловсруулж Хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ хэмээн зохицуулсан нь нотариатчын тоог захиргааны аргаар хязгаарлаж буй мэт сэтгэгдэл төрүүлж байна. Улмаар цөөн тооны нотариатч өндөр орлоготой ажиллах нөхцөл байдал үүсэх нь уг мэргэжлээр ажиллах сонирхолыг бүрэлдүүлж өрсөлдөөн өрнүүлэх эерэг талтай хэдий ч албан тушаалаа урвуулан ашиглах хээл хахуульд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна.

Нотариатч нь үйл ажиллагаа явуулахдаа хараат бус бие даасан шинжтэй ажиллах ёстой бөгөөд

НОТАРИАТ ЯМАР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ВЭ?

“Эрх зүйн шинэтгэл” төслийн
ажилтан Иммануэль Гебхардт

“Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1997 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан “Нотаратын тухай” хуулийг мөрдөн ажиллаж байна. Энэ хуулиар нотариатын үйл ажиллагааг эрхлэн явуулах 3 төрлийн нотариатч байна гэжээ. Үүнд нотариатч, өмгөөлөгч нотариатч болон нотариатчийн үүрэг гүйцэтгэгч төрийн захиргааны албаны хүмүүс байх юм. Өмгөөллийн хуулийн дагуу өмгөөлөгч, нотариатчийн үүргийг давхар гүйцэтгэхийг зөвшөөрдөг байна.

Монгол Улсын хувьд үндэсний нотариатын нэг танхимтай ба энэ нь удирдлагын төв бөгөөд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг, түүний салбарууд аймаг, нийслэлд ажилладаг. Нотариатын байгууллага нь ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд Хууль зүйн яаманд бүртгүүлж, зохион байгуулалт, үйл ажиллагааг дүрмээр зохицуулдаг.

Нотариатын танхим нь Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран нотариатын үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Нотариатчаар Монгол Улсын харъяат, хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг ажиллуулахыг зөвшөөрдөг. Нотариатчийг сонгон шалгаруулах ажлыг нотариатын танхим зохион байгуулна.

Нотариатын танхимын дэргэд нотариатчдийг сонгон шалгаруулах

мэргэжлийн, орон тооны бус комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнийг Хууль зүйн сайд баталдаг. Хэрэв нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзсан шийдвэрийг тухайн иргэн эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй. Нотариатч болон өмгөөлөгч нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн яамнаас өгдөг.

Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэшлийн шалгаруулалт явуулах тухай асуудлыг нотариатын тойрог, нотариатчдын орон тоо, хэрэгцээг харгалзан тухай бүр шийдвэрлэнэ.

Нотариатын тойрог түүнд ажиллах нотариатчын тоог Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоодог. Аймаг, нийслэлийн Засаг дарга хүн амын байршил, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг харгалзан нотариатын тойрогт ажиллах нотариатчын тооны талаар саналаа боловсруулж Хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ хэмээн зохицуулсан нь нотариатчын тоог захиргааны аргаар хязгаарлаж буй мэт сэтгэгдэл төрүүлж байна. Улмаар цөөн тооны нотариатч өндөр орлоготой ажиллах нөхцөл байдал үүсэх нь уг мэргэжлээр ажиллах сонирхолыг бүрэлдүүлж өрсөлдөөн өрнүүлэх зөргө талтай хэдий ч албан тушаалаа урвуулан ашиглах хээл хахуульд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна.

Нотариатч нь үйл ажиллагаа явуулахдаа хараат бус бие даасан шинжтэй ажиллах ёстой бөгөөд

өөрийн үйл ажиллагааг хууль бусаар ашиглахыг хатуу хориглоно. Нотариатч нь нотариатчийн үйл ажиллагаанаас хохирол учирч болох тохиолдол бүрийг тусгасан даатгалын гэрээг Нотариатчдын танхимтай байгуулдаг. Нотариатчдын танхим гэрээний нөхцөл өөрчлөгдөх, хүчингүй болох, хугацаа нь дуусгавар болох тохиолдолд энэ тухай нотариатчдад нэн даруй мэдэгдэж байна. Өнөөг

хүртэл Хууль зүйн яам нь нотариатын танхимд хүчтэй нөлөөлж байгаа нь нотариатчид биеэ даасан байдлаа бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүйд хүргэж байгаа ч шинэтгэлийн үйл явц нотариатын эрх зүйн орчинг тууштай өөрчилж байна. Ялангуяа хөрш зэргэлдээ БНХАУ-д өнөөг хүртэл төрийн албаны нотариат байдагтай харьцуулахад урагштай хөгжиж байна”.

* * *

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

(2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)
(Улаанбаатар хот)
(Хэсэгчлэн авав)

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэргийн оролцогч

20 дугаар зүйл. Хариуцагчийн эрх, үүрэг

20.1.Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

20.1.1.захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;

20.1.2.нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, эсхүл татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчтэй эвлэрэх;

20.1.3.захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх;

20.1.4.хэргийг буцаалгах, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, нэмэлт нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;

20.1.5.энэ хуулийн 19.1.4.-19.1.7.-д заасан эрх.

20.2.Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:

20.2.1.нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, захиргааны хэргийн шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх;

20.2.2. захиргааны хэргийн шүүхээс тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх, шүүх хуралдаанд оролцох;

20.2.3.захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх.

* * *

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ ХУУЛИЙГ ҮНДЭСЛЭЖ ШҮҮХИЙН АРГААР ШИЙДВЭР ГАРГАДАГ



Хууль зүйн
шинжлэх
ухааны доктор,
профессор,
Монгол Улсын
Гавьяат хуульч
Г.Совд

Манай ёсонд хувьтай хүн хур борооноор гэж ярьдаг. Нийслэлд өглөөнөөс бороо орж сая танайд ирэхэд нилээн ширүүлсээ. Тэгээд би ирж явахдаа бодлоо л доо Совд гуай үнэхээр хувьтай хүн юм байна. Бороо асгараад гээд ... Тэгэхээр би өөрийгөө хамаатуулаад хувьтай хүмүүс хур борооноор гэж хэлэх гээд байгаа. Энэ санаанаас яриагаа эхэлбэл ямар вэ?

- За бид хоёрын уулзаж байгаа энэ мөчид үнэхээр хур бороо орж, тэнгэр хайраа ивээж байгаа нь ган гачиг тайлагдаж, сайхан зун болохын эхлэл бизээ ... Танай сэтгүүлийн хамт олонд энэ бороо орж, зун дэлгэрч байгаа шиг цаашдаа улам дэлгэрч манай хуулийн байгууллагын ажилтнууд, хуульчдын оюун санааг гэгээгээрүүлэх ажилдаа улам их амжилт гаргаарай гэж бэлэгшээж байна даа.

Та манай нэрт хуульчдын нэг. Энэ мэргэжлийг сонгосон уу, эсвэл тохиолдлынх байсан уу?

- Би цэрэгт ариун цэврийн зааварлагчийн курс төгсөж, цэргийн госпитальд албаа хаасан юм. Манай ангийн дарга Шаравдорж гэдэг хүн намайг ЗХУ-д цэргийн хүн

эмнэлгийн академид явуулна гэх би дотроо эмнэлгийн чиглэлээр явах дургүй хуульч болох санаатай байдаг. Тэгээд цэргээс халагдаад нутагтаа очиход тэр үед боловсон хүчин дутагдалтай байсан үе л дээ. Гэтэл аймгийн намын хороо дуудаж намайг Прокурорт мөрдөн байцаагчаар шууд томилуулахаар шилжүүлсэн юм. Тэгээд 2 жил гаруй ажиллаж байтал 1956 онд Улаанбаатарт Хуулийн дунд сургууль анх нээгдэхэд би анхны оюутан, анхны төгсөгч болж байлаа. Ингэж л хуульч болох гараа маань эхэлсэн юм даа.

Та чинь сургууль төгсөхөөсөө өмнө хуульч болчихсон байсан юм биш үү?

- Мөрдөн байцаагч байсан харин хуульч гэхэд хэцүү л дээ. Анх ажилд ороход Эрүүгийн хууль, Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг 14 хоногийн хугацаатай уншуулаад шалгалт авсан юм. Залуу байсан болохоор бараг бүгдийг нь цээжилчихнэ биз дээ. Тэр үед хэрэг мөрдөн байцаах үүргийг прокурор гүйцэтгэдэг, цагдаа мөрдөн байцаалт хийдэггүй байлаа.

Дараа нь хойшоо сургуульд явсан гэдэг байхаа ...?

- ЗХУ-д Ленинград хотын Улсын их сургуулийн хуулийн салбарт 4 жил суралцсан, сургууль төгсөх жилээ биений эрүүл мэндийн байдлаас шалтгаалж, Свердловск хотын Хууль зүйн дээд сургуульд шилжиж төгссөн юм.

Сургуулиа төгсөөж ирээд ямар албанд томилогдсон бэ?

- 1962 оны зун БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит чуулган хуралдаж байв. Энэ үед би амралтаараа дадлага хийхээр ирсэн байлаа. Гэтэл намайг Улсын дээд шүүхийн Эрүүгийн коллегийн гишүүнээр оюутан байхад сонгосон. Тэгээд би зунжингаа коллегийн гишүүний үүргээ гүйцэтгэж, УДШ-д хэрэг хяналаа. Сургуулиа төгсөж ирээд Эрүүгийн коллегийн гишүүний ажлаа хийсэн. Энэ үед л жинхэнэ хуульч болсон байлаа шүү дээ.

Та олон жил их сургуульд багшилсан хун. Анх хэдийд энэ ажилд шилжсэн бэ?

- 1964 онд МАХН-ын Төв Хорооны тогтоол гарч МУИС-ийн Хуулийн салбарыг бэхжүүлэх талаар арга хэмжээ авч, хуульчдын дундаас багш шалгаруулсан юм. Би мөн оны 7 дугаар сард МУИС-д багшаар очиж, 2 сарын дараа шинэ хичээлийн жил эхлэхэд Тэнхимийн эрхлэгчээр томилогдож байлаа. Эдүгээ 39 дэх жилдээ багшийн ажлаас хөндийрөөгүй л явна даа.

Таныг олон шавьтай тэдгээрийн дотроос одоогийн хуулийн салбарт ажиллаж байгаа томчуудын багш нь гэдэг юм билээ?

- Хичээл заалгасан шавь олон олон, чухам хэд болсон тоог мэдэхгүй. Харин тоймтойгоос нь хэлбэл хуулийн мэргэжлийн шавь нар дотроос шинжлэх ухааны доктор 7, түүний дотор академич 2 /Ж.Амарсанаа, С.Нарангэрэл/, гавъяат хуульч 17 /дашрамд хэлэхэд Б.Чимид, Т.Сэнгэдорж нар анхны шавь/, дэд доктор, сайд, дарга гээд олон бий дээ.

Багшлахын зэрэгцээ Та бас энэ хооронд том дарга хийж байсан санагдана?

- Намын Төв Хорооны шийдвэрээр 1973-1992 онд Улсын дээд шүүхийн нэгдүгээр орлогч дарга бөгөөд Эрүүгийн коллегийн дарга, Улсын Прокурорын нэгдүгээр орлогч, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн газарт хэлтсийн дарга, дараа нь ШУА-ийн Төр эрх зүйн хүрээлэнгийн захирлаар тус тус ажиллаж байлаа.

Дараа нь бур том дарга болсон. Үндсэн хуулийн Цэцийн анхны дарга нь Та байсан. Улсын Бага Хурлаас энэ албан тушаалд өндөр хувьтай сонгогдож байсныг санаж байна. Анхны юм бүхэн сонин содон байдаг. Энэ талаар таны ээтгэгдлийг сонсох гэсэн юм.

- Улсын Бага Хурал Цэцийн 8 гишүүнийг сонгож баталсан /Б.Пүрэв генерал нэрээ татсан/ юм. Цэцийн 8 гишүүн нууц санал хураалтаар даргаа сонгоход намайг гаргасан л даа. Цэцийн анхны гишүүдээс орон тооны Н.Жанпан, Б.Дангаасүрэн, Г.Нямдоо гурав, орон тооны бус нь Ц.Цолмон, Д.Чилхаажав, Л.Баасан, Ж.Бямбаа, Ж.Чойжанцан нар шүү дээ. Анхны гишүүдээс Н.Жанцан, Д.Чилхаажав хоёр одоо хүртэл ажиллаж байна. Цэцийн даргаар сонгогдсоны дараа намайг Төрийн ордны 201 дугаарын өрөөнд орууллаа. Энэ өрөө их түүхтэй. Анх Улсын Бага Хурлын дарга Бумцэнд гуай сууж байсан гэдэг. Тэгээд Цэцийн тамга, албан бичгийн хуудсаа хийлгэхээс ажлаа эхэлж, нөгөө 3 гишүүнээ өрөө савтай болгож байлаа.

Хамгийн анхны өргөдөл, маргаан хэнийх байсан, яаж шийдээж байв даа. Ер нь нарийн төвөгтэй асуудал их тулгарна биздээ?

- Цэц цоо шинэ байгууллага учир манайхан үүрэг зорилгыг нь гүйцэд ойлгодоггүй байсан. Эхэн үедээ өргөдөлд ёстой дарагдсан даа. Ихэнх нь МАХН-ын Хянан шалгах хороонд

өгдөг матаас маягийн бие биеэ ховлосон хувийн болон улс төрийн шинжтэй байх. Үүний зэрэгцээ Үндсэн хуультай холбоотой маргаанч ирж байлаа. Анхных нь Сэлэнгэ аймгийн Ерөөгийн САА-н Бадарчийн өргөдөл, тэр Ардын Их хурлын депутат байсан юм. Улсын Их Хурал орон нутгийн засаг захиргааны өөрчлөлтөд нутгийн иргэдийн санал аваагүй, асуудлыг буруу шийдсэн гэсэн байв. Энэ өргөдлийг гишүүн Н.Жанцан шалгасан. Эцсийн шийдвэр нь Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгосон юм.

Цэцийн гишүүнд тусалдаг хүн байгаагүй, өргөдлөө өөрөө биечлэн шалгана. Аливаа асуудлыг чихээрээ сонсож, гараараа барьж хийдэг хүн бол Цэцийн гишүүн, шүүгч нар л байдаг. Үндсэн хууль нь манай төрийн улс төрийн бодлогын хамгийн гол зангилаа илэрхийлэл байдаг тул үүнтэй холбоотой маргаан улс төрөөс хөндий байдаггүй учир ийм асуудлаар эцсийн шийдвэр гаргах хариуцлагатай асуудал тавигдана. Асуудлыг шийдэх явцад заримдаа Цэц “улс төржсөн” шийдвэр гаргалаа гэж шүүмжлэх явдал гардаг. Цэцийн хэлэлцэн гаргасан шийдвэр бол монгол төрийн гол бодлогод хамаардаг юм. Намын улс төрийн бодлого биш шүү. Үндсэн хуулийн Цэц хуулийг үндэслэж, шүүхийн аргаар шийдвэр гаргадаг асуудлын гол учиг байгаа юм. Хуульд юу гэж заасан байна тэр ёсоор нь шийддэг онцлогтой. Цэцэд Улс төрийн аргаар хэлэлцээр хийх, зөвшилцөх, харилцан буулт хийх ойлголт байдаггүй. Цэцэд ирсэн маргаан бүр шинэ, дахиж хандаж байсан тохиолдол үгүй, шийдэж чадахгүй яая даа гэсэн зүйл гарч байгаагүй.

Манайхан Төрийн гурван өндөрлөг гээд байдаг. Энэ нь олон түмэнд төдийлөн оновчтой ойлгогддоггүй. Таны

бодол...

- Тиймээ. манайхан Төрийн гурван өндөрлөг гээд 3 даргаа нэрлээд байдаг. Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд гурав бол хамгийн том дарга мөнөөс мөн. Харин төрийн гурван өндөрлөг гэвэл арай өөр ойлголт байгаа юм л даа.

- Хууль тогтоох байгууллага – Улсын Их Хурал,

- Гүйцэтгэх засаглалд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд толгойлдог Засгийн газар хамтдаа багтдаг.

- Шүүх засаглалд Үндсэн хуулийн Цэц, Улсын дээд шүүхтэй нийлээд гуравдах өндөрлөг нь болж байгаа юм.

Тэгэхээр манайхан 3 дахийг нь хаячихаад Дээд шүүхээ ч заримдаа сонсдоггүй юм шиг ажиглагддаг?

- Сонсдог эсэх тухайд мэдэх юм алга. Энд төрийн уламжлал, шинэ соёл дутаад байдаг байхаа. Яваандаа ойлгодог болно л доо. Заавал энийг ойлгуулах гэж Цэцийн дарга ч юмуу, Улсын дээд шүүхийн дарга өөрөө яваад байх хэрэггүй л дээ. Тэгээд ч тэд дуугүй байдаг биз.

Жинхэнэ эрх зүйт төрийн тогтолцоо бүрдсэн үед л тийм болох байх даа?

- Тийм, тийм. Шүүхийг ойлгодог болно.

Хуульч бэлтгэдэг хувийн сургууль олон болсон. Хуулийн ажилтны орон тоо хязгаартай. Үүнтэй холбогдоод хуульчийг сонгон шалгаруулах тулгамдсан асуудал гарч байна. Энэ талаар Таны бодлыг сонсьё?

- Хувийн олон сургуулийг учир зүггүй шүүмжлээд яахав. Хэрвээ тэд хүн сургах боломж, бааз суурьтай бол

боловсрол олгож байг л дээ. Хуулийн боловсрол эзэмшсэн хүн заавал хуульч хийх шаардлагагүй. Өөр ямарч ажилд хуулийн боловсрол хэрэгтэй байна. Харин шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, нотариат зэрэг нарийн мэргэжлийн ажлыг жинхэнэ хуульч хийх ёстой. Одоогийн төслөөр бол их, дээд сургууль төгсөгчдөд эрх зүйч - бакалавр /тэр дипломонд хуульч гэж үг байхгүй/ мэргэжил олгох, дараа нь дахин шалгалт авч байж хуульч болгох жишээтэй. Тийм шалгалт өгсөн хүнд мэргэжлийн хуулийн байгууллагад ажиллах эрх нээгдэнэ гэсэн үг л дээ. Манайх хоёр газрын туршлага судалсан юм билээ. Германд хоёр даваатай шалгалтын систем бий. Хоёр дахь шалгалт нь их хүнд. АНУ-д "Бар"-ын систем гэж бий. Энэ нь хуулийн сургууль төгсөөд тодорхой хугацаанд ажилласны дараа "Бар"-ын гэх тусгай шалгалт өгөөд тэнцсэн нь мэргэжлийн хуульч болдог. Францад магистрантур гэж сургалтын системтэй, дагнаж мэргэшүүлдэг. Шүүгч болоход заавал шүүхийн магистрантур төгссөн байх шаардлагатай. Итали бол тусгай шалгаруулалттай. Тодорхой албанд томилогдохын өмнө тусгай шалгалт өгдөг. Жишээ нь, Их сургуулийн профессор хүн шүүгч болоход тусгай шалгалт өгнө. Манай хувьд эдгээр олон хувилбараас сонголт хийж, Монголын хөрсөнд суух сайн хууль гаргах хэрэгтэй. Улсын Их Хурал энэ асуудлыг удахгүй хэлэлцэнэ байхаа, эрхэм түшээд маань зөв сайн хууль гаргана байх гэж найдаж сууна.

Шинэ залуу хуульчид их гарч байна. Ахмад хуульчид ч ажилласаар байгаа. Тэдний хоорондын харилцааны тухайд таны бодол...

Ахмад хуульчид мэдлэгээ сэргээж, шинэ болох шаардлагатай. Шинэ залуу хуульчид ахмад

үеийнхний сайн талын туршлага, дадлагаас байнга суралцах нь чухал. Тэд хамтарч ажиллахгүй бол залгамж чанар, шинэтгэлийн зарчим алдагдана. Хуулийн ажил нь хүний сэтгэхүй дээр тулгуурладаг нарийн ажиллагаа, нямбай байдал, өндөр мэдрэмж, мэргэжлийн онцгой төвшин шаарддаг. Туршлагаас харахад бага алдаж, алдаан дээрээ суралцаж байж л сайн хуульч болдог шүү дээ. Хуучин арга, муйхар практикаар ахмад нь зүтгээд, залуус нь энэ хоцрогдсон гэж дээгүүр хараад байдаггүй энэ хоёрын холбоо нягт байж ажил урагшилна гэдгийг ямагт санаж байх ёстой.

Таныг УДШ-д ажиллаж байх үеийн шүүхийг одоогийн шүүхтэй харьцуулбал, одоо шинэ шүүх гэсэн нэр томъёо гарсан?

Одоогийн шүүх нь альч талаараа шинэ шүүх. Намайг ажиллаж байх үеийн шүүх Гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэхэд туслах механизм байсан гэж болно. В.И.Ленин "Зөвлөлийн шүүх бол пролетарийн диктатурын төмөр нударга" гэж сургаж байлаа. Манайх ч энэ "сургаал"-ыг удирдлага болгож байсан үе бий шүүдээ. Тэр үед эрх баригч нам, АИХ-аас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, түүнд үйлчилдэг, хууль сахиулах байгууллагын дотор шүүх багтаж, шүүхийг прокурор хянадаг байлаа.

Одоо тэс өөр болсон шүү. Шүүх, тэгээд хууль сахиулах байгууллага гэж нэрлэнэ. Шинэ шүүх нь биеэ даасан, хараат бус боллоо. Сайнаараа ч муугаараа ч шинэчлэгдэж, шүүхтэй харьцах харьцаанд ихээхэн өөрчлөлт гарлаа. Харин шүүхийг хуучнаараа захирах гэдэг, эрх мэдэл биеэ даасан хэлбэрт нь тавихгүй үзэл бодол, дарамтлах хандлага дээрээ байсаар байгаа нь ажиглагддаг. Одоо шүүхдээ итгэх, шүүхээ хүндлэх хэрэгтэй байна. Зарим нэг улс төрчид шүүхийг их

шүүмжилбэл өөрийгөө том улс төрч гэж боддог шиг байна. Одоо үед монголын шүүх муухан улс төрчийн шүүмжлэлийн бай, сайн улс төрчийн хүндэтгэлийн бэлэгдэл болоо шив дээ.

Бид хоёрын ярилцлага дуусах дөхөж байна. Тантай уулзсан дээрээ Улсын Их Хурлын сонгуулийн тухай асуумаар санагдлаа. Энэ талаар Таны бодол?

Улсын Их Хурлын сонгууль болоход нэг жилийн хугацаа үлдлээ. Зарим намууд нэгдэж, эвсэл байгуулж байна. Зарим нь өөрийгөө сурталчлаад л... Манайд сонгуулийн санал савалдаг айхтар муу зуршил бий. Сонгуулийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай. Харин үүнийгээ хэтэрхий оройтуулаад байх шиг. Манайд сонгуулийн систем, тогтолцооны тухай яриад байдаг хэрнээ сонгуулийн процессийг улам боловсронгуй болгох талаар төдийлөн анхаарахгүй байна. Тухайлбал,

томгосон тойрог ач холбогдолтой тэнд сонголт хийх боломж илүү байдаг. Сонгуулийн сурталчилгаа, санхүүжилтийн асуудалд онцгой анхаарал тавих нь их чухал юм. 2004 оны сонгуульд аль нэг нам хэт давуу биш дор хаяж намын бүлэг байгуулах хэмжээний сөрөг хүчинтэй байгаасай гэж бодож байна. Тэгэхгүй бол сөрөг хүчний дуу хоолой ард түмэнд хүрэхгүй, төр хяналтгүй болох сөрөг үр дагавар ажиглагддаг.

Суулийн үед Та юу туурвиж байна вэ?

Хууль зүйн тайлбар толь 500 гаруй хуудастай ном бэлэн болгоод байна. Гэхдээ би ганцаараа биш хоёр академич, хуульч Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал нарын хүмүүс оролцож, гол редакторын ажлыг би өөрөө хийлээ. Энэ толь хуульчдад төдийгүй ер нь судлаач эрдэмтэд, өргөн олон нийтийн хууль эрх зүйн боловсролд ашигтай гарын авлага болно.

ШИНЭ НОМ

- *МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД-6
- *МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД-8
- *МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД -9
- *МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД -10
- *"ГАЗАР" (Монгол Улсын хууль тогтоомжийн эмхтгэл)
- *МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ,
ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
- *МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ,
ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ
- *ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН ТАЙЛБАР
- *ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ (Эмхтгэл)
- *ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
- *ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- *МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ/Монгол улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ/ эмхтгэл
- *МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
(Өврийн 10х14 см)/
- *БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙ (Гарын авлага)
- *ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭН (Д.Зүмбэрэлхам)
- *ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭТГЭЛЦЭХ УР ЧАДВАР (Д.Зүмбэрэлхам)
- *ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТР (Д.Уянга)
- *ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХ
- *МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙ (С.Төмөр)
- *ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ХАНГАХ ТАЛААР ГАРГАСАН
БАРИМТ БИЧГИЙН ЭМХТГЭЛ
- *МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛЫН ЭМХТГЭЛ
- *МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД (Эмхтгэл)
- *ХУУЛЬЧДАД ЗОРИУЛСАН АНГЛИ ХЭЛ (Сурах бичиг)
- *МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ (ТУСГАЙ АНГИ) (С.Жанцан)
- *ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ (Д.Цолмон)

СОНИН СЭТГҮҮЛ

- "ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ" сэтгүүл
- "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" сэтгүүл
- "ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ" сонин

Сэтгүүлийн нэгдсэн зөвлөл

Хаяг: Улаанбаатар - 46, Үндэсний архивын газрын 206 тоот өрөө

Индекс - 14279

Утас: 322094, 315789, 315734

Факс: 976-11-322094,
976-11-315789

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ,
сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв